ХАЙРТ МОНГОЛ ОРНОО МАНДУУЛЬЯ!

ХИЛ СУДЛАЛ

ХСИС-ИЙН ХИЛИЙН СУРГУУЛЬ,
МОНГОЛЫН ХИЛ СУДЛАЛЫН АКАДЕМИЙН ОНОЛ-МЭДЭЭЛЛИЙН СЭТГҮҮЛ

19 ДЭХ ЖИЛДЭЭ УЛИРАЛД НЭГ УДАА ГАРНА

01-02/44-45
2016 он

АГУУЛГА

ХИЛ СУДЛАЛ-ОНОЛ ПРАКТИК

Д.Чойбаатар. Хилийн отрядад гэрээт хилчний албыг зохион байгуулсан үр дүн, цаашид анхаарах асуудал

Д.Баярсайхан. Хилийн аюулгүй байдал Монгол Улсын аюулгүй байдлын бүрэлдэхүүн болох нь

Д.Алтангэрэл. Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын үндэс, үзэл санаа

Б.Лувсанравдан. Аюулгүй байдал, түүний хувьсал өөрчлөлт ба хилийн аюулгүй байдал

Т.Нурлан. Уулын бүсийн физик газар зүйн онцлог хил хамгаалалтын удирдлага, зохион байгуулалтад нөлөөлөх нь

СУРГАЛТЫН ОНОЛ, АРГА ЗҮЙ

Ё.Хадхүү. Орчин үеийн багшийн хэв маяг, ёс зүй

Б.Мөнгөнбагана. Макаровын гар бууны онцлог

ЦЭРГИЙН СЭТГЭЛ СУДЛАЛ

Т.Баяраа. Хүндрэлтэй нөхцөл байдлын үе дэх хилчдийн сэтгэл зүйн бэлтгэл

ХИЛЧИН БА ХУУЛЬ

С.Оюунчимэг. Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын эрх зүйн мэдлэгийн хэрэгцээ, шаардлага, тулгамдаж буй зарим асуудал

Г.Лхагвамаа. Гэмт этгээдийн гэмт хэрэг үйлдсэний дараах зан байдал, түүний эрүүгийн эрх зүйн учир холбогдол

ХИЛИЙН ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Х.Асхар. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд хилийн хяналтын байгууллагуудын оролцоо

Г.Галбадрах. Хилийн боомтод гоц халдварт өвчний сэжиг

илэрсэн үед хил хяналтын байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ
Т.Баяраа. Тагнуулын үйл ажиллагаа

ХИЛИЙН ТҮҮХ

Ц.Ганболд. Монгол Улсын хилийн түүхийн судалгаанд Б.Цэдэн-Ишийн гүйцэтгэсэн үүрэг
Д.Бухбат. Хүйтэн дайны үеийн ахмад хилчдийн нийгмийн асуудал
Д.Жавхлант. Улсын хилийн аюулгүй байдлыг хангахад дипломатын аргыг хэрэглэж ирсэн түүхэн туршлага
Н.Алтанзул. Өнөөгийн дэлхий дахиныг өөрчилсөн Чингис хааны үйл ажиллагаа

ХИЛ СУДЛАЛ-ОНОЛ ПРАКТИК

ХИЛИЙН ОТРЯДАД ГЭРЭЭТ ХИЛЧНИЙ АЛБЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮР ДҮН, ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Д.Чойбаатар. Хилийн 0129 дүгээр ангийн захирагч, докторант, хурандаа



Агуулга:

1. Гэрээт хилчдийн алба хаасан байдалд хийсэн дүгнэлт

2. Гэрээт хилчдийн албыг боловсронгуй болгох талаар хийсэн ажил

3. Гэрээт хилчний албыг боловсронгуй болгох чиглэлээр цаашид анхаарах асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 194 дүгээр тогтоолоор "Цэргийн албыг сайн дурын үндсэн дээр гэрээгээр хаах" журам батлагдсан нь Хил хамгаалах байгууллагад гэрээт хилчний албыг зохион байгуулах эрх зүйн үндэс суурь тавигдсан гэж үздэг.

Манай анги 1933 оноос хойш Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа болсон улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах ариун үүргийг хугацаат цэргийн алба хаагчдын хүчээр гүйцэтгэж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд гэрээт хилчдийн хүчээр гүйцэтгэж, Хил хамгаалах байгууллагад гэрээт хилчний албыг нэвтрүүлэх эрхэм үүргийг хэрэгжүүлж байна. Тухайлбал: 2007 онд тус ангийн "Үзүүр ус"-ны заставыг хил хамгаалах байгууллагын хэмжээнд туршилтын журмаар "Гэрээт хилчин"-ий албанд шилжүүлж, гэрээт харуулын дарга, холбоочин, жолоочийн албан тушаалд иргэдийг анх удаа хил хамгаалах байгууллагад гэрээгээр алба хаалгаж эхэлсэн.

2010 оноос манай ангийн хилийн 9 заставт 208 гэрээт хилчдийг жолооч, холбоочин, сантехникийн слесарь, малчин, гэрээт хилчин албан тушаалд томилон алба хаалгаж, гэрээт хилчний албыг өргөжүүлэн зохион байгуулсан.

Энэ хугацаанд манай ангид алба хаасан гэрээт хилчид улсын хил зөрчсөн 4 удаагийн 4 хил зөрчигч, хил орчмын дэглэмийн 35 зөрчил, хариулгагүй бэлчээрээр хилд тулсан 33 удаагийн 2415 толгой малыг цаг тухайд нь илрүүлж, ард иргэдэд учирч болох 185 370 000 төгрөгний хохирлоос урьдчилан сэргийлж ажилласан байна.


Өнөөдрийн байдлаар манай ангийн хилийн 9 заставт гэрээт холбоочин, жолооч, сантехникийн слесарь, малчин, гэрээт хилчин гэсэн орон тоон дээр 150 гаруй гэрээт хилчин албаа амжилттай хааж байна.

Гэрээт хилчний албыг зохион

байгуулж эхэлснээс хойших хугацаанд тус ангид нийт 598 гэрээт хилчин алба хаагаад байна.


Нэг. Гэрээт хилчдийн алба хаасан байдалд хийсэн дүгнэлт

1.1. Орон нутгийн харъяалал




I эрээт хилчдиин орон нутгиин харъяаллаас дүгнэлт хиież үзэхэд 2010-2012 онд төв суурин газраас, 2013-2014 онд Говь-Алтай, Архангай, Ховд, Баян-Өлгий аймаг буюу баруун аймгуудаас түлхүү хамрагдсан үзүүлэлт харагдаж байна.

1.2. Гэрээт хилчдийн боловсролын түвшин



I боловсролтой байгаа нь гэрээт хилчдийн боловсролын түвшин өндөр байгааг харуулж байна.

1.3. Гэрээт хилчдийн сургалтын үр дүн



- Гэрээт хилчдээс Онлайнаар шалгалт өгч Солонгос улсад магистрын сургалтанд гэрээт хилчин М.Баасанбат, Австрали улсад Т.Балжинням нар суралцаж байна
- ХХБ-ын офицерын бүрэлдэхүүнд 2012 гэрээт хилчин б/ч Я.Батбаяр, 2013 онд гэрээт хилчин б/ч Д.Галдандагва, 2014 онд гэрээт хилчин б/ч Б.Төрболд нар дэвшин томилогдсоноос а/д Я.Батбаяр тус ангидаа хилийн заставын СМССЭО-оор ажиллаж байна.
- Гэрээт хилчдийг сургах мэргэшүүлэх чиглэлээр санаачлагатай ажилласны үр дүнд ОХУ-ын Курган, Калининград хотын ХЦ-ийн сургуульд 16, Хууль сахиулах их сургуулийн Хилийн албаны сургуульд 23 нийт 39 гэрээт хилчин суралцаж байна.
- Ахлагчийн бүрэлдэхүүнд 110 гэрээт хилчин орон хилийн ангиудад харуулын дарга, холбоочин, жолооч албан тушаалд ажиллаж байна.

Дээрх хоёр судалгаанаас үзэхэд гэрээт хилчдээр хил хамгаалах байгууллагын ирээдүйн боловсон хүчинг бэлтгэх бүрэн боломж байгаа эерэг давуу талууд харагдаж байна.

1.4. Гэрээт хилчдийн цалин хангамжийн байдал




Үндсэн цалин	ТТ-4-1	ТТ-4-2	ТТ-4-3	ТТ-4-4	ТТ-4-5
	430625	458761	485788	521489	536948
					ТТ-6-4
					541499

Гэрээт хилчид алба хаах хугацаандаа албан тушаалын зэрэглэлийн үндсэн цалин, хилийн, цолны, онцгой нөхцөлийн нэмэгдлүүд, шагнал, урамшууллыг хууль тогтоомжид заасны дагуу цаг тухайд нь хангагдаж байна.

Гэрээт хилчид өнөөдрийн байдлаар 600 000 төгрөгний дундаж цалинтай болж жил бүр цалин нь нэмэгдэж байгаа нь гэрээт хилчдийн алба хаах нөхцөл бүрдэж, хүсэл сонирхлыг нэмэгдүүлж байна.

1.5. Шагнал урамшуулалын байдал







2012 онд ХХЕГ-ын даргын тушаалаар Монгол улсын "Онц хилчин" тэмдгээр гэрээт хилчин А.Гэрэлчулуун, А.Даваабат, Э.Нэргүй, М.Амараа, Н.Тэрбиш, Н.Цогтбаяр, Б.Ганбат, Нэргүйбаатар, Отгонбаатар, С.Буянбат нар,


2013 онд Хил хамгаалах байгууллагын тэргүүн дээд шагнал "Сүлдэт багана"-ын эзнээр хилийн 3 дугаар заставын гэрээт хилчин түрүүч Г.Одгэрэл,

2014 онд Монголын залуучуудын холбооны "Тэргүүний залуу" алтан медалиар хилийн 4 дүгээр заставын гэрээт хилчин байлдагч М.Пүрэвжав,

"Хилчний алдар III" тэмдгээр 13, "Хил хамгаалалтад амжилт гаргасны төлөө"


тэмдгээр 19, "Хилийн төлөө" тэмдгээр 30, Ангийн 80 жилийн ойн тэмдгээр 57, ангийн захирагчийн тушаалаар давхардсан тоогоор 350 гаруй гэрээт хилчин тус тус шагнагдсан байгаа зэрэг нь гэрээт хилчид гэрээгээ сайн биелүүлж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргаж, албан үүргээ амжилттай гүйцэтгэж байгаагийн илэрхийлэл юм.

1.6. Гэрээт хилчдийн сахилга хариуцлага



Гэрээт хилчдийн сахилгын байдалд дүгнэлт хийж үзэхэд 105 буюу 17.5 хувь гэрээт хилчин амралт, чөлөөний хугацааг хүндэтгэх шалтгаангүйгээр хэтрүүлэн, ажил тасалсан, мэргэжил, ур чадвар, сахилга хариуцлагын хувьд албан тушаалдаа тэнцэхгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, цэргийн дүрмийн болон сахилгын зөрчил гаргасан, эрүүл мэндийн байдал болон өөрийн хүсэлтээр, ар гэрийн гачигдлын улмаас гэрээгээ цуцалсан зэрэг нь хойшид анхаарах сөрөг бөгөөд гол асуудлууд болж байна.

1.7. Гэрээт хилчдийн гэрээний биелэлт



Гэрээт хилчдийн алба хаасан байдалд дүгнэлт хийхэд гэрээт хилчдийн 71 хувь /424/ нь гэрээгээ дуусгаж цаашид ч гэрээгээ сунган үргэлжлүүлэн ажиллаж байгаа нь сайшаалтай байна.

Хоёр. Гэрээт хилчний албыг боловсронгуй болгох чиглэлээр хийсэн ажлууд



2012 онд манай бүтээлч хамт олноос "Гэрээт хилчний албыг боловсронгуй болгох", "Гэрээт хилчний албыг төгөлдөржүүлэх" зорилт дэвшүүлэн ажиллаж "Гэрээт хилчин – Гэрэлтэй алба" туршлага, сургамж, зөвлөмж, гарын авлага номыг боловсруулсан.

2014 онд тус ангийн шинжлэх ухаан технологийн салбар зөвлөлөөс "Гэрээт хилчний албыг боловсронгуй болгох нь" сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг ангийн албад, хилийн заставууд, ангийн офицеруудыг хамруулан зохион байгуулж "Гэрээт хилчний албыг боловсронгуй болгох" бодомж, төсөл гарын авлагыг шинэчлэн боловсруулж, албандаа мөрдөн ажиллаж байна. Үүнд: Хилийн бүх заставт гэрээт хилчдийн хэсэг байгуулж, тусгай өрөөтэй болгон, хэсгийн ажиллах журмыг боловсруулж, гэрээт хилчдийн амралтын өрөөнүүдийг нэг стандартад оруулсан.

Гэрээт хилчдийн ажил дүгнэх журмыг шинэчлэн боловсруулж, тэдний идэвх санаачлагыг өрнүүлж, ажлыг дүгнэж эхэлсэн нь үр дүнгээ өгч байна. Гэрээт хилчдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, тэднийг хөгжүүлэх зорилгоор хилийн заставуудыг "ВСАТ" системд холбон, IP утас суурилуулж өгснөөр өгөгдөл дамжуулах системээр хилийн отряд, заставын хооронд мэдээ, мэдээллийг шуурхай дамжуулж, хилийн заставын гэрээт хилчид интернетэд холбогдож дэлхий дахинд болсон цаг үеийн мэдээ мэдээллийг тухайн үед нь авах боломж нөхцлөөр хангагдсан. "Ном" аян өрнүүлж, гэрээт хилчид ээлжийн амралт чөлөөгөөр яваад ирэхдээ шинэ ном авч уншиж судлан, бие бүрэлдэхүүндээ мэдээлэл хийж, хилийн заставтаа хандивлаж оюуны хөрөнгө оруулалт хийж хэвшсэн. 2014 онд болсон ХХБ-ын тэргүүний офицеруудын зөвлөгөөний үеэр зохион байгуулагдсан "Улсын хил хамгаалалтыг боловсронгуй болгох нь" сэдэвт зөвлөгөөнд гэрээт хилчин хариуцсан ажилтан хошууч Б.Мэндсайхан "Мэргэшсэн гэрээт хилчдээр хил хамгаалах байгууллагын ирээдүйн боловсон хүчинг бэлтгэх" сэдвээр илтгэл тавьсан.

Манай ангиас Ар тал хангалтын дарга, дэд хурандаа Г.Батмөнх 2014 онд "Улсын хил хамгаалалтад гэрээт хилчдийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь", 2015 онд хилийн 1 дүгээр заставын дарга ахлах дэслэгч Т.Дэлгэрмөрөн "Гэрээт цэргийн албанд нөлөөлж байгаа хүчин зүйлсүүд" сэдвээр магистрын зэрэг хамгаалсан. Гэрээт хилчдийн албаны идэвх санаачлагыг өрнүүлэх, тэдний онолын мэдлэг, биеэр хийх дадлага чадварыг дээшлүүлэх зорилгоор 2014,

2015 онд ангийн хэмжээнд "Шилдэг гэрээт хилчин" тэмцээнийг зохион байгуулсан.

Гэрээт хилчдийг мэргэшүүлэх зорилгоор ХХЕГ-тай хамтарч ШУТИС-ийн Улаанбаатар хот дахь Политехникийн сургуулийн дэргэдэх сургалт үйлдвэрлэлийн төвийн сантехникийн анхан шатны сургалтанд 5, барилгын коллежид барилга, сантехникч мэргэжлээр 17, хилийн 0151 дүгээр ангид холбооны чиглэлээр 16, хөгжмийн чиглэлээр 10 гэрээт хилчин нийт 48 мэргэжилтэн сургасан.

Ангийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу жил бүр малчин, жолооч, сантехникийн слесарь, холбоочин, гэрээт хилчдийн хэсгийн дарга нар болон тэргүүний гэрээт хилчдийн цугларалтыг зохион байгуулж тусгай хөтөлбөрийн дагуу хичээл сургалт явуулснаар анги өөрөө 115 холбоочин, 129 жолооч, 92 сантехникийн слесарь бүгд 336 бага мэргэжилтнүүдийг бэлтгэсэн.

2014 онд Дорноговь аймгийн засаг даргын тамгын газрын 34 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар хилийн 2, 3 дугаар заставуудын "Төмөрт", "Хараат толгойн" хилийн харуулуудыг орчин үеийн шийдэл бүхий халуун ус, амралтын, унтлагын, гал зуухны өрөөтэйгөөр тохижуулсан.

2.1. Спорт, Урлагийн чиглэлээр:

2.1.1. Спортын чиглэлээр:

Хил хамгаалах байгууллагаас 2011 онд зохиогдсон "Хилчдийн спортын наадам"-ын "Гар бөмбөг"-ийн тэмцээнд гэрээт хилчин байлдагч Б.Энхзаяа, Д.Нямдорж, Л.Хатанбаатар, Э.Бадамсамбуу нар оролцож говь цөлийн бүсийн тэмцээнд тэргүүн байр.

"Сагсан бөмбөг"-ийн аварга шалгаруулах тэмцээнд гэрээт хилчин байлдагч М.Дөлгөөн, Б.Гантулга, Б.Баяржаргал, Р.Чаминчулуун нар бүсийн тэмцээнд дэд байр.

"Гар дээр суниалт"-ын тэмцээнд гэрээт хилчин байлдагч Б.Зинамадир оролцож бүсэд болон Хил хамгаалах байгууллагын хэмжээнд тэргүүн байр.

"Гэдэсний таталт"-ын тэмцээнд гэрээт хилчин байлдагч Г.Эрдэнэсайхан оролцож бүсийн тэмцээнд тэргүүн байр.

"Эрлийн бүлэг"-ийн тэмцээнд гэрээт хилчин дэд түрүүч Б.Гантулга, Г.Идэрнасан, байлдагч Г.Ганзориг, Буянтогтох нар оролцож бүсийн тэмцээнд дэд байр.

Хөнгөн атлетикийн тэмцээнд гэрээт хилчин Ч.Болдбаатар оролцож говь цөлийн бүсийн тэмцээн болон Хил хамгаалах байгууллагын хэмжээнд тэргүүн байр эзэлсэн зэрэг амжилтуудыг үзүүлсэн.

2012 онд болсон "Шилдэг гэрээт хилчин - 2012" тэмцээнд гэрээт хилчдээс 2 баг оролцож, 1, 3 дугаар байранд орж хувийн дүнгээр гэрээт хилчин байлдагч О.Мөнхдэлгэр 1, гэрээт хилчин байлдагч Г.Эрдэнэсайхан 2 дугаар байруудыг эзэлж ОХУ-д сургуульд суралцах эрхээр шагнуулан амжилттай суралцаж байна.

2014 онд болсон Хил хамгаалах байгууллагын "Марш тактикийн аварга салаа, тасаг" шалгаруулах тэмцээнд гэрээт хилчин Б.Батсайхан, С.Ганцоож, Д.Уранболд, Г.Эрхэмзаяа, Э.Энх-Эрдэнэ, Б.Баасанбат, Т.Амартүвшин нарын 7 гэрээт хилчин оролцож өмнөд бүсийн тэмцээнд "Тэргүүн" байр, хил хамгаалах байгууллагын хэмжээнд "Дэд" байрт шалгарсан.

2014 онд Дорноговь аймагт зохион байгуулагдсан "Дорноговь бага олимп" тэмцээнд хилийн 2 дугаар заставын гэрээт хилчин байлдагч Н.Дамдинсүрэн, хилийн 4 дүгээр заставын гэрээт хилчин Х.Хашчулуун, хилийн 5 дугаар заставын гэрээт хилчин байлдагч Т.Жангарбаатар нар "Сагсан бөмбөг", "Олс таталт"-ын тэмцээнд оролцож, багаараа "Тэргүүн" байранд шалгарсан.

2015 онд Хил хамгаалах байгууллагын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа "Шилдэг гэрээт хилчин" шалгаруулах тэмцээний өмнөд бүсийн аварга шалгаруулах тэмцээнд гэрээт хилчин байлдагч Д.Уранболд "Тэргүүн" байр, хилийн 5 дугаар заставын гэрээт хилчин түрүүч Т.Жангарбаатар "Дэд" байр, хилийн 3 дугаар заставын гэрээт хилчин байлдагч Т.Амартүвшин "Гутгаар" байр, хилийн 7 дугаар заставын гэрээт хилчин байлдагч Д.Баярмагнай "Тавдугаар" байруудыг эзлэн III шатны хил хамгаалах байгууллагын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ аваад байна.

2.1.2. Урлагийн чиглэлээр

2010, 2012, 2013, 2014 онд болсон Хилчдийн урлагийн наадам, ХХБ, Анги, Дорноговь аймгийн 80 жилийн ойд баярын жагсаал, морин бэлтгэлийн үзүүлэх тоглолт, БНЭУ-ын хилчдийн төлөөлөгчдийг айлчлахад жагсаалын зэвсэгтэй ажиллагаа болон гардан тулааны үзүүлэх тоглолт, бөхийн үзүүлэх барилдаан, сур харвах, эмнэг сургах, морь уургалах, бугуйлдах зэрэг үзүүлбэрүүдийг гэрээт хилчид үзүүлж, албаны ур чадвараа орон нутгийн удирдлага, ард иргэдэд үзүүлж сурталчилсан.

2. Гэрээт хилчний албыг сурталчлах ажлын хүрээнд:

2010, 2011, 2012 онд МҮОНТ-тэй хамтран "Дархан хилийн манаанд", "Нар тоссон хилийн заставын наадам", "Эрх зүйн хөтөч" зэрэг нэвтрүүлгүүд

"MN-25" суваг телевизтэй хамтран "Танайд хоноё", "Сэтгүүлч гэрээт хилчний албанд",

"BTV" телевизтэй хамтран "Цэргийн хорооны наадам", "Эх орныхоо төлөө зүтгэе",

"NTV" телевизтэй хамтран "Ганаа мэргэжлээ сольсон нь",

"ETV" телевизтэй хамтран "Сүлдэт баганын дэргэд", "Дархан хил тайван байна" хилчдийн шинэ жилийн нэвтрүүлэг

Дорноговь аймгийн "BSB" телевизтэй хамтран "Шилдэг ахлагч", "Шилдэг гэрээт хилчин" шалгаруулах тэмцээний бичлэгийг хийж, гэрээт хилчний албыг сурталчилсан.

Зууны мэдээ сонинд "Хилийн заставт хавар ирлээ", Өдрийн сонинд "Эх орны амар амгалангийн босго" нийтлэлүүдийг бичсэн.

Гурав: Гэрээт хилчний албыг боловсронгуй болгох чиглэлээр цаашид анхаарах асуудал

1. Хугацаат цэргийн албыг гүйцэд хаасны дараа гэрээт хилчний албанд сонгон шалгаруулж авдаг журмыг баримталж ажиллахгүй бол цэргийн албыг 8 сар хаагаад гэрээт хилчний албанд ирж 6-7 сар болоод гэрээ цуцлах сонирхол их байгаа нь "Гэрээт хилчний алба хаах журам"-ын 10-ын 5 дугаар заалт буюу хугацаат цэргийн албыг 8 сараас доошгүй хугацаагаар алба хааж гэрээт хилчний албанд ороод 4 сарын

дотор гэрээ цуцлагдах тохиолдолд гэрээт хилчний албанд ажилласан төлбөрийг буцаан төлүүлнэ гэсэн заалтыг өөрчлөх шаардлагатай байгаа нь нотлогдож байна.

2. "Гэрээт хилчний алба хаах журам"-д заасны дагуу "Гэрээт хилчин" гэсэн нэр томьёог хил хамгаалах байгууллагын хэмжээнд хэрэглэх.

/гэрээт цэрэг гэх нэршил давхар хэрэглэгдэж байна/

3. Гэрээт хилчдийг төрөл мэргэжлийн гүнзгийрүүлсэн тусгай сургалтанд хамруулж, мэргэжлийн чадварлаг гэрээт хилчин бэлтгэх.

/Жолооч, сантехникч, холбоочдыг дахин сургаж цаг алдаж байна/

4. ХСИС-ийн хичээлийн программд гэрээт хилчдэд зориулан тусгай хөтөлбөр тусгуулах.

5. Гэрээт хилчдэд цэргийн мэргэжлийн зэрэг олгох, энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх.

6. Гэрээт хилчний алба хаасан хугацааг 5 жилийн урамшуулалд оруулах

7. Хоёр жилийн хугацаанд гэрээгээр алба хаагаад гэрээгээ сунгасан тохиолдолд гэрээт хилчдийн цалингийн шатлалыг нэмэгдүүлж харуулын даргын хэмжээнд цалинжуулах /2015 оны 04 дүгээр сард гэрээ дуусан Баян-Өлгий аймгийн харъяат гэрээт хилчин байлдагч К.Болатбек гэрээгээ 1 жилээр сунгасныг ТТ-6-4 шатлалаар цалинжуулан ажиллаж байна/

8. Гэрээт хилчдийг байгуулсан гэрээний 50-иас дээш хувь буюу 1 жилийн хугацаанд гэрээгээ амжилттай биелүүлсэн тэргүүний гэрээт хилчдийг тухайн анги байгууллага хил хамгаалах байгууллагын удирдлагад уламжилснаар ХСИС-ийн Хилийн албаны сургуульд урилгаар суралцуулдаг болгох.

9. Гэрээний үүргээ биелүүлээгүй ажил тасалж хаяж явсан гэрээт хилчдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх, хадгаламжин дахь мөнгийг анги байгууллага эргүүлэн татан авдаг журмыг хэрэгжүүлэх.

10. Иргэний их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг Хил хамгаалах байгууллагад шаардлагатай мэргэжлээр /хүний эмч, малын эмч, холбоо, компьютер, техник, сантехник, барилгын инженер/ төгссөн дээд боловсролтой иргэдийг гэрээт хилчний албанд элсүүлэн авч гэрээний хугацаа дуусахаар мэргэжлээр нь авч ажиллуулан офицер, ахлагч болгох.

11. Гэрээт хилчний албаны талаар Хил хамгаалах байгууллагын судлаачид, эрдэмтэн, докторуудыг манай ангийг түшиглэн судалгааны ажил хийлгэж, бодит үр дүнг хэрэгжүүлэх.

12. Хил хамгаалах байгууллагын ирээдүйн боловсон хүчин бэлтгэх суурь бааз болсон гэрээт хилчний албыг өргөжүүлж, төгөлдөржүүлэхийн тулд ХХЕГ-ын ЦСАЗБ-ын хэлтэс, гэрээт хилчний албанд бүрэн шилжсэн хилийн отрядуудад гэрээт хилчин хариуцсан алба, хилийн заставт гэрээт хилчдийг хариуцсан орлогч зэрэг орон тоог бий болговол гэрээт хилчдийн албаны мэдлэг, дадлага, чадварыг дээшлүүлж, эзэнтэй болж, гэрээт хилчний алба улам боловсронгуй болгоход тодорхой түлхэц болно гэдэгт итгэж байгаагаа илэрхийлж, гэрээт хилчний алба гэрэлтэй байхын өлзийтэй ерөөлийг дэвшүүлье.

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОХ НЬ

Д.Баярсайхан. Хилийн сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдлын тэнхимийн эрхлэгч, докторант, дэд хурандаа



Монгол Улс оршин тогтносон 2200 гаруй жилийн хугацаанд хил, хязгаарын төлөө явуулсан тэмцлийн түүхийг харахад Монгол Улсад тал бүрээс учирч байсан аюул занал нь түүнийг хүн төрөлхтөний түүхийн тавцангаас зайлуулах, нутаг дэвсгэрийг нь эзэмших, эс чадваас хил орчмын тодорхой газар нутгийг таслаж авах зорилго, чиглэлтэй явагдаж иржээ. Хүн ам цөөн, газар нутаг өргөн уудам, нийгэм эдийн засгийн хөгжлөөр харьцангуй сул өнөөгийн нөхцөлд өөрийн аюулгүй байдлыг хангахад нэн тэргүүнд улсын хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдүүлэхийг өнгөрсөн үеийн түүхэн сургамж харуулж байна.

Аливаа улс орон улсынхаа хилийг бодит байдлаар болон олон улсын эрх зүйгээр баталгаажуулдаг. Олон улсын эрх зүйгээр баталгаажсан хил нь тухайн улсын тусгаар тогтнолын бат илэрхийлэл мөн боловч түүний аюулгүй байдал нь бүрэн дүүрэн хангагдсан гэсэн ойлголт хараахан биш юм. Хөрш зэргэлдээ улс орнуудын улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан хүн ам зүйн түрэмгийлэл үйлдэгдэж болзошгүй, хилийн зурвас, боомт бүхий газруудад хоёр улсын иргэд хоорондын маргаантай асуудлууд мөн хил орчмын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй байгууллага, иргэдийн зөрчилдөөнөөс болж зэвсэгт мөргөлдөөн, хил дамнасан хар тамхи, мансууруулах бодис, хүний болон эд, эрхтний худалдаа, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх зэрэг хандлагууд ажиглагдаж байна. Хил нь аливаа /обьект/-г зааглах, цаг хугацаа үйл явцын эхлэл төгсгөлийн хязгаар зэргийн тухай ойлголт бүхий философийн ухагдахуун болно.

Монгол Улс нь Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай улсын хилийн асуудлыг XX зууны сүүлийн хагаст бүрэн шийдвэрлэж, баталгаажилтыг нь хүлээн зөвшөөрсөн, олон улсын эрх зүйн үндэс бүрдсэн. цаашид тогтоон тэмдэглэж, баталгаажуулсан хилийг өөрчлөхгүй, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн манах, хамгаалах ажиллагааг улам боловсронгуй болгох нь манай хил хамгаалах байгууллагын үндсэн үүрэг болж байна. Ер нь улсын хилийг хамгаалах асуудлыг зөвхөн хилийн шугам, бүс, зурваст хил хамгаалах байгууллагаас хэрэгжүүлдэг арга

хэмжээ болгон хуульчилсан нь өнөөгийн шаардлагад нийцэхгүй байна.

Улсын хилийг янз бүрээр тодорхойлж ирсэн, ихэвчлэн улс орны газар нутгийн зах хязгаарыг зааглasан шугам гэсэн агуулгаар авч үзсэн байдаг. Энэ нь нутаг дэвсгэрийн бүрэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд шаардлагатай чухал ойлголт гэдгийг хэн ч үгүйсгэх аргагүй юм.

Гэвч бие даасан улс байж үндэснийхээ эрх ашиг, тусгаар тогтнолыг нийгмийн амьдралын бүхий л салбарт хамгаалахад дээрх ойлголт тэр бүр хангалттай биш байна. Улс үндэстний язгуур ашиг сонирхол нь улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, шинжлэх ухаан, техник, цэрэг, байгаль орчны бүх салбарт хамгаалагдаж байж тухайн улсын тусгаар тогтнол баталгаатай хангагдана.

Улсын хил, хязгаар нутгийн хөгжил, аюулгүй байдлын асуудлаар төр, засаг, байгууллага, иргэдээс явуулж байгаа үйл ажиллагааг хилийн үйл ажиллагаа гэнэ.

Энэ нь хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх салбарт үйл ажиллагаа явуулж байгаа субьектуудын гүйцэтгэх үүрэг чиг хандлагыг тодорхойлоход чухал ач холбогдолтой ойлголт юм. Үүнтэй холбогдуулан хилийн аюулгүй байдал гэсэн ойлголт гарч ирнэ.

Эх үүсвэр нь хаана байгаагаас хамаарааd аюулгүй байдлыг дотоод, гадаад гэж ангилдаг билээ. Ийнхүү гадаад аюулгүй байдал нь дотоодоосоо улс хоорондын газар нутгийн хилээр зааглагддаг аж. Даяаршлын одоогийн орчинд гадаад, дотоод аюулгүй байдлын зааг ялгаа нилээдгүй бүдгэрч байна. Улсууд хоорондоо хил залган, янз бүрийн параметр /юмны гол шинжийг заасан хэмжээс/ бүхий тогтолцоо, тэр дундаа янз янзын /ихэнхдээ эсрэг, тэсрэг/ ашиг сонирхлыг бүрдүүлж байдаг байна.

Физик бүтцийн талаас л гэхэд дээрх тогтолцоонуудыг салган зааглasан эмзэг орчин болох хилийн давхраа үүсэн гарч ирдэг. Нийгэм улс төрийн тогтолцооны хувьд хилийн орчин тийм давхраа нь болдог. Хилийн аюулгүй байдлын тухай ярихад, хил залгаа улсуудын гадаад, дотоод аюул занал хамгийн ихээр сүлжилдсэн, хилийн орчны аюулгүй байдал юун түрүүнд хөндөгдөнө. Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн болох хилийн аюулгүй байдал гэдэг нь: хилийн хүрээнд үүсэх дотоод, гадаад шинжтэй аюул заналыг зайлуулан, улс хоорондын харилцаанд таатай уур амьсгал бүрдүүлж, төр, нийгэм, хувь хүмүүсийн амин чухал эрх ашгийг хилийн хүрээнд хамгаалах явдал юм. Тийм бүрдэл бол улс орны газар нутгийг зааглasан улсын хилийн шугам юм. Хил гэдгийг улс төрийн талаас нь үндэсний тусгаар тогтнолд хамааралтай орон зайг тусгаарласан хүрээ хязгаарыг хэлдэг.

Америкийн онолч Н.Спайкменийн тодорхойлсноор хил, геополитикийн хувьд << үндэстнийг нэгтгэхэд түлхэн чиглүүлдэг, төвлөрүүлэгч хүчирхэг элемент, нэгэн төрлийн бэлэг тэмдэг>> болдог байна. Эндээс үзвэл хил гэдэг бол улс орнуудын нутаг дэвсгэрийг тусгаарлаад механикаар тэмдэглэчихсэн зүгээр нэг шугам биш нь харагдана. Энэ бол улс орны аюулгүй байдал, амьдрах нөхцөлийг хангаж өгдөг амин чухал

хүчин зүйлүүдийн нэг нь юм. Тэр нь үндэстний адил чанар, өөрийн ухамсар бүрдэх оршиц газрыг хэлдэг байна. Улс орон хил хязгаарынхаа халдашгүй дархан байдлыг хамгаалах чадвар бол, түүний олон улсын хүрээнд эзлэх нэр хүнд, сүр хүчний илэрхийлэл юм.

Түүхэн туршлагаас үзвэл хилгүй болж төвтэйгээ холбоо харилцаа сулран, хил орчимд маргаан будлиан үүссэнээс улс гүрнүүдийн задрал эхэлсэн байх нь харагддаг. Чухамдаа иймэрхүү асуудлууд л Ромын империйг унагаж, XX зууны эхэнд Австри-Унгарыг, эцэст ЗХУ-ыг задралд хүргэсэн байдаг.

Үндэсний аюулгүй байдал, тэр дундаа хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны үүрэг, бүтцийг тодорхойлдог болохоор улсын хилийн үндсэн үүргийг онцлон үзэх нь зүйтэй. Салган тусгаарлах, залган нийлүүлэх хоёр бол нийтлэг үүргүүд нь юм. Олон улсын эрх зүй, дотоодын хууль тогтоомж дээр үндэслэн эдгээр үүргүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл боломжийг төр бүрдүүлж өгөх үүрэгтэй. Энд л хүчний векторууд уулзалдаж, улс бүрийн үндэсний ашиг сонирхол сүлэлдэж байдаг. Иймээс улс, үндэстний ашиг сонирхол зөрчигдөж, тусгаар тогтнол хумигдан, газар нутгийн бүрэн бүтэн байдал, улс төр, эдийн засаг, соёлын бие даасан байдал алдагдах явдалтай хийх тэмцлээр анхдагч үүргийн хэрэгжилт хангагдана. Хоёрдогч үүрэг нь эсрэгээрээ, бүс нутгийн болоод дэлхийн эдийн засаг, улс төрийн бүтцүүдийн хөгжлийн хандлагыг тооцоолж, олон улсын харилцааны нөхцөлд улс орнууд хэр зэрэг эрэмбэ дараатай "орж байгаа"-д зохицуулан үндэснийхээ хэрэгцээ шаардлагыг хангах явдал юм.

Миний хувийн бодлоор эдгээрээс гадна төр улсын бүрэн бүтэн байдал, иргэншлийг хадгалах гэсэн, төр засагт төдийлөн анхаарагддаггүй өөр хоёр үүрэг байна гэж үздэг. Анхдагч үүрэг нь, үндэстэн голлох, нэгтгэн зангидах үүрэгтэй ч гэлээ, Монгол улс дэлхийн бусад хөгжингүй орнуудын адил "үндэстний улс" болж чадаагүй байгаатай холбоотой юм.

Ийм учраас орон нутгийн хийгээд үндэстний газар нутгийн салан тусгаарлах үзлийн аюул занал хадгалагдсаар байна. Энэ үүргийг хэрэгжүүлэх нь төр, нийгмийн хэрэг ч гэлээ улсын хил энд, "өргөмжлөгдсөн угсаатны улсууд"-аас, нийгэм соёлын олонлог бүхий улс болгон субъектүүдийг хилийн хүрээнд багтаан бүрэлдүүлэх холбоос шижим болон гарч ирнэ гэсэн үг. Энэ утгаараа засаг захиргаа-орон нутгийн байдлаар хилийг хамгаалах гэдэг томоохон эндүүрэл юм.

Хилийн орон зайд үндэсний голлох ашиг сонирхол нь эдийн засгийн салбарт, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд, хар тамхины наймаа, зэвсэг, галт хэрэгсэл, түүхий эд материалын нөөцийн худалдаа, хууль бус загасчлал, байгаль орчныг сүйтгэх, терроризмтэй тэмцэх хүрээнд оршиж байна.

Үүнээс үндэслэн хилийн аюулгүй байдлыг төр, нийгмийн амьдрал, үйл ажиллагааны хүрээгээр нь нийгэм улс төрийн, эдийн засгийн, цэргийн, хилийн аюулгүй байдал гэж хуваж болно. Дээр дурдагдсан хилийн аюулгүй байдлын талаарх тодорхойлолтыг хилийн орон зайд төр, нийгэм, хувь хүмүүсийн ашиг сонирхолд аюул учраагүй байх явдал гэж бас тайлбарлаж болно.

Хилийн аюулгүй байдлыг хангах цэргийн болоод оперативын аргуудын хооронд хүчний тэнцвэр шаардагддагаас, улс орнуудын ашиг сонирхлын зөрчилдөөнөөс болоод аюул заналыг бүрэн арилгах боломж байдаггүй. Иймээс улсын хил хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, хүч хэрэглээр хангах аль нэгэн хувилбарыг эхлүүлэх, хилийн үйл ажиллагааны тухайн салбарт ялгавартай, системийн хандлага хэрэгтэй юм.

Хүчний тэнцвэр, тогтвортой байдал, тайван амгалангийн тулгуур багана болох хүртэл, зэвсэгт тэмцлийн хэрэглүүдийн хөгжлөөс хамааралгүйгээр аюулгүй хилийн асуудал ач холбогдлоо алдахгүй. Хэдийгээр зэвсэгт тэмцлийн хэрэглүүд хөгжөөд орчин цагийн байлдааны хөнөөх хэрэгсэл /мэдээллийн зэвсэг, пуужингийн зэвсэг, нисэх хүчин/ ашиглаж, хил, хязгаар нутгаар халдлага, түрэмгийлэл үйлдэхэд бүх хилийг "хаалт, саадгүй" болгосноор, тийм төрлийн аюулыг зэвсгийн хүчээр устгах тэр улсын боломж, хилээ хамгаалах чадвар хамгаас чухал хэвээр байна.

Мэдээжийн хэрэг, хилийн аюулгүй байдлын хангалт, зорилго чиглэлтэй бусад үйл ажиллагааны нэгэн адил, зохих шинжлэх ухааны бааз суурь, салбар шинжлэх ухаанд тулгуурлах ёстой бөгөөд тэр нь цогцолбор шинжлэх ухаан-хил судлал юм. Хил судлал өөрийн гэсэн онцлогтой дараах үүргүүдийг гүйцэтгэнэ.

- Онол-хөтөлбөрийн үүрэг /хилийн аюулгүй байдал, хилийн харилцаа, хилийн үйл ажиллагааны үзэл баримтлалуудад үндэслэл боловсруулах/
- Тохируулга - нормативын үүрэг /хилийн харилцаа, хилийн үйл ажиллагааны эрх зүйн хангалт/
- Төлөвлөлт-дүн шинжилгээний үүрэг /хилийн орон зай дахь ашиг сонирхол, аюул занал, тэдгээрийг саармагжуулах арга хэрэгслүүдийн үнэлгээ, дүн шинжилгээ/
- Удирдлага-зохион байгуулалтын үүрэг /хилийн үйл ажиллагааны амьдрал, практик/ Хил бол геополитикийн бодит байдал, геополитикийн зорилго, геополитикийн хэрэгслийн аль алиныг агуулна. Хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн хэрэгслүүд /геополитикийн хэрэгсэл болохын хувьд/-ийн нэг нь хилийн бодлого юм.

Хилийн аюулгүй байдлыг хангах хүрээнд баримтлах хилийн бодлогын үндсэн үүргүүд бол:

- Тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, түүний орон зайн аюулгүй байдлыг хангах
- Хилийн аюулгүй байдлын дотоод, гадаад аюулыг илрүүлэх, цаг тухайд нь урьдчилсан дүгнэлт гаргах
- Дотоод болон гадаад аюулаас урьдчилан сэргийлэх, саармагжуулах оператив, цэргийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх
- Хилийн боомт, хил орчмын бүс нутгийн эдийн засгийн хөгжил, амьдрал үйл ажиллагааг дэмжих, нийгмийн чиглэлтэй бие даасан эдийн засгийн бодлого явуулах, эдийн засгийг хөгжүүлэх
- Иргэдийн аюулгүй байдал, үндсэн хуулийн эрх, эрх чөлөөг хилийн орон зайд хангах
- Үндэстнүүдийн хоорондын эв нэгдлийг ханган, хууль ёсыг бэхжүүлж,

хилийн орон зайд нийгэм улс төрийн тогтвортой байдлыг хадгалж, хууль тогтоомж, нутгийн захиргааны тогтолцоог боловсронгуй болгох

- Хил залгаа улсуудтайгаа эрх тэгш, харилцан ашигтай, хамтын ажиллагаа тогтоох
- Төр улсын хориглон хамгаалалтын нэгдүгээр цувраа болохын нь хувьд хил хамгаалах албаны цэргийн чадавхийг хангалттай хэмжээнд барьж байх
- Монгол Улсын эсрэг чиглэсэн гадаад орнуудын тагнан турших, хорлон сүйтгэх үйл ажиллагааг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үр дүнтэй арга хэмжээ авах
- Хилийн орон зай дахь байгаль орчны нөхцөл байдлыг үндсээр нь сайжруулах
- Хилийн хүрээн дэх гэмт хэрэг, авлигатай тэмцэхэд чиглэсэн хүчин чармайлтыг нэгтгэх
- Хилийн хүрээнд гүйцэтгэх засаглалын байгууллагуудын үйл ажиллагааг журамлаж, эрх үүргийг тодорхойлох норматив, эрх зүйн баазыг буй болгох
- Хил залгаа улсуудаас улсын хил, олон улсын эрх зүйн орчинг бүрдүүлэх ажиллагааг идэвхижүүлэх
- Улс хоорондын хилийн орон зайг хөгжүүлэх
- Хил залгаа улсын зүгээс нутаг дэвсгэрт хийгдэх эдийн засаг, хүн ам, шашин, соёлын түрэмгийллийн эсрэг арга хэмжээ авах
- Материалын үнэт зүйлс, хар тамхи, зэвсэг, байгалийн нөөцийг хулгайлан хууль бусаар хил давуулах, үндэстэн дамжсан зохион байгуулалттай гэмт хэрэг, хууль бус цагаачлалыг таслан зогсоох
- Хил судлалын салбарт хийгдэж буй үр дүнтэй шинжлэх ухааны судалгаанууд, байгуулагдаж буй эрх зүйн ардчилсан институцүүд, бүрэлдэн буй болж байгаа төрийн захиргааны байгууллагууд, үндэсний болоод хилийн аюулгүй байдлыг хэрэгжүүлэхэд улс төрийн намууд, олон нийтийн байгууллагуудын өргөн оролцоо 21 дүгээр зуунд Монгол улсын бие даасан, аюулгүй, эрчимтэй хөгжлийн баталгаа болж байна.

ТӨРӨӨС ХИЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ҮНДЭС, ҮЗЭЛ САНАА

Д.Алтангэрэл. Хилийн сургуулийн Хилийн албаны тэнхимийн ахлах багш, докторант, хошууч



Монгол улс дэлхий нийтийн хөгжлийн ерөнхий чиг хандлагын дагуу зах зээлийн эдийн засгийг хөгжүүлж, ардчиллын замыг сонгосноор манай улсын гадаад бодлогын үзэл баримтлал өөрчлөгдсөн нь улсын хил, түүний хамгаалалтын асуудалд шууд нөлөөлөх болсон билээ.

Социалист системд багтаж байх үед манай улс БНХАУ-ыг "болзошгүй дайсан" хэмээн үзэж уг улстай хил залгаа хилийн хэсгийн хамгаалалтыг бэхжүүлж харьцангуй их хэмжээний хүч хэрэгслийг өмнөд хилд төвлөрүүлэн, хамгаалалт зохион байгуулж байсан бол ЗХУ-тай хил залгаа хойд хилээ "найрамдлын хил" хэмээн нэрлэж хамгаалалтгүй шахам байлгаж байсан болно.

Энэ үед хил хамгаалалт нь:

-Улсын хилийг сэргийлэн манаж, хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хил залгаа улстай хилийн асуудлаар байгуулсан гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй Хилийн цэрэг,

-Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах, хориглон хамгаалах үүрэгтэй Зөвлөлт Холбоот Улсын болон Монголын Ардын Армийн анги нэгтгэлүүд, НАХЯ-ны харъяа аймгуудын АХГазар, хэлтэс, Гүйцэтгэх ажлын хүч хэрэгсэл,

-Хориглон хамгаалалтын үүрэгтэй ЗХУ-ын болон Монголын Ардын цэргийн анги нэгтгэлүүд,

-Хил залгаа улсын зүгээс явуулж болзошгүй аливаа өдөөн хатгалга, зэвсэгт халдлага, түрэмгийллээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй Армийн болон НАХЯ-ны тагнуулын хүч хэрэгслээр явагддаг бүхэл бүтэн тогтолцоо, цогц арга хэмжээ байлаа. Гадаад бодлогын үзэл баримтлалын дагуу олон улсын эрх зүйн нийтлэг зарчмыг үндэслэн дэлхийн бүх улс орон түүний дотор хил залгаа орших БНХАУ, ОХУ-тай НҮБ-ын дүрмийн хэмжээнд харилцаагаа хөгжүүлэх зорилт дэвшүүлснээр дээрхи тогтолцоо устаж, улсын хилийг нийтэд нь хамгаалалттай болгох, хил орчмын нутагт үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалах, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах үүргийг зөвхөн өөрийн хүчээр шийдвэрлэх зорилт улс орны өмнө тавигдаж байжээ.

Хуучин тогтолцооны орон зай онгойсон энэ үед хил хамгаалалтыг зөвхөн өмнөд хилийн 4676.9 километрт

биш нийт хилийн 8252.6 километрт зохион байгуулж явуулах үүргийг цорын ганц Хилийн цэрэг үүрэх болсон боловч түүнд тагнуул явуулах, хил хамгаалалтанд оролцогч бусад хүч хэрэгсэл, төрийн болоод орон нутгийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зангидах эрх олгогдоогүйгээс гадна өөрийн нь харъяалал хаана байх нь тодорхойгүй байгууллага болж хувирсан юм.

Гэтэл зах зээлийн харилцааны сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд улс орны гадаад харилцаа нээлттэй болохын зэрэгцээ иргэд, аж ахуйн байгууллагууд хил залгаа улсын иргэд, байгууллагатай чөлөөтэй харьцах болсон бөгөөд зарим тохиолдолд тэдний зүгээс хууль бус ажиллагааг хамтран үйлдэх, хилийн шинэ шинэ төрлийн зөрчил, тухайлбал, суудлын автомашин, ноолуур, мансууруулах бодис, спирт, хүн хууль бусаар улсын хил нэвтрүүлэх, улмаар зохион байгуулалттай хэлбэрт шилжих болсон, цаашид энэ байдал улам даамжрах хандлагатай байна.

Түүнчлэн улсын хил зөрчин ан амьтан, байгалийн баялаг хулгайгаар ашиглах, хил орчмын иргэдийн малыг хулгайлах, дээрэмдэх энэ явцдаа хилчид, иргэдийн эсрэг зэвсэг, хүч хэрэглэн, тэдний амь нас, эрүүл мэндийг хохироох явдал гарах боллоо.

Энэ байдал нь зарим талаар хил орчмын нутаг эзэнгүйдэх шалтаг болж, тэндээс хүн ам олноор нүүдэллэн төв суурин газарт шилжих болсон нь хил орчмын үржил шимтэй стратегийн ач холбогдол бүхий газар нутгийг хил залгаа улсын зүгээс хулгайгаар ашиглах, хилд тулж нутаглах (Дорнодын Халхгол сумын Хянганы нурууны хэсэг, Увс, Завхан аймгийн зарим сумдын нутаг гэх мэт) боломж олгох, алсдаа хилийн редемаркаци явуулахад хөрш орны талд ашигтай байдлаар эргэх хандлагад хүргэж болзошгүй байдалд хүргэсэн байна.

Хил хамгаалалт гэдэг ухагдахуун нь:

- улсын хилийг арчлан хамгаалах;
- улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах;
- хил орчмын нутагт үндэсний язгуур эрх ашгийг хамгаалах;
- улсын хил дээр зэвсэгт халдлага, түрэмгийлэл үйлдэгдсэн үед хориглон хамгаалалтад оролцох зэрэг үйл ажиллагааг хамардаг өргөн хүрээтэй ойлголт байдаг.

Гэтэл энэ бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүргийг төрийн захиргааны төв болон орон нутгийн засаг захиргааны байгууллага, иргэд хилийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн баталсан журам, Засгийн газрын тогтоолын дагуу хүлээдэг боловч тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, чиглүүлэх тогтолцооны систем бүрэлдэн тогтоогүйгээс тус тусын чиг мөрийг хөөсөн салангид ажиллагаа болон хувирч завсраас нь хилийн зөрчил гаргаж гэмт хэрэг үйлдэгчид завших боломж гарч, энэ зай завсрыг хууль зөрчигчид нарийн сайн ойлгон байнга ашиглаж байдаг гэхэд хилсдэхгүй байдалд хүрээд байна. Тэгвэл өнөөдөр улсын хил хамгаалалт гэдгийг зөвхөн улсын хилийн шугамыг сэргийлэн манах цэргийн ажиллагаа мэтээр ойлгож, хил хамгаалах байгууллага /хилийн цэрэг/ дангаараа хэрэгжүүлэх үүрэгтэй гэж үзэх үзэл түгээмэл болжээ.

Улсын хил хамгаалалтын үндсэн хүч хэрэгсэл нь хил хамгаалах байгууллага /хилийн цэрэг/ боловч хилийн тухай хуулиар хил хамгаалалтад оролцох үүрэгтэй төрийн яам, газар, аймаг, сумын засаг дарга, түүний тамгын газар, иргэдэд хил хамгаалалтын эрх ашигт нийцсэн үүрэг чиглэл өгөх, тэднийг хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг шаардах, үйл ажиллагааг нь зохицуулан уялдуулах эрх хил хамгаалах байгууллагад олгогдоогүй, энэ чиглэлийн зохицуулалт хийх байгууллага байхгүй зэрэг нь хүндрэл учруулж байна. Байдал цаашид ийм янзаар удаан үргэлжилбэл Үндэсний аюулгүй байдалд ноцтой хор хохирол учруулахуйц бодит болон болзошгүй хүчин зүйлс улам бүр нэмэгдэх хандлагатай байгаа тул улсын хил, түүний хамгаалалт, хил орчмын нутагт үндэсний эрх ашгийг хамгаалах асуудалд огт өөрөөр хандаж "Төрөөс хилийн талаар баримтлах бодлого" боловсруулан баталж мөрдөх шаардлагатай болжээ.

Нөгөө талаас хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын хилийн тухай хууль тогтоомжийн үзэл санаа нь улсын хил хамгаалалтад иргэд, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, хууль болон хил хяналтын байгууллага, төрийн захиргааны төв байгууллагуудын хүч оролцоог аль болох өргөн ашиглан Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлын нэг болох тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй байдлыг хангахад чиглэгдсэн билээ.

Гэтэл эдгээр байгууллагууд өөр өөрийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гарч, хэрэгжиж байгаа хууль, эрхийн актуудыг өөрсдийн байгууллагуудын хууль мэт ойлгодог тогтсон буруу зуршлаас шалтгаалан үйл ажиллагаагаа хил хамгаалалтын эрх ашигт уялдан зангидагддаггүй, тийм эрх зүйн орчин төдийлөн бүрэлдэн тогтоогүй байгаагаас улсын хил хамгаалалт гэдэг нь улсын хилийг сэргийлэн манаж байгаа дан ганц цэргийн ажиллагаа, хил хамгаалах байгууллагын үүрэг мэтээр ойлгогдох байдалд хүрчээ. Иймд улсын хил, түүнтэй холбоотой асуудал, хил хамгаалалтын талаар улсын хэмжээнд баримтлах бодлогыг нэгтгэн зангидах, явуулж буй үйл ажиллагааг уялдуулан зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор тухай үеийн Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт "Төрөөс хилийн талаар баримтлах бодлого", хилийн тухайн хууль тогтоомж болон нэгдэн орсон Олон Улсын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийж, эрх зүйн орчинг оновчтой болгоно" гэж заасныг үндэслэн Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд нийцүүлэн "Төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлогын үндэс"[1] баримт бичгийг боловсруулжээ. Төрөөс хилийн талаар баримтлах бодлого нь улсын хилийн асуудлаар Монгол улсын олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, үүнтэй холбоотой хууль тогтоомж боловсруулах, хязгаар нутгийг хөгжүүлэх зэрэг асуудлаар баримтлах төрийн албан ёсны үзэл баримтлал бөгөөд удаан хугацааны туршид залгамж чанартай мөрдөгдөх

[1] "Төрөөс хилийн талаар баримтлах бодлого" үзэл баримтлал,УБ.2002,

баримт бичиг билээ.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлого нь дараах бүтэц агуулгатай байна:

-Хилийн талаар баримтлах бодлогын агуулга, зорилго, зорилт, нэр томъёог тодорхойлсон нийтлэг үндэслэл

-Улсын хилийг арчлан хамгаалах, хил орчмын нутгийн аюулгүй байдлыг хангах, хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутгийн аюулгүй байдлыг хангах механизмыг бүрдүүлж боловсронгуй болгох, хил хамгаалах болон хяналтын байгууллагын бүтэц, үйл ажиллагааг боловсронгуй болгох зэргийг тусгасан үндсэн чиглэл;[2]

-Уг бодлогыг хэрэгжүүлэх нөхцөл зэрэг бүлгүүд болно.

Энэхүү баримт бичиг нь улсын хилийн асуудалд хамаарах нийгэм, улс төр, зохион байгуулалт, эдийн засаг, дипломат, цэрэг, тагнуул, хууль зүйн хүрээг хамарна.

Бодлогын "Нийтлэг үндэслэл" болон "Улсын хилийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл"-ийг тодорхойлсон хэсгүүд ил, "Хэрэгжүүлэх арга зам"-ыг тодорхойлсон хэсгийн зарим заалт нууц болно.

Бодлогод хязгаар нутгийг эрчимтэй хөгжүүлэх, улсын хилийг мэргэшсэн хилчид, техник хэрэгсэл хосолсон, улс төр дипломатын арга голчилсон хамгаалалттай болгох, түүнд төрийн байгууллагууд, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангаж, хил нээлттэй, энхийн байх үзэл санааг агуулсан дараах зарчмын гол заалтууд тусгагдсан байна.

-Улсын хилийн асуудлаар баримтлах төрийн бодлого нэгдмэл, явуулж буй үйл ажиллагаа уялдан зохицож байх эрх зүйн орчинг бүрдүүлэх;

-Нэгэнт тогтсон хил өөрчлөгдөхгүй, түүний халдашгүй дархан байдал хангагдсан байх нөхцлийг бүрдүүлэх;

-Хилийн аливаа асуудлыг энхийн аргаар шийдвэрлэж байхыг эрмэлзсэн Монгол төрийн албан ёсны байр суурийг илэрхийлсэн байх;

-Хязгаар нутаг, түүнийг хөгжүүлэх, тэнд ажиллаж, амьдрагсдын нийгмийн баталгааг хангах талаар баримтлах төрийн үзэл баримтлалыг тодорхойлох;

-Улсын хил хамгаалалтад оролцох чиг, үүрэг бүхий бүх байгууллагуудад мөрдөгдөж буй хууль тогтоомжуудыг улсын хил хамгаалалтын эрх ашигт нийцүүлэх, тэдний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах механизм бүрдүүлэх;

-Улсын хил хамгаалалтад хяналтын болон илрүүлэлтийн зориулалттай техник хэрэгслийг өргөн нэвтрүүлэх, аль болох хэмнэлттэй, үр өгөөж сайтай аргыг түлхүү ашиглах асуудлыг чухалчлах;

-Улсын хил хамгаалах байгууллагын чиг үүрэг, харъяалал, бүтэц зохион байгуулалт, бүрэлдэхүүн, зэвсэглэл, хангалтын байдлыг сайжруулах, улсын хил хамгаалалтад түүний эзлэх байр суурийг өндөржүүлэх, бие даасан ажиллагаа, боломж, чадавхийг дээшлүүлэх асуудлыг баталгаажуулах;

-Улсын хил хамгаалалтад оролцогч байгууллага, иргэдийн нийгмийн хангамж, баталгааг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг тусгах зэрэг болно.

"Төрөөс хилийн талаар баримтлах

[2] Төрөөс хилийн талаар баримтлах бодлого. УБ,2002

бодлого" хэрэгжүүлснээр төрөөс хилийн талаар баримтлах бодлого цэгцтэй болж, түүний залгамж чанар хангагдан ямар ч засаглалын үед мөрдөгдөх тулгуур баримт бичиг болох ба улсын хил түүнтэй холбоотой асуудлыг цогцоор шийдвэрлэх боломж бүрдэн энэ талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээрийг байгуулахад үндсэн баримтлал байх боломж хангагдах нь уг баримт бичгийн гол үзэл санаа юм. Судалгааны явцад төрөөс хилийн талаар баримталж байсан уламжлалыг эрдэмтдийн хийсэн дүгнэлтээр тодорхойлбол:

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулан ХХЕГ-ын дэргэдэх Шинжлэх Ухаан Технологийн Зөвлөлөөс Мэдээлэлжүүлэлтийн Олон Улсын Академи, МСМА-тай хамтран 2006 онд зохион байгуулсан "Улсын хил, хязгаарын талаар Чингис хаанаас баримталсан бодлого, сургамж" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал дээр эрдэмтэн судлаачид тавьсан илтгэлүүддээ Монгол улсын хилийн хамгаалалт, баталгаажилтыг төгс төгөлдөр байлгах, хилийн аюулгүй байдлыг хангах нөхцөл бололцоог бүрдүүлэхтэй холбоотой байгууллага, иргэн бүхэн өөрт оногдсон үүрэг, зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд онол арга зүйн талаас туслаж дэмжих зорилгоор дараах дүгнэлтүүдийг хийжээ.

Үүнд:

МОУА-ийн академич, доктор, профессор, хошууч генерал П.Сүндэв:

Их монгол улсыг байгуулсны 800 жилийн ойг даян дэлхийд тэмдэглэхээр НҮБ-аас шиййдвэрлэсэн нь Монгол улсын нэр хүнд, эзэн богд Чингис хааны гавьяаны бодит илрэл бөгөөд түүнд улсын хил, хязгаарын баталгаажилт, хамгаалалт, шийдвэрлэх нөлөөлөх хүчин зүйлийн нэг нь болж байна.

Улсын хилийг баталгаажуулах, хамгаалах онол, арга зүй үүсэж хөгжихөд Чингис хаан, түүний залгажлагчдын оруулсан хувь нэмэр, гавьяа зүтгэл нь Монгол улс төдийгүй дэлхий нийтийн ач холбогдолтой, тэр нь өөрийн хүчтэй адил хэмжээний буюу олон дахин давуу илүү хүчнээс улс орон, ард түмнээ найдвартай хамгаалах чадвараар илэрч байна гэж:

МОУА-ийн тэргүүлэгч гишүүн, академич, Шинжлэх ухааны гавъяат ажилтан, ЦШУ-ны доктор, профессор, дэслэгч генерал Ш.Арвай:

Улс орон, цэргээ нэгдмэл тогтолцоогоор бэлтгэх, явуулах иж бүрэн шинжтэй олон төрлийн арга хэмжээнүүдээс бүрдсэн маш нарийн тогтолцооны үндэс нь цэргийн бүтэц, зохион байгуулалтад оршиж байсан бөгөөд энэ тогтолцооны үндэс нь гуравт, аравт, зуут, мянгат, түмтийн тогтолцоо байв.

Тус тогтолцоог хүмүүн төрөлхтөн оршин байгаа өөрийн улс орны өвөрмөц тогтолцоонд нийцүүлэн VIII зууны турш хэрэглэж иржээ. -Чингис хааны цэргийн байгуулалтад цэргийн ноёд, бидний хэлж заншсанаар боловсон хүчнийг бэлтгэх, сонгох, томилох, үр дүнг үнэлж дүгнэх бүхэл бүтэн шинэ мэдлэг, хүний нөөцийн тогтолцоог бий болгожээ.

Чингис хааны цэргийн байгуулалтын нэгэн үнэт сургамж бол улс орон цэргийн хүчийг хил хязгаараа хамгаалахад байнгын бэлтгэлтэй байлгах зүйрлэшгүй өвөрмөц ухаан

бодол, бүтээлч үйл ажиллагаа байлаа.

Орчин үед улсын хил хамгаалах хүчний хэрэглэж байгаа цэргийн байгуулалтын үндэс нь Чингис хааны үүсгэж ашигласан бодлого ухааны үргэлжлэл үр шим бөгөөд хүн төрөлхтөн өөр өөрийн улс гүрний хэмжээнд баяжуулан хэрэглэж ирснээрээ онцлогтой.

Эзэн Богд Чингис 800 жилийн тэртээ нэн тэргүүнд гаднаас учирч болзошгүй аюулаас улс орон, ард түмнээ хамгаалахын тулд 95 мянгатыг хил хязгаарын дагуу байрлуулж ашигласан нь тохиолдлын чанартай байгаагүй бөгөөд энэ нь улсын хилийн тухай шинжлэх ухааны үндэстэй онол анхлан тавигдсан байж болох юм.

Зэр зэвсгийн зэрэгцээ оюун ухааны ач холбогдол өсч байна. Дэлхийчлэгдэн буй ертөнцөд нэг улсын хилээс хамт гарсан үндэстэн дамнасан эдийн засаг, мэдээллийн бүтэц буй болж байхад нөгөө талаар нэг улсаас үл хамаарах терроризмын сөрөг үр дагавар гарах болов.

Их Монгол улс байгуулагдсан үе өнөөгийн нөхцөл байдлын хооронд бараг бүхэл бүтэн эриний зааг гарч байгаа ч гэсэн Чингисээс улсын хил хамгаалахад оруулсан уламжлалт өвөрмөц онол арга зүй их байгаа нь маргаангүй гэж дүгнэсэн байдаг.

Мөн Чингис судлалын төвийн тэргүүн, МСМА-ийн дэд ерөнхийлөгч, МОУА болон Монгол улсын ШУА-ийн академич, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Ч.Далай:

Эзэн Чингис 1206 онд Их Монгол улсаа тунхаглаад юуны урьд цэрэгжсэн хүчнийхээ 90 шахам хувийг хил хязгаартаа байрлуулж ашиглажээ.

Энэ бол шинжлэх ухааны үндэстэй төрийн тодорхой бодлого яах аргагүй мөн. Улсын хилийн дагуу байрладаг сум, аймаг нь хилийн цэрэгтэйгээ хамт тухайн чиглэлийн аюулгүй байдлыг хангахад бэлэн байх учиртай. Тэр үеийн тогтолцоо цэрэг-иргэний хосолсон шинжтэй байсан учраас бүхнийг нэг зорилгод чиглүүлэн ашиглахад арай хялбар байсан.

Эзэн Чингис бусдыг эзэрхэхийн тулд хөрш зэргэлдээ улс орондоо довтолж байгаагүй. Харин эсрэг талаас халдаж, түрэмгийлж доромжилж өдөөн хатгадаг учраас тэдний эсрэг тэмцэх зайлшгүй бодит шаардлагаас урган гарч байв. Харин ч Чингис хаан итгэл үнэмшил, эв эеийг туйлаас эрхэмлэн, түүнээс үндэслэсэн хөршүүдийн удирдлагатай ураг төрлийн холбоо тогтоохыг эрхэмлэж байсан түүхтэй.

Монгол орны өвөрмөц байгаль, монголын соёл иргэншлийн онцлог, цөөхөн хүн хүчээр өөрийгөө хамгаалах улсын бодлого үйл ажиллагаанд, түүнчлэн улсын хилээ хамгаалахад оногдож зохицсон зарчим, арга барил зүй тогтлын шинжтэй бодол санаа юутай харьцуулшгүй амьдралд ч байдаг, бас улс, нийгэм, хүн ардынхаа эрэлт хэрэгцээнд илүү бүтээлчээр нийцдэг талтай.

Чингис эрдэмтэн мэргэдийг бараг бүхний дээр онцгойлон тавьж бараг бүх шатанд зөвлөх болгон ашиглаж байсан. Хилгүй улс гэж байхгүй, улсгүй хил гэж байхгүй. Энэ нь яван явсаар найрамдал, сөргөлдөөн тэмцлийн гол обьект болж ирсэн түүхтэй.

Улсын хил дээр найрамдал нөхөрлөлийг онцгойлон үзэх, улсын

хязгаар нутгийг улсын сүр хүч, өнгө үзэмж гэж үзэн шилдэг хүчээр бэхжүүлж, нийгэм эдийн засгийн хөгжлийг нь онцгойлон дээшлүүлж, халдах дайсныг няцаахад хязгаар нутгаар гүнд цөмрүүлэхгүй барьж шийтгэхээр цэргээ бэлэн байлгах зэрэг онол, арга зүйг үндэс болгож байсан нь Чингисийн бидэнд үлдээсэн нэг сургамж нь эрдэмтдээ дээдлэх, тэдний оюуны их боломжийг ашиглах, зөвлөхөөр авч ажиллуулах уламжлалт сургамж гэж илтгэлдээ дурдсан нь дээрх эрдэмтдийн хийсэн дүгнэлтүүдээс үзэхэд Чингис хаан, түүний залгамжлагчид улсын хилийн асуудлыг нэн тэргүүн ээлжинд авч үзэж, хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах талаар тодорхой төрөөс хилийн талаар бодлого баримталж байсан гэж үзэх үндэстэй байна.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТҮҮНИЙ ХУВЬСАЛ ӨӨРЧЛӨЛТ БА ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Б.Лувсанравдан. ХСИС-ийн Ахлагчийн сургуулийн Хил хамгаалах албаны тэнхимийн эрхлэгч, докторант, дэд хурандаа



АГУУЛГА:

-Аюулгүй байдлын ойлголт, үүсэл хөгжил

-Аюулгүй байдлыг хангах үзэл баримтлалын өнөөгийн байдал

-Хилийн аюулгүй байдал

Аюулгүй байдал, түүнийг хангах үйл ажиллагаа нь олон мянган жилийн уламжлалтай бөгөөд хүй нэгдлийн нийгэм ч байнгын аюул заналын дунд бий болсон. Энэ үед хүний үйл ажиллагаа болхи бүдүүлэг байсан ч өөрийгөө гадаад, дотоодын аюулаас хамгаалах боломжийг олгож байсан. Хүний нийгэм боловсронгуй болж хөгжихийн хэрээр аюул, хөнөөлийн шинж чанар хэмжээ улам ихсэж тэр хэрээр аюулаас хамгаалах шинэ арга хэрэгсэл хайх шаардлага тулгарсаар байсан. Түүхийн явцад тулгарсан аюулаас найдвартай хамгаалах гол хүч нь ээлж дараалан биесээ халж гарч ирсэн отог омог, овог аймаг, аймгийн холбоо, төр улсын байгуулал болж хөгжжээ.

Монгол Улсын хувьд ч Хүннү гүрний үеэс эхлээд өнөөдрийг хүртэл нийгмийн хөгжлийнхөө үе шат бүхэндээ аюулгүй байдлын бодлого уламжлалтай байжээ. "...МЭӨ 209 онд асар том газар нутагтай хаан Модун "Газар бол улсын үндэс" гэж номлосныг монголчууд түүхэндээ эх оронч үзэл, төрийн бодлогынхоо төвд байлгасаар ирсэн..."[Стратегийн судалгааны хүрээлэн УБ.1999 он. 408х.38хх]. Энэ бодлогын үр дүн хөгжсөөр Их монгол улсын үеэс дэлхийн энх амгалан

байдал, бүх талын хамтын ажиллагаа, аюулгүй байдлыг хамгаалах тогтолцоо бий болсныг хүн төрөлхтөн хүлээн зөвшөөрчээ. Дундад зуунд Монголчууд өөрийн нутгийн аюулгүй байдлыг хангах үүднээс өөрийн нутгийг тойруулан хант улсуудыг байгуулж гүрэн улсынхаа халхавч болгож ирсэн.

Эртний өрнийн сэтгэгчид аюулгүй байдлыг хангах асуудалд хүмүүсийн харилцааг зохицуулах дүрэм журам чухал хэрэгтэй гэж үзэж байсан явдал нь аюулгүй байдлыг хангаж буй өнөөгийн бодлогын эх суурь болжээ.

17-18 дугаар зууны үед Т.Гобсс, Д.Локк, Ж.Руссо зэрэг сэтгэгчдийн үзэл баримтлалын үрээр баруун европын орнуудад аюулгүй байдлын ойлголт хүчтэй тархаж "Аюул занал арилж амгалан тайван байдал тогтоход улс төр, эдийн засаг чухал нөлөөтэй" гэж үзэж эхэлсэн бөгөөд дэлхийн улс орнууд түүхийн явцдаа аюулгүй байдлаа хангах үндсэн чиглэл нь цэрэг зэвсэг, эдийн засаг гэж үзсээр ирсэн. Хүйтэн дайны дараа буюу 1980-аад оноос аюулгүй байдлаас гадна нийгмийн аюулгүй байдал гэсэн нэр томъёо гарч ирсэн бөгөөд нийгэм бие хүний ашиг сонирхол чухлаар яригдах болсон. Энэ нь яв явсаар бие хүний аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйл зэрэг ойлголтуудыг бий болгожээ.

Энэ үеэс германы судлаачид "... Аюулгүй байдал гэдэг нь хэн ч юунаас ч айж түгшихгүй байх нөхцөл..." [Бор.Ж. Чулуунбат.Б. Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс. УБ.2012 он. 306х.15хх] гэж тодорхойлсон байдаг.

Хорьдугаар зуунд уламжлалт шинжлэх ухааны салбарууд ололт амжилтаа нэгтгэн хөгжсөнөөр шинэлэг шинжлэх ухааны салбарууд нээгдсэн. Ер нь ямар ч салбар шинжлэх ухаан нь хүний нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдан хөгждөг зүй тогтолтой бөгөөд хүний нийгмийн хөгжлийн эцсийн зорилт бол хүн, түүний хүрээлэн буй орчны аюулгүй байдлын асуудал болон хөгжиж байна. Иймээс учраас өнөөдөр дэлхий дахинд аюулгүй байдал, түүний баталгаажилтын асуудал эрчимтэй судлагдаж байна.

Аюулгүй байдал нь маш өргөн ойлголт бөгөөд орчлон ертөнц, сансар, агаар мандал, тив, улс, үндэстэн, төр, нийгэм, хүн гэх мэт олон орон зайн түвшний судлагдахуун юм. Аюулгүй байдлыг олон шинжлэх ухаан судалдаг ч зөвхөн өөртөө хамааралтай тэр хэсгийг өөрийн салбарын судалгааны байр сууринаас хандаж хэсэгчлэн судалдаг байна.

Аюулгүй байдлын тухай судалгаа нь "... Философийн, - Улс төр судлалын, -Тусгай буюу салбарын гэсэн 3 түвшинд явагдах үндэстэй юм..." гэж олон улсын эрдэмтэд үзэх болжээ. Философийн судалгааны түвшин нь аюулгүй байдлын тухай асуудлын нийтлэг зүй тогтол, зарчим, нөхцөл шалтгааныг тодорхойлох зэрэг өргөн хүрээний ойлголтыг, улс төр судлалын түвшин нь төр, нийгэм, бие хүн зэрэг объектууд, тэдгээрт учирч болох аюулаас хамгаалах зүй тогтлыг, салбарын судалгааны түвшин нь улс төр, эдийн засаг, батлан хамгаалах, мэдээлэл зэрэг тодорхой салбарын асуудлыг тус тус судалдаг байна..." [Бор.Ж. Чулуунбат.Б. Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс. УБ.2012 он. 306х.11хх] Өнөөдөр

дэлхийд аюулгүй байдлын тухай олон тодорхойлолтууд бий болсон байна. Тухайлбал: судлаач Ч.Улаанхүүгийн тодорхойлсноор "...Аюулгүй байдал гэдэг нь нийгэм, хувь хүн, улс гүрэн нь аюул заналаас хамгаалагдсан байдлыг аюулгүй байдал...", ..."Аюулгүй байдал нь аюул заналхийлэлгүй орчин, аюулаас сэргийлэх хамгаалалт юм"... Судлаач Ж.Борын бичсэнээр "Аюулгүй байдал нь найдвартай оршин тогтнох, өөрөө зохицуулах, нэгдмэл байдал зэрэг зарчимтай системлэг ойлголт юм..." Аюулгүй байдал гэдэг нь аливаа нийгмийн иргэд нь өөрийгөө илэрхийлэх, хөгжих, соёлжих боломж юм...", "...Аюулгүй байдал нь аз туршсан зөрчилдөөнт нөхцөл байдалд амьдрах чадвар боломжийг хангах баталгаа..", "...Аюулгүй байдал нь сөрөг нөлөө үзүүлэх аливаа айдас түгшүүр бүрэн арилсан үлгэр жишээ нөхцөл байдал юм..." гэх зэргээр тодорхойлсон.

Судлаач миний хувьд аюулгүй байдал гэдэг нь улс орон, байгууллага, иргэд ямар нэгэн айдас түгшүүр, аюул занал, тэдгээрээс үүдсэн хохирол үгүй байх нөхцөл, боломж юм гэж үзэж байна.

Аюулгүй байдлыг хангах үзэл баримтлалын өнөөгийн байдал

Аюулгүй байдлын тухай маш олон ойлголтуудын дотроос нэгтгэн тунгааж дэлхийн улс бүр өөрийнхөө аюулгүй байдлын үндсийг тодорхойлж түүнийгээ баримтлан ажилладаг. Тухайлбал, Японы ҮАБ-ын номлолд нийгэм, эдийн засгийн үндэс төрийн байгууллын хэвийн үйл ажиллагааг хангах, нийгэм төрийн байгууллыг хадгалах, батлан хамгаалах хүчин чадал, нутаг дэвсгэрийн халдашгүй дархан байдал, бие даасан гадаад, дотоод бодлого нь үндэсний аюулгүй байдлынх нь бүрэлдэхүүн болсон байдаг. Харин Францад улсын аюулгүй байдлыг дотоодын эмх замбараагүй байдал, гадаадын түрэмгийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд бий болсон энх тайван амар амгалан байдал гэж үздэг байна. Харин Герман улсын үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэгт улс төр, эдийн засаг, цэргийн хүч, газар нутаг, олон улсын нэр хүнд, төрийн хэвийн үйл ажиллагаа зэрэг хамаардаг байна.

Монгол Улсын хувьд ч 1990–ээд оны өөрчлөлтийн үр дүнд хөрш орнуудын найрамдалт харилцааны үр дүнгээр аюулгүй байдлаа хангадаг байсан үе өнгөрч өөрөө өөрийнхөө аюулгүй байдлаа хангах шаардлага тулгарч анх 1994 онд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаа боловсруулж УИХ-аар батлуулсан юм. Энэ үзэл баримтлал нь түүхэн нэн эгзэгтэй үед үндэсний аюулгүй байдал, үндэсний эрх ашгийг хангах төрийн бодлогын үндсэн зарчим, чиглэлүүдийг зааж өгсөн нь чухал үүрэг гүйцэтгэж, шилжилтийн үеийн бэрхшээлийг даван туулж тусгаар тогтнолоо баталгаажуулах, хөгжлийн суурийг тавихад чухал ач холбогдолтой байсан ч манай улсын аюулгүй байдлын гадаад, дотоод нөхцөл байдал өөрчлөгдөж, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг өнөөгийн нөхцөлд нийцүүлэн шинэчлэх шаардлага бий болсон.

Энэхүү шаардлагын дагуу үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалыг 2010 оны 7-р сарын 15-ны өдөр УИХ баталсан билээ. Энэ үзэл баримтлал нь үндэсний аюулгүй

байдлыг хангах гол чиглэл, арга замыг тодорхойлсон төрийн бодлогын чухал баримт бичиг бөгөөд үүнээс үүдэлтэй аюулгүй байдлын салбар, эрх зүйн орчны өргөн хүрээтэй шинэтгэл эхэлсэн.

Үндэсний аюулгүй байдал гэдгийг өмнө нь уламжлалт улс төр, цэрэг, дайны заналхийлэлтэй холбон ойлгож, зөвхөн төр, түүний тусгай байгууллагуудын үүрэг хэмээн үзэж байв. Харин орчин үеийн шинэ нөхцөл байдал нь аюулгүй байдлын тухай ойлголт, цар хүрээ, хангах арга замыг өргөтгөж, шинэчилсэн үзэл баримтлал нь хүн төвтэй, цогц, мэдлэгт суурилсан гэсэн суурь зарчмаар өөрчлөгдсөн.

Өөрөөр хэлбэл аюулгүй байдалд хандах хандлага, шийдвэрлэх арга замуудыг шинээр томъёолж Оршин тогтнохуйн аюулгүй байдал, Эдийн засгийн аюулгүй байдал, Дотоод аюулгүй байдал, Хүний аюулгүй байдал, Хүрээлэн буй орчны аюулгүй байдал, Мэдээллийн аюулгүй байдал гэсэн зургаан чиглэлээр цогц харилцан уялдаатай хангах, нийгэм, иргэдийн хамтын хүчээр хангах зарчим дээр тулгуурлах шаардлагатай болсон. Хувь хүний аюулгүй, амгалан, эрүүл, хангалуун амьдрал нь нийгмийн тогтвортой байдал, хөгжил дэвшлийн сурвалж болж, энэ нь цаашлаад төр, улс, үндэсний аюулгүй байдлыг хангаж төр, нийгэм нь аюулгүй байж иргэнийхээ аюулгүй байдлыг хангана гэсэн хүн төвтэй аюулгүй байдлын үзэл баримтлал болсон байна. Тиймээс хүний амар амгалан, аюулгүй, эрүүл, хангалуун амьдрах, түүний хөгжих, хөдөлмөрлөх нөхцөл бүрдсэн, орлого, хүрээлэх орчин, хүнс нь аюулгүй байх цогц, бодитой, оновчтой шийдлийг тусгасан мэдлэгт суурилсан үзэл баримтлал юм.

Үндэсний аюулгүй байдлыг хангах, үндэсний эрх ашиг, үнэт зүйлийг хамгаалах, хэвшүүлэх, улс орны хөгжлийг хангах, эв нэгдэл, нийгмийн оюун санааг төлөвшүүлэхэд чиглэгдсэн тодорхой зорилт, арга хэмжээг тусгаснаар тунхаглалын шинжтэй бус төр, нийгэм, иргэдийн харилцан хамтын ажиллагаагаар, харилцан уялдаатай хангах тодорхой стратеги, чиглэлийг заасан нь чухал ач холбогдолтой.

Хилийн аюулгүй байдал

Монгол улс оршин тогтносон 2200 гаруй жилийн түүхэн хугацаанд учирч байсан аюул занал нь манай нутаг дэвсгэрийг бүхлээр нь буюу хэсэгчилж эзэмших зорилготой явагдаж ирсэн.

Өнөөдрийн байдлаар "Хилийн аюулгүй байдал" гэдэг нэр томъео нь ямар нэг хууль тогтоомжид тусгагдаагүй байна. Харин судлаачид "...Хилийн аюулгүй байдлыг улсын хил хязгаар нутагт улс, нийгэм, иргэдийн ашиг сонирхол хангагдсан байх нөхцөл..." [Ц.Ганболд, Д.Нямдорж. Хил судлал. УБ.2011 он. 172х.124хх] гэж үздэг.

Хилийн аюулгүй байдлын тухай ярихаас өмнө үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал түүний салшгүй хэсэг болох оршин тогтнохуйн аюулгүй байдлын тухай зайлшгүй ярих болно.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт

байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана..."[Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. УБ.2001 он.]

Оршин тогтнохуйн аюулгүй байдал

"...Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс мөн. ..."[Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ.2010 он.] гэж тунхагласан нь хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал нь Монгол улсын аюулгүй байдлын чухал судлагдахуун болохыг тодорхойлж байгаа юм. Уг үзэл баримтлалд:

Хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдал

3.1.2.1. Нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зарчимтай уялдуулан Монгол Улсын газрын сангийн нэгдсэн бодлого, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоно.

3.1.2.2. Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах, зэвсэгт хүчний нэгдмэл тогтолцоог төлөвшүүлж, зэвсэгт хүчнийг мэргэжлийн чиг баримжаатай, чадварлаг болгон хөгжүүлнэ. Улсын хилийн хамгаалалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, урамшуулах бодлого явуулна.

3.1.2.3. Гадны дүрвэгсэд олноор хил даван орж ирэх, гэнэтийн хяналтгүй нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх бэлэн байдлын тогтолцоог бүрдүүлж, эрх зүй, улс төр, дипломатын цогц арга хэмжээ авна.

3.1.2.4. Хилийн хамгаалалт, хяналт шалгалтын үйл ажиллагаанд мэдээллийн нэгдмэл, шуурхай байдлыг баталгаатай хангах зохион байгуулалт, техник, технологийн шинэчлэлийг хэрэгжүүлнэ.

3.1.2.5. Хил орчмын бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэхдээ үндэсний нэгдмэл ашиг сонирхлыг дээдэлж, Монгол Улсын бүрэн эрхт байдал, хил хязгаар, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг бататгах зарчмыг үндэс болгоно.

3.1.2.6. Хил дээр боомт нээх, хаах, боомтын ажиллагааны горимд өөрчлөлт оруулах асуудлыг төрийн эрх барих дээд байгууллага шийдвэрлэнэ.

3.1.2.7. Хилийн дагуух орон нутгийн хөгжлийн бодлого, гадаад харилцаа нь төрийн нэгдсэн бодлогод захирагдана.

Эдгээрээс үзэхэд хилийн аюулгүй байдал бол үндэсний аюулгүй байдлын "гол бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үндэсний болон бүс нутаг, дэлхийн төвшний төрөл бүрийн субъектүүд, тэдний харилцан ажиллагааны үр дүн болох нь" харагдаж байна.

УУЛЫН БҮСИЙН ФИЗИК ГАЗАР ЗҮЙН ОНЦЛОГ ХИЛ ХАМГААЛАЛТЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД НӨЛӨӨЛӨХ НЬ:

ХСУА-ийн 821 дүгээр дамжааны сонсогч,
магистрант, дэд хурандаа Т.Нурлан

Хураангуй: Энэхүү илтгэлээр уулын бүсийн физик газар зүйн онцлог нь хил хамгаалалтын удирдлага, зохион байгуулалтад хэрхэн нөлөөлж байгаа тодорхойлохыг зорьсон болно.

Түлхүүр үгс: Уулын бүсийн физик газар зүйн онцлог, хилийн нөхцөл байдал, хил хамгаалалтын удирдлага, зохион байгуулалт

Монгол Улсын байгаль цаг уурын онцлог, нөхцөл байдал нь улсын хилийн аюулгүй байдлыг хангах, хил хамгаалалтыг зохион байгуулан явуулахад зайлшгүй анхаарвал зохих чухал хүчин зүйл, хөдөлгөгч хүч бөгөөд хилийн бүс нутаг, хил орчмын нутаг дэвсгэрийг дээрх хүчин зүйлүүдийг үндэслэн уулын бүс нутаг гэж хуваан авч үзсэн.

Монгол орны газар нутаг далай тэнгисээс алслагдсан тал бүрээсээ өндөр уул нуруугаар хүрээлэгдсэн, далайн түвшнээс дээш 1800 метр өндөрт орших бөгөөд нутаг дэвсгэрийн ихэнхи хувь нь уулархаг бүсэд хамаарагддаг зэргээс шалтгаалж эх газрын эрс тэс, уур амьсгалд багтана.Уулархаг бүсийн газар орны нөлөөллийг дараахь байдлаар тодорхойлон гаргана.Үүнд:

д/д	Газар нутаг	Далайн түвшингээс дээш	Харьцангуй өндөр нь	Хажуугийн нэрс a^0-нь
1.	Өндөр уулстай	2000 м-ээс дээш	1000 м-ээс дээш	25^0-ээс дээш
2.	Дунд зэргийн уулстай	1000-2000 м хүртэл	500-1000 м-ээс дээш	10^0-20^0 хүртэл
3.	Нам уулстай	500-1000 м хүртэл	200-500 м-ээс дээш	5^0-10^0 хүртэл

Уулын бүсийн уур амьсгалын байнгын хахир ширүүн нөхцлөөс гадна хил хамгаалалтанд сөргөөр нөлөөлж байдаг онц аюултай үзэгдэл цөөнгүй тохиолдоно. Үүнд:

1. Хүчтэй салхи жилд-5 орчим удаа
2. Цасан шуурга зарим өвөл 55 хоног хүртэл давтамжтай
3. Цасан бүрхүүл 30 см-ээс дээш тогтоно
4. Цочир хүйтрэл 8 сарын 10-наас эхэлнэ
5. Хур тунадас жилдээ 100-400 мм унана
6. Бүрхэг өдөр 30-70 хоногт хэлбэлзэнэ
7. Аянга цахилгаан жилдээ 35-45 удаа бууна
8. Мөндөр 30 орчим удаа ордог зэргээс үзвэл цаг агаарын эрс тэс уур амьсгал, хахир хатуу өвөл, аагим халалтыг үүсгэдгээрээ хил хамгаалалтыг зохион байгуулж

явуулахад ихээхэн хүндрэл учруулна.

9. Мөн уулархаг хэсэгт хавар цочир хүйтрэл хожуу /6-р сарын дундуур/ дуусаж, намар эрт /8-р сарын сүүлийн 10 хоногт/ эхлэх бөгөөд дулааны хугацаа богино /70-аас цөөн/ бусад нутагт 90-130 хоног байдаг нь хил хамгаалалтыг зохион байгуулж явуулахад хүндрэлтэй байдаг байна.

Улсын хил хамгаалалтыг зохион байгуулахад уулын бүсийн цаг агаар, улирлын онцлог нь хил хамгаалалтад дараах байдлаар нөлөөлж байна.

а/ Хүйтэн сэрүүний улиралд эерэг нөлөөлөл нь:

- Хилийн зөрчил гарч болзошгүй чиглэл, зам даваа, хавцал уулын ам, гол нуурын дагуу цасан зурвас тогтож ул мөрийг хянаж хил хамгаалалтад ашиглах боломжтой.
- Цас их орж хилийн уул, даваа гүвээ, зам харгуй бүрэн хаагдаж, хоёр талаас хилийн хөдөлгөөн үйлдэх боломжгүй болдог учраас цагийн байдлын өрнөлт багасаж, хил хамгаалалтыг хилийн заставууд цөөн тооны хүчээр зохион байгуулах нөхцөл бүрддэг.
- Газар оронд үзлэг шалгалт хийх боломж хомс боловч хүн, мал амьтны хөдөлгөөнийг илрүүлэх зорилгоор даваа гүвээ, хавцал жалгын амыг хяналтанд авах, ашигтай байрлал эзэлж отох, бүслэн хаах, төрөл бүрийн саад хаалтыг байгуулах боломжтой.
- Хилчдийн хилд үүрэг гүйцэтгэх ачаалал, хөнгөрч, бүх шатны цугларалт хичээл сургууль, дадлага нормативыг нэгдсэн журмаар зохион байгуулах боломжтой болно.
- Өндөрлөг газраас застав, харуулын хянах манааны байрлалаас өдрийн гэгээтэй цагт хяналт зохион байгуулж, үйлдэл хөдөлгөөнийг хяналтанд авч илрүүлэх, шийдвэрлэхэд таатай нөлөө үзүүлнэ.

б/Сөрөг нөлөөлөл нь:

- Хил хамгаалалтад уналга тээврийн хэрэгсэл ашиглах боломж хязгаарлагдаж хилчид явганаар голдуу үүрэг гүйцэтгэдэгээс цаг агаарын огцом өөрчлөлтэй үед төөрөх, осгох, уулын цасны нурангид өртөх аюултай.
- Орон нутгийн харилцан ажиллагаатай байгууллагууд /үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, хил орчмын сум/-тай хамтран ажиллах шаардлагатай үед түүний хүч хэрэгслийг авах, ашиглах боломж хязгаарлагдмал.
- Хүч хэрэгслийг шилжүүлэн бүлэглэх, маневарлах, цагийн байдал үүссэн үед эрэл зохион байгуулахад хүндрэлтэй.
- Цасан шуурганы нөлөөгөөр зам жим, уулын харгуй хаагдах, халтиргаа гулгаа үүссэнээс хилийн манааны үүрэг гүйцэтгэх замнал өөрчлөгдөх, саадыг давахын тулд илүү зам туулах зэргээр үүрэг гүйцэтгэх нөхцөл, хугацаа өөрчлөгдөнө.
- Хилийн заставууд бүх төрлийн хангалт, эмнэлгийн тусламж болон бусад яаралтай арга хэмжээнүүдийг авахад туйлын хүндрэлтэй байдаг.
- Хилийн багана тэмдгийн 70 гаруй хувьд нь хүрэх боломжгүй. Хилийн дагуу болон алслагдсан хэсэг, хилийн зөрчил гарч болзошгүй чиглэлүүдэд хөдөлгөөн үйлдэх боломж хязгаарлагдмал.
- Хүйтний эрч өдөртөө 20-35 градус, шөнөдөө 30-40 градус хүйтэрч

үе үе цасан шуурга болдог нь хилийн манаа осгох, төөрөх аюул ихтэй.

- Нар жаргасны дараа агаарын хэм огцом буурч 10-20С-ийн зөрүү үүснэ.Салхины чиг байнга өөрчлөгдөж, уулын өндөр ихсэх тутам салхины хурд, хүч ихээхэн нэмэгдэнэ.

- Хилийн манаа уул хадан дунд өгсөж уруудахад 10 –ын өнцөг бүхий налууд 2-3 км/цаг, 20 хүртэл бол 1-1,5 км/цаг, түүнээс дээш налуу бүхий уулын ар, энгэрт 1 км/цаг хурдтай явах нөхцөл үүсэж, газар орныг баримжаалах зай бодит байдлаас 1.5-2 дахин буурна.

- Хилд үүрэг гүйцэтгэх буюу ажилд томилогдсон автомашинууд тогтоосон нормоос 2 дахин илүү шатах тослох материал зарцуулж механик эвдрэл гарч, зардал чирэгдэл нэмэгддэг.

- Уулын өндөр 10м-ээр өгсөх тутам агаарын хэм дунджаар 0,6-аар буурч, даралт 8-10мм-ээр багасч, агаарын нягтрал 1,2 хуваариар сийрэгжин, техникийн хөдөлгүүрийн хүчин чадал, хөдөлгөөний хурд буурах, шатахуун зарцуулалт болон усны ууршилт ихсэхэд нөлөөлдөг. Автомашины даац 20-25 хувь, хурд 2 дахин буурч шатахуун зарцуулалт 75 хүртэлх хувиар, техникийн хөдөлгүүрийн хүчин чадал, механик эвдрэл ихсэж зардал нэмэгдэнэ.

- Хил хамгаалалтад тээврийн болон илрүүлэлтийн техник хэрэгсэл ашиглах, хяналт зохиох, хилийн эрэл явуулах, хүч хэрэгслийг шилжүүлэн байрлуулах өөр хоорондоо болон нутгийн ард иргэд, орон нутгийн байгууллагуудтай холбоо барих, мэдээлэл солилцох боломж ихэнх хэсгүүдэд хязгаарлагдмал.

б/. Урин дулааны улиралд Улсын хил хамгаалалтад эергээр нөлөөлөх нөлөөлөл нь:

- Хариуцсан хэсгийн ой мод, байгалийн баялаг, нол нуурын усны хангамж хүрэлцээтэй байдаг нь хилчдийн ахуй хангалт, сэтгэл зүйд таатай нөлөө үзүүлдэг.

- Гарын доорхи материал мод, хад, чулуу, ашиглаж дулаацах байр барьж гэнэтийн хүйтэх бороо, мөндөр, аянга, цахилгаанаас өөрийгөө болон нөхдөө хамгаалах боломжтой.

- Байгаль цаг агаар, газар орны нөлөөллийг дагаж орон нутгийн айл, малчид хилийн зурваст ихээр зусаж намарждаг нь тэднийг байршлаар нь хил хамгаалалтад ашиглах, хил хамгаалалтын нягтрал болон хяналтанд хамаарагдах хэсгийн хэмжээг нэмэгдүүлэх, харилцан ажиллагааг зохион байгуулахад үр дүнтэй.

г/. Улсын хил хамгаалалтад сөрөг нөлөөлөл нь:

- Уулын цас хайлж, бороо их орсноос уулын голын урсгал ширүүсч, гол нуурын усны түвшин ихсэх гатлахад хүндрэлтэй болж, газрын хөрсийг эвдэж, халтиргаа нуранги үүсэх, хилийн манааны хөдөлгөөн үйлдэхэд хүндрэл учруулж улмаар үргэлжилсэн бороо манан будан татах зэрэг нь цэргийн хяналтыг зохион байгуулахад сөргөөр нөлөөлнө.

- Уулын голууд үерлэж гарам гүүрүүд эвдрэх, уулын чулуу нуранги, хөрсний гулгалт үүсэж хилийн манаа үүрэг гүйцэтгэхэд аюултай нөхцөл бий болно.

- Хилийн харуулд нарны энерги ашиглан, холбооны тэжээлийн эх үүсвэрийг цэнэглэх, холбооны бэлэн байдал, харилцан ажиллагаа зохион байгуулахад сөргөөр нөлөөлнө.

- Өндөр уул, даваа гүвээ, газар

орны бартаа саад, гол ус ихтэйгээс автомашинаар хилийн заставуудын хооронд болон хилийн зам харгуйгаар хөдөлгөөн үйлдэхэд техникийн осол аваар гарах магадлал өндөртэй.

- Хүний хариуцлагагүй үйлдлийн улмаас зарим уулын хэсэгт ойн түймэр гарч болзошгүй.
- Өндөр уулын хэсэгт аянга цахилгаантай аадар бороо олон хоногоор үргэлжилэн орох, байнгын манан будан татах нь хилчид аянганд өртөх, даарч осгох, төөрч будилах, үер усны аюулд нэрвэгдэхээс гадна өндөр уулын үргэлжилсэн таг, сарьдагуудад ундны ус, түлээ олдохгүйгээс гадна хилчдийн уналгын морьд хооллох өвс ургамал ургадаггүй.
- Газрын хөрсөн дээр үлдсэн ул мөрийг таниж ашиглах боломж хязгаарлагдмал байхын зэрэгцээ өндөр уул сархиаг, хадан хана нь бүх төрлийн холбооны техник хэрэгсэл ашиглахад саад учруулах бөгөөд дуран харааны хэрэгслийн байнга ашиглах шаардлага гардаг.
- Цаг агаарын эрс тэс уур амьсгал, өндөр уулын нөлөөлөл нь үүрэг гүйцэтгэж буй хилчдийн энерги зарцуулалтыг ихэсгэдэг.
- Холын зайд ажиглалт хийх, хил зөрчигчийг мөрдөх, байршлыг тогтоох боломж хязгаарлагдмал ба гэмт этгээдүүдийн зүгээс үйлдэх отолт, зэвсэгт эсэргүүцэлд өртөх магадлал өндөр.
- Эрэл хайгуул явуулах, газар оронд үзлэг шалгалт хийхэд тухайн орон нутгийн ард иргэдийг газарчнаар авах, үүний зэрэгцээ уул хаданд явж сургагдсан агт уналга, бусад зүтгэх хүч, тусгай зориулалтын хэрэгслүүд шаардлагатай болно.

Улсын хил хамгаалалтад нөлөөлөх эерэг хүчин зүйл нь:

- Хил зөрчигчид нь улсын хил зөрчихдөө уулын ам, хөндий дааваг ашигладаг тул хилийн зөрчил гарч болзошгүй чиглэлийг тогтооход дөхөмтэй.
- Өнгөлөн далдалтын боломж өндөр
- Улсын хил хамгаалалтад агт уналга хэрэглэх боломжтой
- Мал аж ахуй, туслах аж ахуй эрхлэх, байгалийн баялаг ашиглахад тохиромжтой.

Улсын хил хамгаалалтад нөлөөлөх сөрөг хүчин зүйл нь:

- Нэг цэгээс хяналтад хамрагдах хэсэг бага
- Хилийн манаа овор ихтэй хэрэгсэл авч явахад хүндрэлтэй
- Газар орны бартаа нугачаа, далдалт их
- Цаг агаар газар орны онцлогоос хамаарч үзэгдэх орчин хязгаарлагдмал
- Хилийн манаа улсын хил зөрчсөн этгээдүүдийн отолтод өртөх магадлал өндөр
- Хилийн зөрчил гарсан үед эрэл, операци явуулах, хүч хэрэгслийн шилжилт хөдөлгөөн үйлдэхэд бэрхшээлтэй
- Холбоо харилцан ажиллагааг зохион байгуулахад хүндрэлтэй
- Хил хамгаалалтад тээврийн хэрэгсэл ашиглах боломж хязгаарлагдмал, авто машины тогтоосон нормоос 2 дахин илүү шатах тослох материал зарцуулдаг
- Цаг агаарын огцом өөрчлөлтөд хилийн манаа төөрөх, осгох, цасны нуранги, аянга цахилгаанд өртөх магадлал өндөр
- Яаралтай эмнэлгийн тусламж

бүх төрлийн хангалт үйлчилгээ авахад хүндрэлтэй. 2000 метрийн өндөрт хүний цусан дахь хүчилтөрөгч дутагдсанаас зүрхний цохилт түргэсэн толгой эргэдэг бол, 3000 метрээс дээш гарах тохиолдолд өндөр уулын өвчнөөр өвчилж эхэлнэ. Түүний шинж тэмдэг нь толгой өвдөх, дотор муухайрах, бөөлжих, хоол унд, нойронд дургүй болсноос бие тавгүйтэн уур уцаартай болж, биеэ хянах чадвар алдагдан албаны ажиллагаанд нөлөөлж болзошгүй. Эрүүл мэндийн ийм өөрчлөлт нь урьд өмнө уг орчинд амьдран суурьшиж байгаагүй буюу өөр бүс нутгаас цэргийн албанд татагдагсад болон сайн дурын үндсэн дээр гэрээгээр алба хаахаар шилжин ирсэн цэргийн албан хаагчдад тохиолдох магадлал өндөр юм.

- Байгаль цаг улирлын өөр өөр нөхцөл байдал нь хилийн аюулгүй байдлыг хангах, хил хамгаалалтыг зохион байгуулан явуулах, улсын хилийн болон хил орчмын дэглэм зөрчигчдийн үйлдлийг таслан зогсооход эрэг болон сөрөг хүчин зүйлсийг үзүүлж байдаг.

- Зарим тохиолдолд эцсийн үр дүнд ч нөлөөлдөг онцлогтой тул бүх шатны удирдлага, штабаас алба үйл ажиллагаагаа зохион байгуулан явуулахдаа энэхүү хүчин зүйлсийг тооцон хилийн опериатив-тактикийн цагийн байдлыг үнэлэхдээ заавал харгалзан үздэг байх нь чухал болно.

Хилийн боомтын хил хамгаалалтыг зохион байгуулахад:

Уулын бүсийн цаг агаар, улирлын онцлог нь хилийн боомтын хил хамгаалалтад дараах байдлаар нөлөөлж байна.

Тус бүс нутагт Баян-Өлгий аймгийн Ногооннуур, Цэнгэл, Улаанхус, Сагсай, Алтай, Дэлүүн, Булган, Увс аймгийн Бөхмөрөн, Сагил, Давст, Тэс, Зүүнговь, Баруунтуруун, Ховд аймгийн Булган, Үенч, Алтай, Говь-Алтай аймгийн Тонхил зэрэг 4 аймгийн 17 сумын нутаг дэвсгэр дэх хилийн бүс зурваст боомт буюу 31.8% нь Даян-Хуншаньзюй, Өлгий-Усть-Каменигорьский, Булган-Такашикэн, Байтаг-Улиастай, Цагааннуур-Ташанта, Асгайтын гол-Аспайт, Тэс-Шарсуурь, Бөхмөрөн-Кызыл-Хая, Харигийн гол-Мугур-Аксы, Тээл-Хандгайт, Тээл-Торгалыг, Давст-Сарыг-Холь, Тэс-Сарыг-Холь, Боршоо-Хандгайт тус бүсэд тус тус харъяалагдаж байна.

Хилийн боомтууд нь төв суурин газраас алслагдмал, 35-250 км зайтай бөгөөд хилийн дагуух зам харгуй бартаа саад ихтэй, цахилгаан эрчим хүч, үүрэн холбооны сүлжээнд холбогдоогүй. Хүн амын суурьшилт сийрэг, сүүлийн жилүүдэд төв суурин газар луу шилжих хөдөлгөөн ихэссэн.

Улсын хил хамгаалалтад нөлөөлөх сөрөг хүчин зүйл:

- Төв суурин газраас алслагдсан, байнгын цахилгааны эх үүсгүүр, суурин болон үүрэн холбоо, зам харгуй зэрэг дэд бүтэц хөгжөөгүй;

- Орон нутгийн засаг захиргааны нэгж, хууль хяналтын болон харицан ажиллагаатай байгуулагууд хилийн боомтоос алслагдсан нь харилцан ажиллагааг зохион байгуулахад хүндрэлтэй;

- Ихэнх хилийн боомтууд ажилладаггүй, ОХУ-ын хил гаалийн шалгалт, хүнд суртал ихтэйгээс хилээр нэвтрэх иргэдийн тоо цөөн;

- БНХАУ-ын хилийн боомтоор Монгол улсын авто, тээврийн хэрэгслийг гаргадаггүй учраас бизнес эрхлэгчид уг

чиглэлд ирэх дургүй, хилээр нэвтрэх иргэдийн тоо цөөн;

- Жилийн дөрвөн улиралд цас, бороо их ордог, байнгын манан будантай, аянга цахилгаантай байдаг тул албанд ашиглагдаж байгаа бүртгэлийн техник хэрэгсэл аянгад цохиулах, эвдрэх, гэмтэл гарах магадлал өндөр, богино хугацаанд сэргээн засварлах, хэвийн ажиллагаанд шилжүүлэх боломж хязгаарлагдмал;

- Хур тунадас их унадгаас даваа гүвээ, голын гармууд хаагддаг, боомтоор нэвтрэх хөдөлгөөн багасдаг;

- Цаг агаар газар орны онцлогоос хамаарч үзэгдэх орчин хязгаарлагдмал;

- Хил зөрчигч, зөрчихийг завдагсад нь хилийн боомт газрыг тойрох, газар орны бартаа саадыг ашиглан нуугдах боломж өндөртэй;

- Холбоо харилцан ажиллагааг зохион байгуулахад хүндрэлтэй;

- Улсын хилээр нэвтрэх ачааны тээврийн хэрэгслийн тоо цөөн, нэвтрэх ачаа тээврийн хэмжээ бага;

- Цаг агаарын огцом өөрчлөлтөд хилийн шалган нэвтрүүлэх албаны манаа төөрөх, осгох, цасны нуранги, аянга цахилгаанд өртөх магадлал өндөр;

- Яаралтай эмнэлгийн тусламж бүх төрлийн хангалт үйлчилгээ авахад хүндрэлтэй:

- Хилийн боомтууд нь байнгын болон улиралын байдлаар ажилладаг тул албаны ёсны орчин үеийн шаардлага хангасан ажлын байргүй, түүнд ажиллаж байгаа албан хаагчид амьдрах, түр ажиллах нөхцөл бололцоо орчин бүрдээгүй нь эсрэг талын хилийн боомт, болон харилцан ажиллаж байгаа байгууллагуудад бодлогоо хүргэж чаддагүй байна.

Зарим тохиолдолд эцсийн үр дүнд ч нөлөөлдөг онцлогтой тул бүх шатны удирдлага, штабаас алба үйл ажиллагаагаа зохион байгуулан явуулахдаа энэхүү хүчин зүйлсийг тооцон хилийн оператив-тактикийн цагийн байдлыг үнэлэхдээ заавал харгалзан үздэг байх нь чухал болно.

Байгаль цаг улирлын өөр өөр нөхцөл байдал нь хилийн аюулгүй байдлыг хангах, хил хамгаалалтыг зохион байгуулан явуулах, улсын хилийн болон хил орчмын дэглэм зөрчигчдийн үйлдлийг таслан зогсооход эерэг болон сөрөг хүчин зүйлсийг үзүүлж байдаг.

- Орон нутгийн харилцан ажиллагаатай байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай үед түүний хүч хэрэгслийг авах боломж хязгаарлагдмал

- Хүч хэрэгслийг шилжүүлэн бүлэглэх, маневарлах, цагийн байдал үүссэн үед эрэл зохион байгуулан явуулахад хүндрэлтэй.

- Байгаль цаг агаар, газар орны таатай нөлөөллийг дагаж орон нутгийн айл, малчид хилийн зурваст ихээр зусаж намарждаг нь тэднийг байрлалаар нь хил хамгаалалтад ашиглах, хил хамгаалалтын нягтрал болон хяналтанд хамаарагдах хэсгийн хэмжээг нэмэгдүүлэх, харилцан ажиллагааг зохион байгуулахад үр дүнтэй байдаг байна.

СУРГАЛТЫН ОНОЛ, АРГА ЗҮЙ

ОРЧИН ҮЕИЙН БАГШИЙН ХЭВ МАЯГ, ЁС ЗҮЙ

Ё.Хадхүү. Хилийн сургуулийн Хилийн албаны тэнхимийн эрхлэгч, докторант, хурандаа



Өнөөгийн нөхцөлд аль ч улс оронд хүн ардын бүтээх чадавх нийгмийн хөгжлийн гол хөшүүрэг болж байгаа болохоор "Хүн төвт" бодлогыг үндсэн чиглэл болгож байна. Хөгжлийн хүн төвт бодлогыг хэрэгжүүлэхдээ нэн тэргүүнд боловсролоо нийгмийн салбар болгон хөгжүүлж, нийт иргэнийхээ боловсролын чанарыг дээшлүүлэхэд үлэмж их анхаарал тавьдаг болсон нь дэлхий дахины өнөөгийн түгээмэл хандлага болоод байна.

Монгол Улсын төр засгаас боловсролоо нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхэд онцгой анхаарч иргэний үр дүнд боловсролын тогтолцоог бүхэлд нь шинэчлэх үйл явц эрчимтэй хэрэгжиж байгаагийн нэгэн чухал асуудал нь "Багшийн хөгжлийн асуудал" болж байна.

Эдгээрээс үндэслэн: -"Орчин үеийн багшийн хэв маяг, ёс зүй"-н хүрээнд асуудлыг дэвшүүлэхдээ: "Нийгмийн Боловсролын Сургалтын кирриклюмын багшийн хөгжил шинэчлэлт өөрчлөлт хөгжил" гэсэн уялдаа холбоонд авч үзэж: Багшийн хэв маяг, ёс зүй нь нийгмийн хөгжлийн өнөөгийн шатанд ямар өөрчлөлт, хувьсалтай нөхцөлдөж байгаа талаас нь хөндөх нь зүйтэй болов уу.

Дэлхийн даяарчлалын өнөөгийн шатанд залгамж хойч үеэ хэрхэн яаж бутээлч, бодит чадвартай хүн болгон төлөвшүүлэх вэ гэсэн асуудлыг хамгийн үнэт зүйлсийн түвшинд дэвшүүлж байгаа билээ.

Энэхүү үнэт зүйлийг бүтээхэд багшийн үүрэг, роль, хэв маяг, ёс зүй голлох байр суурьтай байх нь зайлшгүй юм.

1. Сургуулийн орчин нөхцөлд нийгэмшин амьдрахад зайлшгүй хэрэгцээтэй шинжлэх ухааны суурь мэдлэг, арга ухаан, дадал зүй, ур чадвар хандлага, туршлага хуримтлуулсан эрдэмлэг оюун ухаан, цогц чадамжийг өөртөө цогцлуулсан байх,

2. Эрдмийн далайгаас сувд шүүрэх хүсэл тэмүүлэлд автагдсан нөр их хүч, авьяас, бүтээлч эрчим хүчийг нөөцөлсөн эрдэм номын уурхай байх,

3. Мэргэжлийн эв дүй, арга туршлага, үнэт зүйлс, язгуур өв уламжлал, урлаг соёл, түүх шастир, бурхан ухааныг дэлгэрүүлэгч байх,

4. Аливаа асуудалд хандахдаа шүүмжлэлтэй сэтгэгч, эрэгцүүлэн

тунгаагч байж, оновчтой таамаглалыг үндэслэлтэй дэвшүүлж, зөгнөн харагч байх,

5. Хүн төрөлхтний болон өөрийн үндэстний бүтээсэн үнэт зүйлийг хүндэтгэн биширч, ухамсарлан ойлгож мэдрэх чадамжтай, хүнлэг энэрэнгүй, эрхэмсэг ёс зүйтэй байх гэсэн үндэсний боловсролын хамгийн шилдэг шинж чанаруудыг төлөвшүүлсэн нөхцөлд орчин үеийн багшийн хэв маягийг төсөөлөн хүлцэж болох талтай байж болно.

Гэхдээ орчин үеийн багшийн хэв маягт тавигдах эн тэргүүний үнэт зүйлс нь:

"Хүн яаж суралцдаг тухай сэтгэл судлалын онолын үзэл баримтлалд суурилсан суралцах үйлийг зохион байгуулах ур чадварыг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ" гэж үздэг байна.

Багшийн үйл ажиллагаа эхний гурваас таван жилийн хугацаанд зөвхөн онолын энгийн мэдлэг олгох, мэдээлэл хүргэх зэргээр хязгаарлагдах байдал илүү ихээр давамгайлсан хандлагатай байх боловч цаашдаа туршлага хуримтлуулах явцдаа тоо баримт, түүхийн уялдаа холбоо, шинжлэх ухааны онол, зүй тогтол зарчим, ухагдахуун зэргийг ойлгуулах чиг хандлага давамгайлсан сургалтыг практик амьдралтай холбон явуулдаг болсноор илэрхийлэгдэж эхэлдэг байна.

Эндээс эхлэн багш хүнд сургалтыг шинжлэх ухааны онолын үндэслэлтэйгээр зохион байгуулах хэв маяг төлөвшиж эхэлдэг. Үүнтэй холбогдуулан Оросын эрдэмтэн Л.С.Выготский тэмдэглэхдээ: "Бодит хөгжлийн түвшингээс илүү үйл явдлыг урьдчилан таамагладаг сургалтыг шаардлага хангасан гэж үзнэ, учир нь сургалт өөрөө хөгжлийг хөдөлгөгч эх үүсвэр байдаг" гэжээ. (ВЭС.1984г.с -252)

Цэргийн шинжлэх ухаанд суралцагчдыг сургах нөхцлийг жишээ болгон авч үзье. Тухайлбал: цэргийн хэрэг, тэр тусмаа хил хамгаалах үйл ажиллагаанд дэвшүүлсэн санал, үйлдэл, үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон урьдчилан төлөвлөх, шийдвэр гаргахад үүдэн гарах үр дагаврыг урьдчилан харах нь амжилтанд хүрэх үндэс болдог.

Удирдах гэдэг нь урьдчилан харах гэсэн санаа бөгөөд цагийн байдлын мөн чанарын утга санаанд нэвтрэн орж гол үндсэн тулгуур асуудлыг тодорхойлоход оршдог. Тиймээс:

Урьдчилан харахын тулд мэдлэг байх хэрэгтэй, алдаа гаргахгүй байхын тулд урьдчилан харж чаддаг байх учиртай гэж авьяаслаг жанжнууд үзэж байлаа. Цэргийн гарамгай жанжин Францын их хаан Наполеон бичихдээ:

Хэрвээ би бүх зүйлд бэлтгэлтэй байгаа мэт санагдаж байвал энэ нь ямар нэг шийдэлд хүрэхийн тулд эхлээд удаан бодож тунгааж, тохиолдож болох асуудал, саад бэрхшээлийг урьдчилан харж таамаглаж чаддаг байсан нь ямар нэг сод ухаанаар бус харин миний сэтгэн бодох ухаанаар хийгддэг байсан. Тиймээс би үдийн хоолон дээрээ ч, театрт үзвэр үзэхдээ ч, шөнө сэрээд ч гэсэн ажиллахын тулд байнга бодож сэтгэдэг байсан гэжээ. Энхүү жишээ баримтаар орчин үеийн багшийн хэв маягийг илэрхийлэхийг хичээлээ.

АНУ-ын боловсрол судлаач Аллан Орнштейн суралцагчдад боловсрол эзэмшүүлэхэд чухам ямар хүчин зүйл илүү үр өгөөжтэй байдгийг мэдэх зорилгоор 200 гаруй сургуулиудад сонгон судалгаа явуулж хамгийн чухал

гэж үзсэн 11 ур чадварыг дараах байдлаар харуулсан байна.

Ур чадвар	Тодорхойлолт
Сурах, сургах үйл ажилллагааны баримжаа	Сурах, сургах үйл ажиллагааны ажил хэрэгч, үр бүтээлч байдал нь багшаас суралцагчиддаа зорилгоо хэрхэн ойлгуулж байгаагаар
Урам зориг, сонирхол	Багшийн эрч хүч, эрх мэдэл оролцооны хэр хэмжээгээр
Шууд сургалт	Багш нь суралцагчдын мэдлэг, чадварын өсөлтийг урьдчилан таамаглаж байгаагаар
Явц	Бэрхшээлийн түвшин, хэмжээ болон хичээлийн явц нь суралцагчдын чадвар сонирхолд хэр зэрэг нийцэж байгаагаар
Мэдээлэл	Багш нь оюутанд эерэг ба сөрөг мэдээллийг өгч байгаа хэр хэмжээгээр
Удирдлага	Багш аливаа зааварчилгаагүйгээр аудиторыг удирдан зохион байгуулах чадвартай байгаагаар
Асуулт	Багш янз бүрийн түвшний асуулт тавьж хариулт авч чадаж байгаагаар
Сургалтын цаг	Тухайн хийчээлд зарцуулах цагийг төлөвлөж, төлөвлөсөн хэмжээ нь уг материалыг бүрэн дүүрэн судалж болохуйц байгаагаар
Хөрвөх чадвар	Заах аргын хувьд уян хатан байдал, тухайн нөхцөлд өөрийн заах аргаа нийцүүлэх чадварын хэр хэмжээгээр
Зохион байгуулалт	Багшаас сургалтыг хэрхэн удирдан чиглүүлж чадаж байгаагаар
Шалгуур материал	Хичээлийн явцад ашиглагдаж байгаа шалгуур хэрэглэгдэхүүний түвшин ба ашиглаж байгаа байдлаар гэх мэт

Эдгээр 11 ур чадвар багшийн сургалтанд хандах хэв шинжийг илэрхийлж байна гэж дүгнэж болох юм.

Багшийн хэв маягийг эрдэмтэн судлаач Нейт, Гейжийн загварт илэрхийлснээр авч үзвэл: “Боловсролын инноваци”-д зохих ач холбогдолтой багшийн зан төлөвийн 4 багцыг тодорхойлсон байна.

Үүнд:

1. Багшийн оюутныхаа санаа байдлыг хүлээн авахад бэлэн байх болон эрүүл уур амьсгал бүрдүүлэх чадвартай байх,

2. Багш нь магтаал, дэмжлэг, урамшууллыг зөв ухаалаг хэрэглэх, бусдыг доромжлохгүйгээр хурцадмал үед алиа хошин байдлыг ашиглаж чадаж байх,

3. Багш өөрийн оюутныхаа санаа бодлыг тодотгох, хөгжүүлэх болон хүлээж авах чадвартай байх,

4. Багш нь шүүмжлэлтэй хандах, суралцагчдад шийтгэл хүлээлгэх, тэдний нэр

хүндийг хүлээн зөвшөөрөх чадвартай байх,

5. Энэхүү багц нь ардчилсан хэв шинжийн талаарх багшийн тухай төсөөллийг өгдөг байна.

Эндээс үндэслэн Нейт Гейк /эрдэмтэн судлаач/ орчин үеийн багш нарт зориулан амжилттай багшлах зарчим, аргуудыг дараах байдлаар толилуулсан байна. Үүнд:

1. Багш нь оюутан суралцагчдад өөрийн хувийн бодол хэрэгцээгээ хангах боломж олгож байх,

2. Багш нь оюутнууддаа онолын мэдлэг эзэмших явцдаа бие даан суралцах, өөр хоорондоо харилцах, харьцаанд анхаарал тавьдаг байх,

3. Суралцагддын бие даан хийх ажлыг дэмжихийн тулд бие даалтын ажлыг хэрэгцээтэй, сонирхолтой, бүтээлч байх хэлбэрээр өгч байх,

4. Дадлага, лабораторын ажлыг гүйцэтгүүлэх явцдаа шат ахиулах сургалтын хэлбэрийг сонгох болон асуулт тавихдаа түлхүүр буюу чиглүүлэх асуулт тавих аргыг ашиглаж байх гэсэн ойлголтуудыг багтаасан байгаа нь багшийн сургалтын үйл ажиллагааны явцад зайлшгүй чухал гэж үзэх ёс зүйн асуудлуудыг хөндсөн байна.

"Сайн шавь багшаасаа" гэсэн ойлголт хэзээ ч утгаа алдахгүй гэдэг нь үүнээс харагдаж байна. Энэхүү судалгаанаас үндэслэн орчин үеийн багшийн хөгжлийн одоогийн төлөв хандлага нь:

а/ Ёс суртахуун;

б/ Ёс зүй гэсэн дотоод цөм хэсэг;

Шинжлэх ухаан, техник, технологийн мэдлэг, чадварууд гэсэн гадаад хүрээний мэдлэг хэмээх хоёр гол хэсгээс тогтож байна. Багш нар мэдлэг эзэмшүүлэх явцдаа дотоод цөм хэсэг болох ёс суртахуун ба ёс зүйн боловсролыг орхигдуулж, харин гадаад тал болох академик чиглэлийг хэт ихээр давамгайлуулсантай холбогдуулан ёс зүйн асуудлууд үүсч байна гэж үзэж эдгээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үндсэн арга зам нь их дээд сургуульд багшийн ёс зүйн хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь зайлшгүй болохыг тэмдэглэх нь зүйтэй гэсэн дүгнэлт хийж байна.

Ийнхүү орчин үеийн багшийн хэв маяг, ёс зүйн асуудалд шинэлэг байр сууринаас хандах, сургах, сурах үйл ажиллагааны загварт өөрчлөлт орж байгаатай уялдуулан суралцах шинэ орчин, суралцагчийн шинэ загвар нь улам бүр бие даасан шинж төрхийг агуулж байна гэж үзэж болох юм.

Иймээс багшийн ёс зүйн боловсролын асуудал орчин үеийн багшийн дахин дизайнчлалын хүрээнд онцгой байр суурь эзлэх болоод байна.

Олон улсын боловсрол сангийн гүйцэтгэх захирал ноён Жак Корлей " 21-р зууны ёс зүй ба ёс суртахууны боловсролын хэрэгцээ шаардлага" гэсэн сэдвээр судалгаа хийсний үр дүнд орчин үеийн боловсролын зорилгыг авч үзэхдээ:

1. Мэдлэг соёлыг уламжлах;

2. Хувь хүний чадавхийг хөгжүүлэх;

3. Нийгмийн үүрэг роль, манлайллыг дээшлүүлэх чиглэлийг заасан байна.

Тэрээр ёс суртахуун ба ёс зүйн талууд нь боловсролын хоёр нэн чухал асуудлууд юм.

Энэ нь орчин үеийн багшийн ёс зүйн боловсролын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх чухал ач холбогдолтойг харуулж байна.

МАКАРОВЫН ГАР БУУНЫ ОНЦЛОГ

Хилийн сургуулийн Цэргийн хэргийн тэнхимийн багш, магистр, хошууч



Монгол Улсын Хил хамгаалах байгууллагын офицерын бүрэлдэхүүн Макаровын 9 мм-ийн гар бууг албанд ашигладаг. Тэдний үүрэг нь эзэмшсэн бууныхаа зориулалт, бүтэц, ажиллагааны онцлогийг сайн мэддэг, ямар ч нөхцөлд ашиглах, оновчтой бууддаг чадвартай байх ёстой.

Макаровын гар буу зохион бүтээгдсэн түүхийг авч үзвэл 1947-1948 онд ЗСБНХУ-д Зөвлөлтийн армийн офицерын бүрэлдэхүүнд зориулагдсан авсаархан хэмжээтэй гар буу зохион бүтээх уралдаант шалгаруулалт зарлагдсан байдаг. Тухайн үед Зөвлөлтийн армийн офицерын бүрэлдэхүүнд ашиглагдаж байсан "ТТ" болон "Наган" револьвер гар буунууд хуучирсан загварт тооцогдож эхэлсэн. Үүнээс гадна шугамын офицеруудад зориулж урт гол төмөртэй автомат гар буу (энэ шаардлагын дагуу хожим Стечкиний 9 мм-ийн автомат гар буу АПС шалгарсан), ахлах офицеруудад зориулж замгийн чөлөөт ухралтыг ашигладаг, автоматаар цэнэглэгдэх цохих буулгах механизмтай гар буу шалгаруулах шийдвэр гарсан.



Макаровын 9 мм-ийн гар буу

Шалгаруулалтанд Зөвлөлтийн зэвсэг зохион бүтээгч Ф.В.Токарев, С.Г.Симонов, С.А.Коровин, И.Я.Стечкин, К.А.Барышев, П.В.Воеводин, И.И.Раков, А.А.Климов, Г.В.Севрюгин, А.И.Лобанов, Н.Ф.Макаров нар зохион бүтээсэн гар бууны загвараа ирүүлж, шинэ загваруудтай хамт "Walther PP", "Mauser HSc", "Sauer 38H", "Beretta M1934", "FN model 1910/22" гар буунуудыг шалгаруулалтын туршилтанд оруулснаас Н.Ф.Макаровын зохион бүтээсэн гар бууны загвар бүх үзүүлэлтээрээ шилдгээр шалгарсан. Гэвч бүтэц, зохион байгуулалтад зарим өөрчлөлт, засвар хийхийг санал болгосноор зарим засварууд хийгдэж, 1951 онд ПМ тусгай тэмдэглэгээтэйгээр Зөвлөлтийн арми болон хууль сахиулах байгууллагуудын зэвсэглэлд хүлээн авсан.



Н.Ф.Макаров

ПМ гар буу нь бүтцийн хувьд ерөнхийдөө "Вальтер ПП" гар бууны загварыг хадгалсан боловч гар бууны бүтэц харьцахад эвтэйхэн, олон төрлийн зориулалттай эд ангиуд, онцгой нөхцөл байдалд гацаагүй, хэвийн ажиллах боломж нэмэгдэж, магазины сум өгөгчийн шүд, гал хамгаалагчийн асуудлыг зөв шийдвэрлэж, замаг баригчийг шинээр бүтээсэн.

Зөвлөлтийн армийн зэвсэглэлд орсноос хойш өнөөг хүртэл ашиглагдаж байгаа ПМ гар бууны халааг Макаровын сайжруулагдсан гар буу "ПММ", Ярыгины гар буу авч байгаа боловч ПМ гар буу нь өөрийн энгийн, найдвартай ажиллагаагаараа дэлхийн олон орны зэвсэглэлд одоог хүртэл үлдэж чадсан.

Макаровын системийн гар буугаар оновчтой буудахын тулд түүний бүтцийн болон байлдааны хүчин чадлын онцлогийг нарийн судлах шаардлагатай.

Сайн бэлтгэгдсэн буудагч нар 50 метр хүртэл зайд байг алдалгүйгээр устгах чадвартай байдаг. Анхны буудалтаар байг устгах нь цөөн тооны чадварлаг хүмүүсийн давуу чанар гэж ойлгож болохгүй. Гар буугаар буудах туршлагыг гар буутай албаны үүрэг гүйцэтгэх шаардлага гардаг хүн бүр эзэмших боломжтой.

Төрөл бүрийн, түргэн өөрчлөгдөх нөхцөлтэй байгустгах чадвартай байхын тулд тодорхой хэмжээний мэдлэг, чадвар, туршлагатай байх, түүнийгээ шаардлагатай үед зөв хэрэглэдэг байх шаардлагатай. Үүний тулд сайн боловсруулсан байгнын дадлага сургуулилалт (зөвхөн буудлагын байх шаардлагагүй) хэрэгтэй.

Буудлагын бэлтгэлийн чухал хэлбэр нь дасгал сургуулилалт болон буудлагын спортын уралдаан тэмцээн байдаг.

Гар буугаар буудах үеийн хүндрэл нь хүний бие болон гарын хөдөлгөөнтэй үед нэг гараараа бууг барин байнд хараалж, гох буулгахад оршдог. Үүнээс гадна нүднийхээ харааны орчинд бууны хараа хэрэгсэл, хараалж буй байгаа тогтоож барих маш хүндрэлтэй байдаг. Яагаад гэвэл хүний нүд 70 сантиметр зайд байрлах сэртгэртэй хараан хэрэгсэл, 25-50 метр зайд байрлах байг, ялангуяа гэрэлтүүлэг хангалтгүй, хүүхэн хараа өргөссөн үед нэгэн зэрэг тогтоож харах чадваргүй байдаг. Энэ тохиолдолд харааны тогтвортой байдал багасаж, хараа хэрэгсэл бүрэлзэж харагдах нь бууг байнд зөв хараалахад саад болж байдаг.

Гар буугаар буудах үед хүндрэлүүдээс гадна буудагч нараас гаргадаг зарим алдаанууд байдаг.

Буудлагын үр дүнд шууд нөлөөлдөг зарим алдаануудыг авч үзье. Үүнд:

1. Буудлагын үед зэвсгийн тогтвортой байдлыг хангах чадваргүй

зогсолт хэрэглэх

2. Буудлагыг удаашруулах.

3. Бууг байнд шагайх, гох буулгах үед хөдөлгөх

4. Анхаарлаа хараа хэрэгсэл, байнд төвлөрүүлж чадахгүй байх

5. Гар бууны гохны сул явалтын үед хүчтэй угзрах

6. Хараалах, гох буулгах үедээ амьсгалын зохицуулалтыг буруу хийх

7. Буудлагын чимээг хүлээх, айх, цочилтоос үүссэн нервийн өөрчлөлтөөс шалтгаалан хараалах, гох буулгах чадвар буурах зэрэг болно.

Буудагч нь буудлагын үед дээр дурьдсан алдаануудаас эхэндээ бүгдийг нь, дараа нь цөөн тооны алдааг гаргаад байдаг нь байг итгэл төгс устгаж, өндөр үр дүн үзүүлэхэд саад болдог.

Алдаануудаас гадна оновчтой буудах техникийг түргэн эзэмшихэд саад болдог хэд хэдэн шалтгаан байдаг. Тэдгээрээс ерөнхий хэдийг нь нэрлэвэл:

1. Буудлагын удирдагч /дасгалжуулагч/-ийн заах арга барил сул.

2. Буудлагын үед суралцагчийн гаргаж буй алдааг тухай бүр нь илрүүлэхэд шаардлагатай хэрэгсэл хуучирсан, эсвэл байхгүй.

3. Буу чанаргүй бүтээгдсэн, тусгалд ороогүй гэж бодох, буудлагыг зөв үйлдэж байгаадаа эргэлзэх зэрэг буудагчийн гаргадаг өөртөө итгэлгүй байдал ордог.

Буудлагын өмнө богино хэмжээний заавар авсан, эхлэн суралцаж буй буудагчийн буудлага үйлдэх ерөнхий байдлыг жишээгээр авч үзье:

“Хагас болон бүтэн хажуугаар зогсолт авч, гараа сунган буугаа байнд чиглүүлээд, биеийнхээ жинг баруун хөл дээрээ төвлөрүүлэн, байгаа хайж овоо харааг байны төвд барьж, амьсгаагаа гарган түгжиж, хөдөлж буй буугаа хараалж буй цэг дээрээ барихыг хичээж, буулгах гохон дээр удааналр дарна. Гохоо буулгахад тодорхой хугацаа зарцуулах бөгөөд, харин гар буу хараалах цэг дээр түр тогтох, эсвэл хөдөлж байны талбайгаас гарах тохиолдол ч байдаг. Амьсгаагаа удаан түгжих үед нүд ачаалласны улмаас нулимс гарч, овоо хараа бүрэлзэж харагдан, цуцсан гар чичирч, сул явалтын үед гохыг угзарч дардаг”.

Эхний амжилтгүй буудлагын дараа эхлэн суралцагч буудагч нь амжилттай буудахад өөрийгөө бэлтгэж индүү болон туухай зэргийг удаан барьж зогсох зэргээр тогтмол дасгал хийх шаардлагатай гэсэн дүгнэлтэнд хүрдэг.

Гэвч ийм дасгалууд нь үргэлж хүссэн үр дүнд хүргэдэггүй. 810 грамм жинтэй гар бууг 20-25 секунд барьж зогсоход булчингийн их хүч шаардагддаггүй. Хамгийн гол нь гарын хүч биш, харин их биеийн ерөнхий тогтвортой байдал байдаг.

Гар буугаар буудах зогсолт нь маш энгийн бөгөөд түүнд дасах шаардлагатай. Ингэхийн тулд өдөр бүр 20-40 минут зөв зогсолтыг давтах нь буудагчид дадал, хэвшил болдог.

Тогтвортой байдлаа хадгалж сурахын тулд нам доор татсан тросс болон олсон дээр тэнцвэрээ хадгалах, тэшүүрээр гулгах дасгалууд маш хэрэгтэй.

Ихэнх хүмүүс буудагчийн чадвар буудлага хийсэн тоо, зарцуулсан сумнаас хамааралтай гэж боддог. Гэвч энэ нь үнэнд нийцдэггүй.

Тодорхой үр дүнгүй олон удаа

буудахад буудагчийн анхаарал сарниж, олон алдаанууд хэвээр оршиж, үр дүн маш удаанаар өсөх магадлалтай..

Оновчтой буудлага – маш их бэлтгэл ажил, зөв зогсолт, бууг найдвартай зөв барих, зөв нэг хэлбэрийн шагайлга, гохыг тохирох мөчид нь зөв буулгасны үр дүн юм.

Гар буугаар буудах техникийг амжилттай эзэмшихийн тулд зөвхөн буудлага үйлдэх арга техникт суралцах нь хангалтгүй. Зэвсгийн байлдааны үзүүлэлт, эд ангийг сайн мэдэх, дотоод , гадаад баллистик, дасгал сургуулилалтын талаар зөв төсөөлөлтэй байх байх хэрэгтэй.

Макаровын системийн гар буу нь албаны үүрэг гүйцэтгэхэд зориулагдсан бөгөөд энэ шаардлагыг бүрэн хангадаг. Гэвч оновчтой буудахад зориулагдсан спортын гар буунуудтай харьцуулахад өндөр үр дүн үзүүлэхэд хүндрэл учруулдаг хэд хэдэн онцлогтой. Эдгээр онцлог нь доор дурьдсан байлдааны хүчин чадлын хэд хэдэн үзүүлэлтээс хамааралтай байдаг. Үүнд:

- Хараалах шугамын урт маш бага буюу 130 мм байдаг.
- Овоо хараа нь гол төмөртэй харьцуулахад хөдөлгөөнтэй замаг дээр суурилагдсан байдаг нь дараачийн буудлагыг үргэлжлүүлэн гүйцэтгэхэд хүндрэл учруулдаг.
- Гохыг буулгах хүч 2 кг буюу гар бууны жинтэй харьцуулахад өндөр байгаа нь гох буулгах үеийн бууны хөдөлгөөнгүй, тогтвортой байдалд нөлөөлж байдаг.
- Сумны хошуунд 315 м/сек анхны хурд олгодог маш хүчтэй дарин цэнэгтэй бөгөөд энэ нь бууны ухрах хөдөлгөөнд ихээр нөлөөлж байдаг.
- Хоосон явалтын зай 15 мм хүртэл байдаг нь гохны сул явалтын үед хэт яарах, буудлагыг хүлээх, анхаарал сарних байдлыг үүсгэдэг.
- Гар бууны үйлдвэрлэгдсэн олон хувь дээр буулгах гох нь сул хөдөлгөөнтэй үйлдвэрлэгдсэн байдаг нь нэг гар буугаар буудаж хэвшсэн буудагчид өөр буугаар буудаж амжилт гаргахад сөргөөр нөлөөлөх боломжтой.


Макаровын системийг гар бууны нягтралыг авч үзэхдээ, хэрэв 4 сумны тусгал 15 см диаметрийн тойрогт багтаж байвал хэвийн гэж тооцдог. Энэ тохиодолд тусгалын дундаж цэг нь байны төвөөс 5 см зайтай байж болно.

Иймд Макаровын гар бууг албанд ашигладаг алба хаагч нар нь бууны зориулалт, бүтэц, эд ангийг сайн мэдэхээс гадна, буудагчийн түгээмэл гаргадаг алдаа, тэдгээрийг засах арга, гар бууны байлдааны хүчин чадлын буудлагад нөлөөлөх онцлогуудыг нарийн судалж мэдэх шаардлагатай. Эдгээр онцлогуудыг нарийн судалж, буудах арга барил, техникийг зөв эзэмших нь гар буугаар оновчтой буудах чадварыг эзэмшихэд чухал нөлөөтэй байдаг.

ЦЭРГИЙН СЭТГЭЛ СУДЛАЛ

ХҮНДРЭЛТЭЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮЕ ДЭХ ХИЛЧДИЙН СЭТГЭЛ ЗҮЙН БЭЛТГЭЛ

Т.Баяраа. Хилийн сургуулийн Цэргийн сэтгэлзүйн тэнхимийн дэд профессор, докторант, дэд хурандаа



Сэтгэлзүйн бэлтгэл бол үйл ажиллагааны агуулга, мөн чанар, өвөрмөц онцлог, хэрэгжих тодорхой үр дүнг багтаасан ойлголт учраас албаны бэлэн байдлыг хангахад голлох үүрэг чиглэлтэй оролцдог.

Хамгийн ерөнхий байдлаар авч үзэх юм бол сэтгэл зүйн бэлтгэл нь албанд тохиолдож буй хүндрэл бэрхшээлийг даван туулж, тавьсан зорилгоо амжилттай хэрэгжүүлэхэд бие бүрэлдэхүүн сэтгэл зүйн хувьд хэр бэлтгэгдсэн байдлыг тодорхойлох үйл явц юм.

Түүний үндсэн зорилго нь хилчдэд хуулиар хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж, албаны хүндрэл бэрхшээлийг даван туулахад шаардлагатай сэтгэлзүйн шинж чанарыг хилчдэд төлөвшүүлэхэд оршино.

Энэ бүхнээс үзвэл сэтгэл зүйн бэлтгэлийн үйл ажиллагаа нь нэгэн зэрэг явагдаж, хоорондоо нягт холбогдсон дараах онцлогийг нь харгалзан үзэх нь чухал юм. Үүнд:

А. Хилчдийн сэтгэл зүйд гаднаас зорилго чиглэлтэй нөлөөлөх ажиллагаа /төр, удирдагч, цэргийн хамт олон, хичээл сургалт явагдах нөхцөл байдал, цагийн байдал гэх мэт/

-Энэ нь хичээлийн агуулга, төлөвлөлт, зохион байгуулалт, арга зүй болон сэтгэл зүй мэдээлэл соёл хүмүүжлийн арга хэмжээгээр дамжин хэрэгждэг. Мөн шаардлагатай сургалтын материаллаг бааз, төхөөрөмж, дуурайлган үзүүлэх хэрэгслийг бий болгох гэх мэт

Сэтгэлзүйн бэлтгэлийн мөн чанар нь хилчдийг сургаж, хүмүүжүүлэхэд чиглэгдсэн байдаг.

Түүний агуулга нь хилчдийг практик ажилд татан оролцуулах, бодит цагийн байдлын үед үүсэх аливаа хүндрэлийг даван туулахад бэлтгэхэд чиглэгдсэн сэтгэлзүй мэдээлэл соёл, хүмүүжлийн ажлыг бие бүрэлдэхүүний дунд зохион явуулснаар тодорхойлогддог.

Энэ нь хичээл сургалт болон хүмүүжлийн ажлын нэгдмэл тогтолцоо бөгөөд хилчдэд сэтгэл зүйн бэлтгэлийг олгоход чиглэгддэг.

Б. Янз бүрийн түвшинд илэрч байгаа хилчдийн сэтгэл зүйн

өөрчлөлтийг хянах ажиллагаа. Энэ нь хүндрэлийг даван туулж, өмнөө тавьсан зорилгоо амжилттай хэрэгжүүлэхэд өөрийн боломж нөхцөл байгаа эсэхийг тодорхойлно.

Сэтгэл зүйн үйл ажиллагааны мөн чанар нь хүндрэлтэй байдлыг өөртөө итгэл үнэмшилтэйгээр даван туулахад шаардлагатай сэтгэлзүйн шинж чанарыг хилчдэд төлөвшүүлэхэд оршдог.

Түүний агуулга нь янз бүрийн түвшинд илэрч байгаа сэтгэцийн өөрчлөлтийг хянахад чиглэгддэг.

Сэтгэлзүйн бэлтгэлийн агуулга нь хичээл сургалт болон тодорхой үүрэг даалгаврыг биелүүлэхийн өмнөх үед илрэх тухайн хүний сэтгэцийн байдал, шинж чанараар тодорхойлогддог.

В. Өөрийгөө хянаж удирдах ажиллагаа, /Энэ нь хүндрэлийг хэрхэн даван туулах талаар урьд олж авсан мэдлэг, туршлага дээр үндэслэн өөрийн сэтгэл санаа зан байдлаа тохируулан удирдахад өөрийгөө хэр идэвхжүүлж зоригжуулсан байдлаар тодорхойлогдоно.

Сэтгэлзүйн бэлтгэлийг нэгдмэл шинжээр нь 3 хуваан авч үздэг.

1. Ерөнхий мэргэжлийн сэтгэл зүйн бэлтгэл –Энэ нь ямар ч нөхцөл байдлын үед тавигдах үүрэг зорилтыг мэргэжлийн өндөр түвшинд биелүүлэхэд шаардагдах сэтгэлзүйн бэлтгэлийн түвшинг бүрдүүлж түүнийг дээшлүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа юм.

2. Сэтгэлзүйн тусгай бэлтгэл -Энэ нь сургалт, албаны үйл ажиллагааны үед тохиолдох хүндрэлийг даван туулахад бэлтгэх үйл ажиллагаа юм.

3. Зорилтот сэтгэл зүйн бэлтгэл –Энэ нь тодорхой үүрэг зорилтыг хэрэгжүүлэхийн тулд өөрийн бүхий л үйл ажиллагаа , авьяас чадвараа дайчлан өөрийгөө бэлтгэх үйл ажиллагаа юм.

Бодит цагийн байдалд ойртуулсан хичээл сургалт явагдах үед хилчдэд сэтгэл зүйн бэлтгэлийн өмнөх үе буюу сэтгэлзүйн тогтвортой байдал үүсч бий болдог.

Өөрөөр хэлбэл энэ нь хилчид хүндрэлтэй байдлыг даван туулах, тавигдсан үүрэг зорилтыг амжилттай биелүүлэх боломж нөхцлийг тодорхойлох сэтгэцийн шинж чанарууд юм.

Хүндрэлтэй нөхцөл байдлын үе дэх сэтгэцийн эдгээр шинж чанарууд нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:.

-Мэдлэг. Янз бүрийн нөхцөл байдлын үед үүсэх хүндрэл бэрхшээлүүд, түүний хилчдийн сэтгэлзүйд үзүүлэх нөлөө, сэтгэцийн үйл ажиллагаагаа удирдах арга барил, түүнчлэн хүндрэлтэй байдлыг даван туулах өөрийн боломж нөхцөл хэр байгаа эсэхийг тодорхойлох талаар зохих мэдлэг эзэмшсэн байх

-Дадлага, чадвар. Энэ нь хүндрэлийг даван туулах, сэтгэцийн үйл ажиллагаагаа удирдах талаар зохих дадлага, чадвартай байх, тавигдсан үүрэг зорилтыг биелүүлэхэд өөрийн хүч чадал, боломж нөхцлөө тодорхойлж сурах

-Үзэл бодол, итгэл үнэмшил, сэдэл хандлага, Энэ нь хүндрэлийг даван туулж тавигдсан үүрэг зорилтыг биелүүлэх явдал нь хэрэгжих боломжтой бөгөөд заавал биелүүлэх ёстой зүйл гэж үзэх

-Хувийн шинж чанарууд. Энэ нь хүндрэлийг даван туулж, сэтгэцийн үйл ажиллагаагаа удирдахад шаардагдах

Хилчдийн албаны үйл ажиллагаанд нөлөөлж байгаа хүчин зүйлүүд	Хүндрэлтэй байдлын үед зайлшгүй эзэмшсэн байх шаардлагатай шинж чанарууд
Аюул занал /бодит болон болзошгүй/	Эр зориг, өөртөө итгэлтэй, шийдэмгий байх, эрсдлийг давах чадвар
Гэнэтийн, шинэлэг тодорхой бус нөхцөл байдал үүсэх	Тэсвэр тэвчээр өөртөө итгэлтэй байх
Мэдээ, мэдээлэл болон цаг хугацааны хомсдол бий болох	Санаачилгатай, хурдан оновчтой шийдвэр гаргаж сурах
Гаргасан шийдвэр, түүнийгээ биелүүлснийхээ төлөө хариуцлага хүлээх	Хариуцлагатай байх Бие даасан байх
Тавигдсан үүрэг зорилтыг биелүүлэхэд шаардагдах нөхцөл боломж бүрдэхгүй байх /нийгэм, мэргэжил, биеийн гэх мэт/	Тууштай байх Тэсвэр тэвчээр Сэтгэл санааны тогтвортой байдал

сэтгэл зүйн тогтвортой шинж байдлыг хэлнэ.

Сэтгэцийн эдгээр шинж чанарууд нь хүндрэлтэй нөхцөл байдлын үед хилчдийн сэтгэл зүйд нөлөөлж байгаа хүчин зүйлээс урган гардаг.

Хүндрэлтэй байдлыг даван туулах үйл ажиллагаа нь сэтгэл зүйн бэлтгэлийн агуулга, чиглэлийг тодорхойлж, янз бүрийн цагийн байдал өгөгдсөн үед явагдах сургалтын тоглолт, даалгаврыг офицерын удирдлага дор хийж гүйцэтгэх замаар хэрэгждэг.

Сэтгэцийн дээрх шинж чанар нь янз бүрийн нөхцөл байдлын үед үүсэх хүндрэлийг онолын түвшинд судлан мэдэж, бодит амьдрал дээр хэрхэн даван туулснаар тодорхойлогдох бөгөөд хилчдийн сэтгэл зүйн бэлтгэгдсэн байдлыг давхар нотолдог.

Хилийн анги салбарын сургалт, албаны үйл ажиллагааны хүрээнд тавигдсан үүрэг зорилтыг биелүүлэх ажлын бэлтгэлийг хангах явцад тодорхой хүндрэл бэрхшээл гардаг.

Тодорхой үүрэг даалгаврыг шууд хэрэгжүүлэхийн өмнө хилчдэд сэтгэл зүйн хувьд хэр бэлтгэгдсэн байдлаа харуулдаг. Энэ нь хүндрэлийг даван туулахад хилчдийн сэтгэл зүйн идэвхтэй байдал , үүрэг зорилтоо гүнзгий ухамсарласан байдалтай шууд холбоотой бөгөөд тавигдсан үүрэг зорилтоо чанартай, үр дүнтэй биелүүлэх боломж нөхцлийг бас хангаж өгдөг.

Офицерын сэтгэл зүйн бэлтгэлийг дараах үндсэн элементүүдэд хуваан авч үзэж, үнэлж дүгнэж байх нь зүйтэй. Үүнд:

-Сэдэл тэмүүлэл- Энэ нь хүндрэлийг даван туулж, тавигдсан үүрэг зорилтыг амжилттай биелүүлэх хүсэл эрмэлзэлтэй байх, саад бэрхшээлийг давж гарснаа биеэрээ мэдрүүлэх, эр зоригтой, шийдэмгий байдлаа бусдад харуулах, хамт олны дунд би хэн бэ гэдгээ батлан харуулах хүсэл эрмэлзэлтэй байх гэх мэт

-Танин мэдэхүйн–Энэ нь хүндрэлтэй байдлын үед учирч болзошгүй хүндрэл

бэрхшээлүүд, түүнийг зайлшгүй даван туулж гарах шаардлага, урьд олж авсан туршлага дээрээ үндэслэн сэтгэцийн үйл ажиллагаагаа удирдах өөрийн боломжийг үнэлж дүгнэх талаар тодорхой ойлголттой болсон байх

-Сэтгэлхөдлөлийн-Энэньтавигдсан үүрэг зорилтыг биелүүлж, хүндрэлийг даван туулахад шаардлагатай сэтгэл зүйн бэлтгэл ба өөрийн авьяас чадварт итгэж, эсвэл эргэлзэж байгаагаа сэтгэл зүрхээрээ мэдрүүлэх

-Эр зоригийн Энэ нь бэрхшээл саадыг давж гарах зоримог шийдэмгий байдал, гаргасан шийдвэр, түүнийг биелүүлснийхээ төлөө хүлээх үүрэг хариуцлагаа ухамсарласан байх .

Сэтгэл зүйн бэлтгэлийн элемент нэг бүр нь хүндрэлийг даван туулах сэтгэл зүйн идэвхтэй байдлыг тусгаж, хилчдийн зан төлөвийг тодорхойлохоос гадна тавигдсан үүргийг биелүүлэхэд та бэлэн байна уу? эсвэл бэлэн бус уу? гэдгийг гэрчилдэг.

Сэтгэлзүйн бэлтгэлийн үйл ажиллагаа нь дараах байдлаар хэрэгжинэ .Үүнд:

Хилчдэд албаны үйл ажиллагааны онцлог болон тавигдсан үүрэг зорилтыг биелүүлэхэд тохиолдох хүндрэл бэрхшээл, түүнийг хэрхэн даван туулах арга замын талаар тодорхой ойлголт, мэдээлэл өгөх нь чухал байдаг.

Хичээл сургалтын явцад өгөгдсөн цагийн байдлын ерөнхий зураглал гаргаж, сургалт албаны чиглэлээр хийгдэх үүрэг даалгаврыг биелүүлэх үйл явцыг оюун санаандаа загварчилж сурах хэрэгтэй.

Өөрөөр хэлбэл өгөгдсөн цагийн байдал нь хилчдийн ухамсарт тусгагдаж, тэднээс сэтгэцийн тодорхой хариу үйлдлийг хийхэд хүргэдэг.

Иймэрхүү нөхцөл байдлын үед хилчид идэвхтэй байж, тохиолдох аливаа саад бэрхшээлийг амжилттай даван туулдаг.

Хичээл сургалт ачаалал ихтэй, тодорхой эрсдэл, аюул заналыг байнга үүсгэж, гэнэтийн, тодорхой бус нөхцөл байдалд явагдах эхний үед бие бүрэлдэхүүний нэлээдгүй хэсэг нь сэтгэл санаа нь зовж түгшсэн байдал ажиглагддаг.

Хүндрэлийг даван туулж байж, тодорхой амжилтанд хүрэхийн ач холбогдлыг хилчдэд тайлбарлан ойлгуулснаар хүндрэлтэй нөхцөл байдлын үе дэх тавигдсан үүрэг зорилтоо амжилттай биелүүлэх хилчдийн хүсэл эрмэлзэл нь тогтвортой болдог.

Өгсөн үүрэг тушаалыг биелүүлж, тохиолдох хүндрэл бэрхшээлийг даван туулах нь зайлшгүй юм гэдгийг өөрөө ухамсарлан ойлгож, түүндээ дүн шинжилгээ хийж сурах юм бол хилчдийн хүсэл эрмэлзэл нь улам нэмэгдэж байдаг.

Ажиллах урам зориг, хүсэл эрмэлзлэлийг цааш нь бадрааж байх тусам хилчид тавигдсан үүрэг зорилтоо түүртэлгүй хөнгөн биелүүлж, хүндрэлийг даван туулахад өөрийн хүч чадлаа дайчлан ажиллах боломж нөхцөл бүрдэж байдаг.

Шинэ аюул занал, оюун ухааны хүндрэлийг үүсгэсэн нөхцөл байдлын үед хийгдэх дасгал сургалтыг олон удаа хийлгүүлсний үр дүнд хүндрэл бэрхшээлийг даван туулах талаар урьд олж авсан мэдлэг, туршлага нь нэмэгдэж, сэтгэцийн үйл ажиллагаагаа удирдах байдал нь тогтвортой болж

эхэлдэг.

Энэ байдлыг харгалзан үзэж, сэтгэцийн үйл ажиллагааг удирдах талаар анхан шатны мэдлэг, чадварыг эзэмшиж, хүндрэлийг даван туулж, байж тавигдсан үүрэг зорилтыг биелүүлэх боломжтой зүйл гэдэгт бүрэн итгэл үнэмшилтэй болж ирдэг.

Мөн аажмаар үүсэх сэтгэлийн түгшүүр, айдас, өөртөө эргэлзэх, итгэлгүй болох зэрэг сэтгэлзүйн сөрөг үзэгдлээс хилчдийг ангид байлгах нь чухал үүрэг байдаг.

Бодит цагийн байдалд ойртуулж, зохиомлоор үүсгэсэн эрсдэл аюул заналын үед хэрхэн дасан зохицох байдлыг тооцож, сэтгэцийн үйл ажиллагаагаа зөв удирдаж сурсны үр дүнд хилчдэд үүсэх аливаа сэтгэлзүйн зүйн сөрөг үзэгдлүүд аажмаар багасаж, сэтгэл санааны байдал нь тогтвортой байх бөгөөд энэ үед өөрийгөө хэт их чагнах, хянах явдал үгүй болж, эхлээд хийгдэх ажлынхаа хамгийн чухал шаардлагатай хэсгийг, харин дараа нь эзэмшсэн туршлага, мэдлэг чадварынхаа үндсэн дээр хийгдэх ажлаа бүхэлд нь чанартай хийж гүйцэтгэх гэсэн хүсэл тэмүүлэлд хүргэдэг байна.

ХИЛЧИН БА ХУУЛЬ

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА, ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

С.Оюунчимэг. ХСИС-ийн ЭЗНУС-ийн Эрх зүйн онолын тэнхимийн ахлах багш, магистр, ахмад



Улс орны аюулгүй байдал юунаас эхлэх вэ? гэвэл – Улсын хилээс эхэлдэг гэдгийг хилчин бүхэн хэлнэ. Энэхүү асуудлын Монгол улсын хил, хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах эрхэм үүрэг хариуцлага Хил хамгаалах байгууллагад ноогдож ирсэн түүхэн уламжлалтай билээ.

Хил хамгаалах байгууллагын түүхэн хөгжлийн явцад хилчин офицеруудын эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх асуудлыг үе үеийн хил хамгаалах үйл ажиллагаанд олон талаас судлан үзэж ирсэн байна.

Орчин үеийн нөхцөлд цэргийн сургалт бэлтгэлтэй уялдсан судалгаа шинжилгээний хандлага, үндсэн тулгуур байр, роль нь голчлон сэтгэл судлалын шинжлэх ухаантай уялдан үндэслэгдэж ирсэн байдал харагдаж байна. Харин хилчдийн үйл ажиллагааны эрх зүйн нөхцөл байдлыг хөндсөн бүтээлүүд ховор байгаа нь Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг зөвхөн улсын хил хамгаалах албаны үйл ажиллагааг явуулахад шаардлагатай хууль, эрх зүйн актуудын хэмжээнд хязгаарлан авч үзэх байдлаар ханддаг байдал ажиглагдаж байна. Тиймээс эрх зүйн мэдлэгтэй байх асуудал нь өргөн хүрээтэй судалгаа шинжилгээний ажил явуулах болон хилчдийн мэргэжлийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан судлах замаар Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын эрх зүйн мэдлэгийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлон гаргаж ирэх нь нэн чухал хэрэгцээ болж байна гэж үзэж байна.

Хүний аливаа үйлдэл, үйл ажиллагаа нь хүрээлэн байгаа бодит нөхцөл байдалтай харилцан уялдаж холбогдохгүй байхын аргагүй бөгөөд энэ нь тодорхой зорилго чиглэлтэй, идэвхтэй нөгөө талаас зөрчилдөөнт байдалд оршин үйлчилж байдаг гэж эрдэмтэн судлаачид үздэг байна. Эндээс мэргэжил нь хөдөлмөрийн үйл ажиллагааны хувьд тодорхой бүтцүүдийг агуулж байдаг гэжээ. Тухайлбал:

- Хөдөлмөр үйл ажиллагааны эцсийн үр дүнд хүрэх зорилго,

зорилтуудыг төсөөлөн харах

- Хөдөлмөрийн явцад зайлшгүй шаардлагатай орчин нөхцлийг бүрдүүлэх
- Хөдөлмөрийн хэрэгслэлийн систем бүхий нөхцлийг хангуулах
- Мэргэжлийн албанд шаардлагатай үүрэг хариуцлагын системийг тогтоох
- Эрх зүйг хэрэглэх, шаардагдах системийг бий болгох гэх мэт өргөн хүрээг хамарч байдаг.

Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын мэргэжлийн үйл ажиллагааны эцсийн үр дүн, зорилгын талаарх бүтэн байдлыг хамгаалах үйл ажиллагааны онцлог, хилчдийн мэргэжлийн үйл ажиллагааны өдөр тутмын хэм хэмжээг тогтоон тодорхойлсон "Монгол улсын үндсэн хууль"-аас эхлээд түүнтэй нийцүүлэн баталгаажуулсан бусад хууль тогтоомж, Монгол улсын хил хамгаалах дүрмүүд, тушаал, захирамж, заавар, эрх зүйн бусад актууд, мөн түүнчлэн ирээдүйн хилийн алба- хууль сахиулагч мэргэжлийн стандартуудад тусгасан байна. Гэхдээ зөвхөн эдгээр баримт бичгүүдийн хүрээнд Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын үйл ажиллагааны эцсийн шийдвэрийг хязгаарлан авч үзэж үл болно.

Тийм болохоор Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын мэргэжлийн арга туршлага, улсын хилийн цагийн байдлыг урьдчилан харж мэдрэх зөн совин, хилч сэтгэлгээ, ур чадвараа дайчлан үүрэг хүлээх цогц чадамж зэрэг нь хилчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд зайлшгүй байх эрхэм чанарууд болдог байна.

Эндээс Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын хөдөлмөрийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь юу вэ? гэдгээс эхлэх нь нэн хэрэгцээтэй гэж үзэх нь зүйд нийцэх болно. Энэ нь хилчдийн хувьд:

1. Хилийн албаны үйл ажиллагааг зохион байгуулах
2. Хилийн анги, салбарын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулах
3. Цэргийн хамт олныг удирдах
4. Улсын хил хамгаалах үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн харилцааны олон талт үйлдэл бүхий бодит орчин нөхцөлд албан үүргээ гүйцэтгэх гэх мэт асуудлууд хамаарагдаж байна.

Тэгвэл: - Мэргэжлийн үйл ажиллагааны хэрэгсэл нь юу вэ? Орчин үеийн нөхцөлд энэ нь:

- Орчин цагийн мэдээллийн хэрэгслийг чадварлаг ашиглах
- Улсын хил хамгаалалтын инженер техникийн хэрэгслүүдийг ашиглах
- Удирдлагын холбооны болон автоматжуулагдсан системийг ашиглах г.м

Нөгөө талаар: Хил хамгаалах албан хаагчдын гадаад хүчин зүйлүүд болохуйц эрх зүйн харилцааны болон үг ярианы соёл, эрх зүйн хандлага, ёс зүй, эрх зүйн мэдлэг, тэдгээрийг өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаандаа хэвшүүлэн хэрэглэх арга барил зэрэг нь мэргэжлийн үйл ажиллагааны бас нэн чухал хэрэгсэл болдог байна. Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын эрх зүйн систем нь хэзээ хаана яаж илрэн гарах вэ? гэдгийг судлан шинжлэх замаар эрх зүйн мэдлэгийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох нь илүү үр дүнтэй гэж үзэж байна.

Тухайлбал:

- ХХБ-ын эрх зүйн үндсэн асуудлыг өргөн хүрээтэй судлах
- ХХБ-ын хариуцан явуулдаг үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох
- ХХБ-ын үйл ажиллагаанд оролцдог иргэд, олон нийтийн байгууллагын эрх зүйн асуудлыг боловсронгуй болгох
- ХХБ-ын албан хаагчдын эрх зүйн боловсролыг байнга дээшлүүлэх
- Хил хамгаалах албанаас чөлөөлөгдсөн албан хаагчдын эрх зүйн байдлыг зохицуулах асуудлыг шинэчлэн авч үзэх
- ХХБ-ын улсын хил хамгаалах үйл ажиллагаа явуулж байгаа албан хаагчдын мэргэжлийн үйлдэл, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулах
- Улсын хил хамгаалах үйл ажиллагааны санхүүгийн хангалтын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох гэх мэт арга хэмжээнүүд нь эргээд хилчдийн эрх зүйн мэдлэгийн хэрэгцээ, шаардлага зайлшгүй чухал болохыг нотлон баталгаажуулах шаардлагатайг харуулж байгаа юм.

Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын эрх зүйн мэдлэгийн хэрэгцээ шаардлага өнөөгийн нөхцөл юунаас урган гарч байна вэ? дараах асуудлыг хөндөх нь чухал болж байна гэж үзэж байна. Үүнд:

1. ХХБ-ын үйл ажиллагааны орчин үеийн нөхцөл байдлыг авч үзвэл юуны өмнө нийгмийн амьдралын бүхий л хүрээнд гарч буй өөрчлөлт шинэчлэлтүүд нь хилчдийн эрх зүйн мэдлэгийг сайжруулах үндсэн нөхцлийг бүрдүүлж байна.

2. Хил орчмын нутаг дэвсгэр дэх нийгмийн амьдралыг удирдан зохион байгуулдаг засаглалын бүтэц, зохион байгуулалт, орон нутгийн ард иргэдийн сэтгэл зүйн болон эрх зүйн орчин өөрчлөгдөх хөгжих тусам хил хамгаалах албаны үйл ажиллагааны эрч хүч, цар хэмжээ өргөжин тэлж, улмаар хилчдээс эрх зүйн өргөн хүрээний мэдлэг, боловсролтой байхыг шаардаж байна.

3. Орчин үеийн нөхцөл байдал Хил хамгаалах байгууллагаас улсын хил хамгаалах өдөр тутмын үйл ажиллагаа дан ганц өөрийн хүч хэрэгслээр явуулах бус нийгмийн харилцааны идэвхтэй үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн бодит орчин нөхцөлд тохирсон бүх шатны олон чиглэлийг байгууллага нэгжүүдтэй босоо болон хэвтээ тэнхлэгт харилцан хамтран үүрэг гүйцэтгэх зайлшгүй шаардага үүдэн гарч байна.

4. Монгол орны нийгмийн хөгжлийн эрч хүч, хурд, шинэчлэлт өөрчлөлтийн стандарт бус нөхцөл байдлаас хамааран Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын ёс зүй мэргэжлийн ур чадвар, чадамж, албаны үйл ажиллагааны хэв шинжийг өнөөгийн эрх зүйн бодит байдалд уялдуулан хөгжүүлэх чиглэлээр шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааны ажил явуулах үүднээс хилчдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх нь чухал болж байна.

Эдгээрээс үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын эрх зүйн байдлын үндэс, эрх зүйн мэдлэг, боловсролын хэрэгцээг үндэслэн судалгаа, шинжилгээний өргөн хүрээтэй ажил явуулах

2. Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааны олон талт арга

хэлбэрүүдийн эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, боловсруулах асуудлыг хөндөж хэрэгжүүлэх

3. Эрх зүйт төрийн тогтолцоотой орчин үеийн нөхцөл байдалд уялдсан "Эрх зүйн мэдлэг эзэмшүүлэх", "Эрх зүйн мэдлэгт тулгуурласан ёс зүйг төлөвшүүлэх" мэргэжлийн загвар бүхий тогтолцооны агуулга, мөн чанарыг харуулсан ном, гарын авлага, хялбаршуулсан кино, зохиол бүтээлийг хөгжүүлэхэд анхаарах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг хийж болох юм.

ГЭМТ ЭТГЭЭДИЙН ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭНИЙ ДАРААХ ЗАН БАЙДАЛ ТҮҮНИЙ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН УЧИР ХОЛБОГДОЛ

ХСИС-ийн ХСУА-ийн АБУСПБагийн ахлах багш, докторант, хошууч Г.Лхагвамаа



LEGAL CONSEQUENCES OF CRIMINAL CONVICTIONS

Abstract

This article explores legal consequences of criminal convictions in the criminal law of Mongolia. Specially, it examines theoretical background and its nature as well as types of the criminal convictions. Moreover this research attempts to define the criminal behavior by using more appropriate terminology in criminal law.

The author explore respective provisions reflected in the criminal code of 2002 in Mongolia.

Хураангуй

Энэхүү өгүүллээр гэмт этгээдийн гэмт хэрэг үйлдсэний дараах зан байдал түүний эрүүгийн эрх зүйн учир холбогдлыг судалсан болно. Ялангуяа гэмт этгээдийн гэмт хэрэг үйлдсэний дараах зан байдал, онцлог шинж болон гэмт этгээдийн гэмт хэрэг үйлдсэний дараах зан байдлын ангилал тэдгээрийн онолын үндэслэлийг тодорхойлоход чиглэгдсэн болно. Түүгээр ч барахгүй гэмт этгээдийн гэмт хэрэг үйлдсэний дараах зан байдал, түүнийг ангилах шалгуур үндэслэлийг онолын үндэслэлтэй тодорхойлон тогтоох төдийгүй эрүүгийн эрх зүйн хэрэгжилтэд зөв зохистой нэр томъёог хэрэглэх явдал нь Монгол улсын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан, эрүүгийн эрх зүйн шинэчлэлтэд хэрхэн нөлөөлөх нөлөөллийг тодорхойлж, уг асуудал нь 2002 оны Монгол улсын эрүүгийн хуульд хэрхэн тусгагдсан байдлыг авч үзсэн байна.

Key words: legal behavior (эрх зүйн зан үйл, зан байдал), Legal status (эрх

зүйн байдал), criminal behavior (гэмт этгээдийн зан байдал), confession (хэргээ хүлээх), recoupment (хохирлоо нөхөн төлөх) legal consequences of convictions (эрүүгийн эрх зүйн үр дагавар)

1. Оршил

2. Гэмт хэрэг үйлдсэний дараах гэмт этгээдийн зан байдал

3. Монгол улсын эрүүгийн хууль дах гэмт хэрэг үйлдсэний дараах гэмт этгээдийн зан үйлийн эрүүгийн эрх зүйн учир холбогдол

4. Дүгнэлт

1. Оршил

Гэмт хэрэг үйлдсэний дараах гэмт этгээдийн зан байдлын тухай асуудал нь эрүүгийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах тодорхой төрлийн харилцаа юм.

Гэмт хэрэг үйлдсэний дараах гэмт этгээдийн зан байдал нь зөвхөн материаллаг эрх зүй болох эрүүгийн эрх зүй төдийгүй эрүүгийн процессын эрх зүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хувьд ач холбогдолтой ойлголт бөгөөд шүүн таслах ажиллагааны хүрээнд шударга ёсны зарчмыг хангах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад чухал үүрэгтэй.

Монгол улсын эрүүгийн эрх зүйн тулгуур зарчмын нэг бол шударга ёсны зарчим бөгөөд түүний гол агуулга нь Эрүүгийн хуулийн 6-р зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдсон этгээдэд шүүхээс оногдуулсан ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь түүний үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор шинж чанар, хэр хэмжээ, уг этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд тохирсон байх явдлаар илэрдэг.

Монгол улсын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд гэмт этгээдийн гэмт хэрэг үйлдсэний дараах зан байдал түүний эрүүгийн эрх зүйн үр дагавар, гэмт этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээнд хэрхэн нөлөөлөх асуудлыг төдийлөн тусгайлан судлаагүй явж иржээ.

Гэхдээ уг асуудлыг эрүүгийн хуулийн урамшууллын хэм хэмжээний хүрээнд тодорхойлж ирсэн бөгөөд өөрөөр хэлбэл гэмт хэргээ илчлэн ирэх, гэмт хэргийн улмаас хохирсон хохирлыг нөхөн төлөх байдлаар голчлон авч үзэж байсан байна.

Гэвч өнөө үед эрүүгийн эрх зүйн өөрчлөлт шинэчлэлт, эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжилтэй холбоотойгоор хохирогчтой эвлэрсэн, гэмт хэргийг илрүүлэхэд идэвхитэй тусламж, дэмжлэг үзүүлсэн, эсвэл гэмт хэрэг шинээр үйлдэх, захиргааны зөрчил гаргах, эрүүгийн хуулиар хүлээлгэсэн үүргийг биелүүлэхээс зайлсхийх зэрэг бусад төрлийн нөхцөлүүдийг хамааруулах болсон байна.

Энэ нь гэмт этгээдийн гэмт хэрэг үйлдсэний дараах зан байдал түүний эрүүгийн эрх зүйн учир холбогдлыг Монгол улсын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны эргэлтэнд оруулан онолын хувьд шинээр тодорхойлох, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлах шаардлагыг эрдэмтэд судлаачдын өмнө бий болгож байна.

2. Гэмт хэрэг үйлдсэний дараах гэмт этгээдийн зан байдал

Эрүүгийн эрх зүйд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, ялыг ялгамжтай оногдуулахад зайлшгүй харгалзах нэг нөхцөл байдал нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн зан байдал мөн.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн зан байдал гэдэгт гэмт хэрэг үйлдэхээс өмнөх, гэмт хэрэг үйлдэх үеийн буюу үйлдсэний дараах хууль ёсонд нийцсэн болон хууль ёсны эсрэг чиглэсэн, тодорхой эрх зүйн учир холбогдол бүхий гэмт этгээдийн зан байдал хамаарна.

Гэмт этгээдийн гэмт хэрэг үйлдсэний дараах зан үйл нь гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий хэд хэдэн салбар эрх зүйд тодорхой хууль цаазын учир холбогдолтой болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Тухайлбал: Захиргааны эрх зүй (цагдаагийн эрх зүй)-д хорих газраас суллагдсан этгээдэд захиргааны хяналт тавих, тэднийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээг сонгон хэрэглэх, гэмт хэргийг нотлох, мөрдөн байцаалтын хойшлуулшгүй ажиллагааг явуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааг хуулийн дагуу хэрэгжүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйд ялтанд ял эдлүүлэх, ялтантай ажиллах, тэднийг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэхэд гэмт хэрэгтний гэмт хэрэг үйлдсэний дараах зан байдал ач холбогдолтой байдаг.

Гэхдээ бид энэ удаад гэмт этгээдийн гэмт хэрэг үйлдсэний дараах зан байдал, түүний эрүүгийн эрх зүйн учир холбогдлын талаар авч үзэх болно.

Эрүүгийн эрх зүйд гэмт этгээдийн гэмт хэрэг үйлдсэний дараах зан байдал нь дээрхи салбар эрх зүйгээс өөр хууль цаазын учир холбогдолтой ба эрүүгийн хуульд заасан тодорхой нөхцөлд түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээнд харилцан адилгүй нөлөөлөх явдлаар тодорхойлогдоно.

Монгол улсын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд гэмт этгээдийн гэмт хэрэг үйлдсэний дараах зан байдал, түүний эрх зүйн үр дагавар, гэмт этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээнд хэрхэн нөлөөлөх асуудлыг тусгайлан судлаагүй байна.

Гэмт хэрэг үйлдсэний дараа гэмт этгээдийн зан байдал (посткриминальное поведение)-ын тухай асуудлыг Оросын Холбооны улсын эрүүгийн эрх зүйд нилээн хожуу өнгөрсөн зууны 80-аад оны үеэс судалж шинжлэх ухааны эргэлтэнд оруулжээ.

Ингэхдээ уг асуудлыг Эрүүгийн хуулийн хэм хэмжээ, урамшуулсан хэм хэмжээний асуудлын хүрээнд анх тодорхойлж[1] хожим нь тусгайлан судлах болжээ[2].

Эхэн үедээ энэ ойлголтын хүрээнд гэмт хэргээ илчлэн ирэх, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх, гэм хорыг арилгах асуудлыг голчлон авч үзэж байсан бол эрүүгийн хуулийн өөрчлөлт шинэчлэлт, эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан хөгжихийн хэрээр бусад нөхцлүүдийг хамааруулах болсон юм.

Оросын Холбооны улсад энэ

[1] В.М.Галкин.Система поощрений в советском праве // журнал Советское государство и право. 1977. № 2. С.89- 95, В.А.Елеонский. Поощрительные нормы уголовного права. Хабаровск. 1980 г.

[2] Х.А.Сабитов.Посткриминальное поведение (понятие, регулирование, последствия). Томск. 1985 г, И.Э.Звечаровский. Уголовно-правовые нормы, поощряющие посткринальное поведение личности. Иркутск. 1991, мөн түүний Посткриминальное поведение: понятие, ответственность, стимулирование. Иркутск. 1993

чиглэлээр гарсан бүтээлүүдэд гэмт хэрэг үйлдсэний дараах гэмт этгээдийн зан байдлыг дараах шинжүүдээр тодорхойлж байна[3].

Үүнд:

а. Эрх зүйн зан байдал байх, өөрөөр хэлбэл Эрүүгийн хуульд хуульчлагдсан зан байдал, зан үйл байх,

"Эрх зүйн зан үйл" гэдэг нь эрх зүйн хэмжээнд хуульчлагдсан төрөөс хүлээн зөвшөөрсөн, хориглосон, үүрэг болгосон, урамшуулсан, тодорхой эрх зүйн үр дагавар бүхий зан үйл, төлөв, зан байдал юм. Судлаач Ч.Нямсүрэн түүнийг "эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж, хууль зүйн үр дагавар агуулж, нийгмийн ач холбогдлоороо ямар нэг түвшинд ухамсарлагдаж байгаа хамтын болон хувь хүний зан үйл юм" гэж тодорхойлжээ[4].

Х.Цэвэлийн "Монгол хэлний товч тайлбар толь"-д *"зан"* гэдэг үгийг аливаа юмны янз, дүр төлөв, байр байдал, *"байдал"* гэдэг үгийг нь аливаа амьтны аашлах байдал, зан ааль, зан байдал зан суртал гэж тайлбарлажээ[5].

Энэ ойлголтын хүрээнд заавал авч үзэх асуудал бол *"эрх зүйн зан үйл"* (правовое поведение) гэдэг ухагдахууныг *"эрх зүйн байдал"* (правовое положение, правовой статус) гэсэн ойлголтоос ялгаж салгаж авч үзэх явдал юм. Эрх зүйн байдал гэдэг нь тодорхой эрх зүйн харилцаанд оролцогчдийн хуулиар хүлээх үүрэг, хуулиар олгогдсон эрхийн нийлбэр, нэгдмэл ойлголт байдаг.

Эрх зүйн зан үйл, зан байдал гэдэг ойлголт өргөн хүрээтэй ойлголт бөгөөд өөртөө олон эрх зүйн агуулга, ухагдахууныг багтаах ба түүний нэг бүрэлдэхүүн хэсэг нь эрүүгийн эрх зүйн зан байдал буюу гэмт хэрэг үйлдсэн этгээдийн зан байдал юм.

Гэмт хэрэг үйлдсэний дараах гэмт этгээдийн зан байдал нь эрх зүйн зан байдлын нэг хэлбэр болохын хувьд эрүүгийн эрх зүйн хамгаалах харилцааны хүрээнд гэмт этгээдийн хэрэг үйлдсэний дараах үйл ажиллагаа, биеэ авч явж буй байдал, зан төлөв гэсэн агуулгаар тодорхойлогдоно.

Гэхдээ гэмт хэрэг үйлдсэний дараахь гэмт этгээдийн бүх зан үйл, зан төлөв, байдал бүхэн энэ ухагдахуунд хамаарахгүй бөгөөд гагцхүү эрүүгийн хуулиар тодорхойлсон зан төлөв, зан байдал, үйлдлийг энэ ухагдахуунд багтааж ойлгох ёстой.

Тухайлбал: гэмт хэрэгтэн гэмт хэрэг үйлдсэний дараа гэр бүл болох, эд зүйл худалдан авах, эд зүйл өвлөн авах зэрэг нь эрүүгийн эрх зүйд ямар нэгэн хууль зүйн учир холбогдолгүй байдаг бол гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо нөхөн төлсөн, гэм хорыг сайн дураар арилгасан, хохирогчтой эвлэрсэн, үйлдсэн хэргээ сайн дураар илчлэн ирсэн, гэмт хэргийг илрүүлэхэд идэвхтэй тусламж, дэмжлэг үзүүлсэн эсвэл гэмт хэрэг шинээр үйлдэх, захиргааны зөрчил гаргах, эрүүгийн хуулиар хүлээлгэсэн үүргийг биелүүлэхээс зайлсхийх зэрэг

---

[3] И.Э.Звечаровский. Посткриминальное поведение личности: ответственность и стимулирование. Автореф.дисс...доктора юрид. наук. Санкт-Петербург. СПбГУ.1993.С.14-15. Р.А.Сабитов Посткриминальное поведение (понятие, регулирование, последствия). Томск.1985. С.8-22

[4] Ч.Нямсүрэн.Эрх зүй, төрийн ерөнхий онол. УБ.2004 он.322 дах тал

[5] Х.Цэвэл.Монгол хэлний тайлбар толь. УБ.УХХ.1966 он.68, 265 дах тал

нь эрүүгийн хуульд заасан зан төлөв, байдал, үйлдэл тул эрүүгийн эрх зүйн учир холбогдолтой зан байдал болох жишээтэй.

b. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тодорхой эрх зүйн үр дагаврыг бий болгох,

Гэмт хэрэг үйлдсэн этгээд хэрэг үйлдсэний дараа Эрүүгийн хуулинд заасан зан төлөвтэй байх, түүнийг сахиж биелүүлэх, тодорхой үйлдлийг хэрэгжүүлэх нь түүнд Эрүүгийн хуульд хуульчлагдсан тодорхой эрх зүйн үр дагаврыг үүсгэнэ.

Гэмт хэрэг үйлдсэний дараах гэмт этгээдийн зан үйл, зан төлөв, байдал нь хууль зүйн мөн чанарын хувьд хууль ёсонд нийцсэн болон хууль ёсыг зөрчсөн шинжтэй аль нь ч байж болно. Үүнээс шалтгаалан үүсэх эрх зүйн үр дагавар өөр өөр (эерэг, сөрөг) байдаг онцлогтой.

Эрх зүйн зан үйл нь эрх зүйн хэм хэмжээнд тусгагдахаас гадна төрийн хяналтын объект болж хууль ёсны болон хууль зөрчсөн үйл явдал (факт) нь тогтоогдсоны эцэст эрх зүйн үр дагаврыг үүсгэнэ. Үүний нэгэн адил гэмт этгээдийн гэмт хэрэг үйлдсэний дараах зан байдалд хуулийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтнууд хяналт тавьж хуульд нийцсэн буюу хууль зөрчсөн зан үйлийг хяналт тавьж, нотолж тогтоосны эцэст хуульд заасан эерэг болон сөрөг эрх зүйн үр дагавар бий болно.

c. Уг зан байдал нь тодорхой цаг хугацааны дотор үргэлжлэх зэрэг болно.

Гэмт хэрэг үйлдсэний дараах гэмт этгээдийн зан байдал нь тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэнээс хойш эрүүгийн эрх зүйн харилцаа дуусгавар болох хүртэл буюу уг ял шийтгүүлсэн этгээд ялгүй болох, ялгүйд тооцогдох хүртэлх цаг хугацаанд үргэлжилнэ.

"Гэмт хэрэг үйлдсэнээс хойш" гэдэгт тодорхой этгээд гэмт хэрэг үйлдсэн, тухайлбал: гэмт этгээдийн үйлдэж эхэлсэн хэрэг нь таслан зогсоогдсон (гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн, завдсан), эсвэл гэмт хэргийг үйлдэж дууссан (төгс үйлдсэн) цаг хугацаанаас хойших үеийг хэлнэ.

Ял шийтгүүлсэн этгээд ялгүй болох, ялгүйд тооцогдох гэдэгт Эрүүгийн 78-р зүйлд заасан үндэслэл журмын дагуу ялтны ял шийтгүүлснээс үүсэх ялтай байдал гэсэн эрх зүйн дагавар арилах, хүчингүй болохыг ойлгоно.

Бидний тодорхойлж буй зан байдал нь харьцангуй урт удаан хугацааг хамрах учраас эрдэмтэд, судлаачид түүнийг цаг хугацааны хувьд янз бүрээр хуваан үзжээ. Профессор Р.А.Сабитов

- Гэмт хэрэг үйлдсэн даруй үе дэх гэмт этгээдийн зан байдал,
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагааны үе шатан дах зан байдал[6],
- Шүүхийн шийтгэх гарснаас хойш ял эдэлж дуусах үе шатан дахь гэмт этгээдийн зан байдал,
- Ял эдэлж дууссанаас хойш ялгүй болох, ялгүйд тооцогдох хүртэлх зан байдал гэж ангилсан бол профессор И.Э.Звечаровский
- Гэмт хэрэг үйлдсэнээс хойш шүүхээс ял оногдуулах хүртэлх үеийн гэмт этгээдийн зан байдал

[6] Р.А.Сабитов Посткриминальное поведение (понятие, регулирование, последствия). Томск. 1985. С.24

(допенитенциарное поведение личности),

- Шүүхээс ял шийтгүүлснээс оногдуулсан ялыг эдэлж дуусах хүртэл үеийн ялтны зан байдал (пенитенциарное поведение личности),
- Ялтны ял эдэлж дууссанаас хойш ялгүй болох, ялгүйд тооцогдох хүртэл үеийн зан байдал (постпенитенциарное поведение личности) гэж 3 үе шатанд хувааж судалжээ[7].

Үүнтэй төсөөтэй ангиллыг профессор М.И.Горобцов хийсэн байдаг[8].

Ийнхүү гэмт хэрэг үйлдсэний дараах гэмт этгээдийн зан байдлыг ангилах нь хууль тогтоогчийн зүгээс гэмт этгээдийн гэмт хэрэг үйлдсэний дараах эрх зүйн зан үйлийг хуульчилсны зорилго, ач холбогдлыг зөв танин мэдэх, эдгээр үе шатуудад гэмт хэрэг үйлдсэн этгээд болон ялтанд эрүүгийн хуульд заасан түүний зан байдалд нийцсэн эрх зүйн үр дагавар, нөлөөллийн арга хэмжээг зөв хэрэглэх онолын төдийгүй практик ач холбогдолтой бөгөөд хоёр дах ангилал нь энэ шаардлагыг илүү хангаж чадна гэж бид үзэж байна.

Оросын Холбооны Улсын эрдэмтэд гэмт хэрэг үйлдсэний дараа гэмт этгээдийн зан байдлыг өөр өөрөөр тодорхойлжээ.

Профессор Р.А.Сабитов гэмт хэрэг үйлдсэн дараах гэмт этгээдийн зан байдал гэдэг нь гэмт хэрэг үйлдсэний дараах гэмт этгээдийн Эрүүгийн хуульд заасан, гэмт хэргийн шинжгүй, хууль ёсонд нийцсэн буюу хууль ёсыг зөрчсөн, тодорхой эрүүгийн эрх зүйн үр дагавар бий болгох ухамсарласан зан төлөв, байдал мөн гэж тэмдэглэжээ[9].

Дээрхи тодорхойлолтоос үзэхэд гэмт хэрэг үйлдсэний дараах гэмт этгээдийн зан байдалд уг этгээд гэмт хэрэг үйлдсэний дараа гэмт хэрэг үйлдсэн явдлыг хамааруулаагүй болохыг харж болох ба тэрээр уг ойлголтонд хамаарахгүй, эрүүгийн эрх зүйн өөр институт болох гэмт хэргийн олонлогт хамаарна гэж үзжээ[10].

Түүний энэ үзэл бодлыг энэ чиглэлээр судалгаа хийсэн бусад судлаач эрдэмтэд хүлээн зөвшөөрөөгүй, шүүмжлэлтэй хандаж гэмт хэрэг үйлдсэний дараах гэмт этгээдийн зан байдалд Эрүүгийн хуульд заасан, тодорхой эрүүгийн эрх зүйн үр дагавар үүсгэх гэмт хэргийн болон гэмт хэргийн бус шинжтэй зан үйл, зан төлөв, үйлдэл хамаарна гэсэн дүгнэлтийг хийсэнтэй[11] бид санал нэгтэй байна.

Бидний үзэж байгаагаар **гэмт хэрэг үйлдсэний дараах гэмт этгээдийн зан байдал** гэдэг нь гэмт хэрэг үйлдсэнээс хойшхи Эрүүгийн хуульд заасан, хууль ёсонд нийцсэн ба хууль зөрчсөн, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тодорхой эрүүгийн эрх зүйн эерэг, сөрөг үр дагаврыг бий болгодог гэмт хэргийн ба гэмт хэргийн бус шинжтэй эрх зүйн байдал (зан төлөв, зан үйл)-ыг хэлнэ.

Уг судлан буй асуудлын хүрээнд

---

[7] И.Э.Звечаровский. Посткриминальное поведение: понятие, ответственность, стимулирование. Иркутск. 1993.С. 17

[8] М.И.Горобцов. Меры постпенитенциарного контроля за поведением осужденных. Орел. 1995. С.12-13

[9] Р.А.Сабитов Посткриминальное поведение (понятие, регулирование, последствия). Томск. 1985. С.22

[10] Р.А.Сабитов.Мөн бүтээл.С.9-10

[11] И.Э.Звечаровский. Посткриминальное поведение личности: ответственность и стимулирование. Автореф. дисс... доктора юрид. наук. Санкт-Петербург. СПбГУ. 1993.С.14

авч үзэх нэг асуудал гэмт хэрэг үйлдсэн дараах гэмт этгээдийн зан байдлыг тодорхой үндэслэлээр ангилах явдал бөгөөд ийнхүү төрөлд ангилах нь тухайн эрх зүйн үзэгдлийг танин мэдэхүйн болон практик ач холбогдлоос үүдэлтэй.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хэрэг үйлдсэний дараах зан үйлийг түүний үргэлжлэх, хэрэгжих үе шатаар нь[12], үүсэх эрх зүйн дагавар, түүний шинж чанараас хамаарч ангилдаг.

Тухайлбал: гэмт хэрэг үйлдсэний дараах гэмт этгээдийн зан байдлыг түүнийг хэрхэн дагаж мөрдсөний, сахиж биелүүлснээс, түүнээс үүсэх эрх зүйн үр дагавраар нь:

а. Хууль ёсонд нийцсэн буюу тухайн этгээдэд үүсэх эрэг зан байдал, үр дагавар,

б. Хууль ёсыг зөрчсөн буюу тухайн этгээдэд сөрөг зан байдал, үр дагавар гэж ангилж болно.

3. Монгол улсын эрүүгийн хууль дах гэмт хэрэг үйлдсэний дараах гэмт этгээдийн зан үйлийн эрүүгийн эрх зүйн учир холбогдол

Хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол улсын эрүүгийн хуулийн хэм хэмжээг судлан үзэхэд гэмт хэрэг үйлдсэний дараах гэмт хэрэгтний зан байдал нь доорхи эрүүгийн эрх зүйн учир холбогдол, үр дагаврыг бий болгоно. Үүнд:

1. *Эрүүгийн хуулийн 33-р зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу завдсан этгээд уг гэмт хэргээ туйлд нь хүргэх боломжтойг ойлгож байсан боловч тийнхүү туйлд нь хүргэхээс сайн дурааараа, төгс татгалзсан тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх ба энэ нь тухайн этгээдийн хувьд эрүүгийн эрх зүйн эерэг үр дагаврыг үүсгэдэг.*

2. *Гэмт хэрэг үйлдсэний дараа эсвэл үйлдсэн гэмт хэрэгтээ ял эдэлж байхдаа буюу ялаа эдэлсний дараа гэмт этгээд дахин гэмт хэрэг үйлдвэл нийлмэл, давтан, рецидив гэмт хэрэг болдог.*

Энэ нь тухайн этгээдийн үйлдэлд өгөх хууль цаазын үнэлэлт дүгнэлт, гэмт хэргийн зүйлчлэлд болон түүнд шүүхээс ял оногдуулах журам, оногдуулах ялын төрөл, хэмжээнд нөлөөлөх сөрөг үр дагавар мөн.

3. *Гэмт хэрэг үйлдсэний дараах шүүхээс ял шийтгэх (оногдуулах) хүртэлх гэмт этгээдийн эерэг болон сөрөг зан үйл, зан байдал нь шүүгдэгчид ял оногдуулахад ялыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал болно.*

Эрүүгийн хуулийн 55-р зүйлд хууль тогтоогч гэмт хэрэгтний гэмт хэрэг үйлдсэний дараах зан байдалд хамаарах хэдэн нөхцлийг түүнд оногдуулах ялыг хөнгөрүүлэх нөхцөл байдал болгон хуульчилжээ.

Тухайлбал: Эрүүгийн хуулийн 55-р зүйлийн 55.1.2-д "гэмт хэргийн улмаас учрах хор уршгийг зайлуулсан", 55.1.3-д "гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо сайн дурааараа нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан", 55.1.9-д "үйлдсэн гэмт хэрэгтээ чин санаанаас гэмшсэн буюу гэмт хэргээ сайн дураар илчилж ирсэн, түүнчлэн гэмт хэрэг болон гэмт хэрэг үйлдсэн этгээд, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг илрүүлэхэд идэвхтэй дэмжлэг үзүүлсэн", 55.1.10-д "бусдын амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан гэмт хэрэг үйлдсэн даруйдаа

[12] Дээр бид үе шатаар ангилах асуудлыг авч үзсэн билээ.Г.Г

хохирогчид эмнэлгийн болон бусад тусламж үзүүлсэн" бол тус тус ялыг хөнгөрүүлж үзэхээр заажээ.

Харин 56-р зүйлийн 56.1.12-д "шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан буюу ялыг тэнсэж хянан харгалзсан хугацаанд, эсхүл ялтай байхдаа гэмт хэрэг дахин үйлдсэн" тохиолдолд ялыг хүндрүүлж үзэхээр заажээ.

4. *Хуульд зааснаас хөнгөрүүлж ял оногдуулах үндэслэл болно.*

Эрүүгийн хуулийн 55-1-р зүйлд "... Эрүүгийн хуулийн тусгай ангид заасны дагуу хорих ял оногдуулж болох гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээд гэмт хэргийн хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан бол шүүх тухайн этгээдийн хувийн байдал, үйлдсэн хэргийнх нь шинж чанарыг харгалзан Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хорих ялын доод хэмжээнээс доогуур хорих ял оногдуулж болох боловч ийнхүү хөнгөрүүлэн оногдуулах хорих ялын доод хэмжээ нь энэ хуулийн тусгай ангид тухайн гэмт хэрэгт оногдуулахаар заасан хорих ялын доод хэмжээний гуравны хоёроос хэтрэхгүй байна.." гэж заасан дээрхийн жишээ мөн.

Ийм заалт Эрүүгийн хуулийн 62-1-р зүйлд мөн хуульчлагдсан юм.

5. *Гэмт этгээдийн гэмт хэрэг үйлдсэний дараах зан байдал нь шүүхээс оногдуулсан ялыг эдлүүлэх, биелүүлэх явцад уг ялыг өөр төрлийн ялаар солих тухайн этгээдэд сөрөг үр дагавартай.*

Эрүүгийн хуулийн 47-р зүйлийн 47.3-д торгох ялыг биелүүлэхээс ноцтойгоор зайлсхийвэл торгох ялын хэмжээнээс хамааран шүүх уг ялыг гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болохоор заасан байдаг.

Мөн ийм үр дагавар Эрүүгийн хуулийн 50-р зүйлийн 50.3-т заасан тохиолдолд бий болдог.

6. *Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болно.*

Үүнийг Эрүүгийн хуулийн 70-р зүйлд 70.1-д "...Хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдэж, сайн дурааараа хэргээ илчилж ирсэн этгээд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно..", 71-р зүйлийн 71.1-д "...Хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн гэм буруутай этгээд хохирогчтой сайн дурааараа эвлэрсэн бөгөөд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.." гэж зааснаас харж болно.

7. *Ял хойшлуулсан, ял тэнссэн шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох, шүүхээс оногдуулсан ялыг биечлэн эдлүүлэх үндэслэл болно.*

Эрүүгийн хуулийн 61-р зүйлийн 61.5-д "...Тэнсэгдсэн ялтан хянан харгалзах хугацаанд захиргааны шийтгэл хүлээсэн бол цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ялыг биечлэн эдлүүлэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ...", 62-р зүйлийн 62.3-д "...Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан этгээд шүүхээс тогтоосон хугацаанд даалгасан үүрэг биелүүлээгүй буюу захиргааны шийтгэл хүлээсэн бол шүүгч цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай захирамж

гаргана...” гэж заасан нь үүний баталгаа юм.

8. *Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ялаас чөлөөлөх эрх зүйн үндэслэл болно.*

Эрүүгийн хуулийн 74-р зүйлийн 74.1-д хорих ял шийтгүүлсэн ялтан засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулж, гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлсөн, гэм хорыг арилгасан бол түүнийг шүүх ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллаж болохоор заасан ба гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлөөгүй этгээдэд ял эдлэхээс хугацаанаас өмнө тэнсэн суллах журмыг хэрэглэхгүй байхаар хуульчилжээ.

9. *Ялтныг хорих газраас хугацааны өмнө тэнсэн сулласан шийдвэрийг хүчингүй болгох нөхцөл болно.*

“...Ялтан хянан харгалзах хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг биелүүлэхээс зайлсхийсэн, захиргааны зөрчил гаргаж шийтгэгдсэн бол шүүгч цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан шийдвэрийг хүчингүй болгож, үлдсэн ялыг эдлүүлэхээр захирамж гаргана..” гэж Эрүүгийн хуулийн 74-р зүйлийн 74.8-д заасан байдаг.

10. *Эрүүгийн хуульд заасан хэргийн хөөн хэлэлцэх хугацаа, шүүхийн шийтгэх тогтоолын биелүүлэх хугацааг хүчингүй болгох (тасрах), зогсоох, сэргээн тоолох үндэслэл болно.*

Эрүүгийн хуулийн 72-р зүйлийн 72.2-д гэмт хэрэг үйлдсэн этгээд 72.1-д заасан хэргийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрөөгүй байхад гэмт хэрэг санаатай үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд энэ тохиолдолд уг хугацааг сүүлчийн хамгийн хүнд гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тоолохоор, 72.3-д шүүхийн өмнөх шат болон шүүхийн шатнаас гэмт хэрэг үйлдсэн этгээд оргон зайлсан бол хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг оргон зайлсан өдрөөс зогсоож уг этгээд баригдсан буюу хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолохоор, эрүүгийн хуулийн 76-р зүйлийн 76.2-д ялтан ял эдлэхээс зайлсхийсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож ялтан цагдан хоригдсон буюу өөрөө сайн дураараа хэргээ илчлэн ирсэн өдрөөс уг хугацааг сэргээн тоолохоор, 76.4-д ялтан 76.1-д заасан хугацаа өнгөрөөгүй байхад шинээр гэмт хэрэг үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд энэ тохиолдолд уг хугацааг сүүлчийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тоолохоор заасан бөгөөд эдгээр зан үйл, байдал нь уг этгээдийн хувьд эрүүгийн эрх зүйн сөрөг үр дагаврыг дагуулна.

11. *Ялгүй болох эрх зүйн үндэслэл, ялгүй болох хугацаа тасрах нөхцөл болно.*

Эрүүгийн хуулийн 78-р зүйлийн 78.2-д зааснаар гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээд үндсэн болон нэмэгдэл эдэлснээс хойш уг зурваст заасан хугацааны дотор шинээр гэмт хэрэг үйлдээгүй бол ялгүй болно. Хэрэв ялаа эдэлж дууссан этгээд ялгүй болох хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдвэл ялгүй болох хугацаа тасрах бөгөөд сүүлчийн гэмт хэрэгт оногдуулсан үндсэн ба нэмэгдэл ялыг эдэлж дууссаны дараа түрүүчийн гэмт хэрэгт ялгүй болох хугацааг хамтатган эхэлж тоолох ба энэ тохиолдолд уг этгээд үйлдсэн аль хүнд ялтай хэрэгтээ ялгүй болох хугацаа дуустал уг этгээд аль алинд нь ялтайд тооцогдоно. (Эрүүгийн

хуулийн 78-р зүйлийн 78.5)

12. *Ялгүйд тооцох эрх зүйн үндэслэл* болно.

Эрүүгийн хуулийн 78-р зүйлийн 78.5-д "...ял шийтгүүлсэн этгээд үндсэн ба нэмэгдэл ялаа эдэлж дууссаны дараа зан байдал, засрал хүмүүжлээрээ үлгэр жишээч байвал шүүх хугацаанаас нь өмнө ялгүйд тооцож болно..." гэж заажээ.

Дүгнэлт

Дээрхээс дүгнэхэд гэмт хэрэг үйлдсэний дараах гэмт этгээдийн зан байдал нь:

- эрх зүйн өргөн агуулгатай,
- эрүүгийн эрх зүйн тогтолцоо дах олон институттэй нягт холбоотой,
- эрүүгийн эрх зүйд тодорхой хууль зүйн учир холбогдлыг бий болгодог,
- бусад олон салбар хүрээнд ч эрх зүйн үр дагаврыг үүсгэдэг,
- танин мэдэхүй, онолын төдийгүй практик ач холбогдол бүхий чухал ойлголт, судлагдахуун болох нь харагдаж байна.

Эцэст нь тэмдэглэхэд уг асуудлыг Монгол улсын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны эргэлтэнд оруулан тусгайлан судлах, үүний үндсэн дээр гэмт хэрэг үйлдсэний дараах гэмт этгээдийн зан байдалтай холбоотой хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн хуулийн хэм хэмжээг боловсронгуй болгох шаардлагатай байгаа бөгөөд ийм шаардлага эрүүгийн хуулийн шударга ёсны болон шүүн таслах ажиллагаанд гэмт хэрэгтний хувийн зан байдалд тохирсон ялыг ялгамжтай оногдуулах зарчмыг хэрэгжүүлэх явдлаар нөхцөлдөж байгаа юм.

Ном зүй

1. Х.А.Сабитов. Посткриминальное поведение (понятие, регулирование, последствия). Томск. 1985 г,

2. В.М.Галкин. Система поощрений в советском праве / журнал Советское государство и право. 1977. № 2.

3. В.А.Елеонский. Поощрительные нормы уголовного права. Хабаровск. 1980 г.

4. И.Э.Звечаровский. Уголовно-правовые нормы, поощряющие посткринальное поведение личности. Иркутск. 1991

5. И.Э.Звечаровский. Посткриминальное поведение: понятие, ответственность, стимулирование. Иркутск. 1993

6. И.Э.Звечаровский. Посткриминальное поведение личности: ответственность и стимулирование. Автореф.дисс... доктора юрид.наук. Санкт-Петербург. СПбГУ.1994.

7. Ч.Нямсүрэн. Эрх зүй, төрийн ерөнхий онол.УБ.2004, 2012 он.

8. Х.Цэвэл.Монгол хэлний тайлбар толь.УБ.УХХ.1966 он.

9. М.И.Горобцов. Меры постпенитенциарного контроля за поведением осужденных.Орел.1995.

10. Монгол улсын Эрүүгийн хууль Төрийн мэдээлэл. УБ. 2002 №5

ХИЛИЙН ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ХИЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОЛЦОО

Х.Асхар. Хилийн сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдлын тэнхимийн дэд профессор, докторант, хошууч



Товч агуулга: Хилийн боомт газар үр дүнтэй хилийн хяналт шалгалтын тогтолцоог хэрэгжүүлснээр хүний наймаа, хууль бус цагаачлал гэмт хэргийн тохиолдлуудыг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах олон улс, бүс нутаг, орон нутгийн шүүх ажиллагааны үндсэн бүтэц болох хүчин зүйлс болох юм. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны нэг хэлбэр болох сургалтын үйл ажиллагаа нэн чухал юм.

Түлхүүр үгс: хүн худалдаалах гэмт хэрэг, хүний наймаа, мөнгө угаах, жендер, жендерийн тулгамдсан асуудал

Abstract: The enforcement of effective border monitoring and control at border areas will enable the detection, investigation, cessation and prevention of human trafficking and illegal immigration cases, the key factor for the international, regional and local judiciary process. The collaborative network of law enforcement agencies is crucial in combating with and prevention from human trafficking.

Дэлхийн хэмжээнд жилд 2 сая 450 мянган хүн ямар нэгэн байдлаар хүний наймаа, албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийн золиос болж байна гэж хөдөлмөрийн олон улсын байгууллагын судалгаагаар гарсан байна.

Дэлхийн хэмжээний хүний наймаанаас олсон орлого одоогийн байдлаар 44 сая америк доллараар үнэлэгдсэн байна.

Түүний үйл ажиллагааны сөрөг үр дагавар нь дараах байдлаар илэрч байна. Үүнд:

- Зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл хоорондын хүчирхийллийн өсөлт нь зах зээл дээр оршин буй албадан хөдөлмөр эрхлүүлэх болон биеэ үнэлүүлэх чиглэлд хүч түрэн тэмцэлдэн хувь эзэмших.

- Зохион байгуулалттай гэмт хэргийн төрөл, хамрах хүрээний өсөлт: зохион байгуулалттай хүний наймаа нь хэзээ ч өөрөө үүсэн бий болдоггүй. Хүний наймааны худалдаа хийж буй худалдаачид нь алан хядах, хар тамхины наймаа, зэвсгийн наймаачидтай өөрт

ашигтайгаар ажиллах хоорондын сүлжээг шуурхай бий болгодог.

- Мөнгө угаах гэмт хэргийн улмаас эдийн засгийн зогсонги байдал бий болгох: хүн худалдаалах наймаа нь асар богино хугацаанд их хэмжээний орлогыг олдогоос улс орны дотоод болон олон улсын хэмжээнд мөнгө угаах гэмт хэргийг хөгжүүлэх чадамжийг бий болгодог.

- Төрийн байгууллагын хэмжээнд авлигын өсөлт: хүний наймаа, хууль бус цагаачлалын нягт салаа мөчир бүхий зохион байгуулалт нь төрийн бүхий л салбар, байгууллагуудын төрийн албан хаагчдыг өөрийн эрхшээлд оруулах (худалдагдах), энэхүү үйл ажиллагааны үр дагавраар гарах үр дүн нь хууль сахиулах байгууллагаас авлигын эсрэг хийх тэмцэл нь талаар болох магадлалтай байдаг байна.

- Улс төрийн авлига, улс төрийн нөлөөллийг худалдаж авах: дээрх гэмт хэргийн үйл ажиллагаагаа мөнгө санхүүгийн хэрэгсэл ашиглан улс төрийн нөлөөлөл, улс төрийн бодлогыг худалдан авах нь гэмт хэрэгтнүүдэд хувийн ашиг, сонирхлоо хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж болзошгүй.

- Улс орны эдийн засгийн хөгжилд оруулах гадаадын хөрөнгө оруулалтыг зогсонги байдалд оруулах: зохион байгуулалттай хууль бус наймаа нь мөнгө угаах гэмт хэргийг халдаах, төрийн байгууллагуудын авлигад автуулснаар улс оронд итгэх итгэлийг үгүй болгосноор гадаад орнуудаас орж ирэх томоохон хөрөнгө оруулагчдаас стратегийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтад сөрөг нөлөөлөл бий болох магадлалтай.

Хүний наймаа нь ихэвчлэн жендерийн царай төрхний ялгааг харгалзсан шинжтэй байдаг.

Хүний наймаа нь зорилгын хувьд олон янз бөгөөд бүс нутгийн, бүс нутгуудын хэмжээнд, ихэвчлэн гэрийн үйлчлэгч, биеийг нь үнэлүүлэх зорилгоор эмэгтэйчүүд, охидыг хүний наймаанд татан оруулдаг. Хүний наймааны золиос бологсдын ихэнх хувийг хууль бусаар хөдөлмөр эрхлэх цагаачид эзлэх ба ихэвчлэн харгалзах хүнгүй, боловсролын түвшин доогуур, хүний наймаачид арга залинд хууртагдан мөнгөө алдсан иргэд байдаг.

Ихэнх тохиолдолд эмэгтэйчүүдэд хувийн зорчих баримт бичиг байдаггүй (баримт бичгийг бүрдүүлэхэд гэр бүлийн талаас зөвшөөрөл шаардагддаг). Зорчих баримт бичиггүй аялан яваа эмэгтэйчүүд нь хууль бус цагаачлагч хэмээн нэрлэгдэх ба ихэнхдээ хууль бус үйлдлийн золиос болсон байдаг.

Эрэгтэйчүүд, хөвгүүдийг мөн адил хүний наймааны золиос болгодог. Тэднийг гол нь хөдөө аж ахуй, барилгын, үйлдвэрлэлийн салбаруудад өөрийн хүсэл зорилгын дагуу бус албадлага, боолын хэлбэрээр ажиллуулдаг. Жишээлбэл: тодорхой тохиолдлыг нэрлэвэл Баруун Африкт хилчид авлига аван олон тооны хөвгүүдийг боол болгон худалдаалах зорилготойгоор улсын хилээр хууль бусаар хил нэвтрүүлсэн явдал юм. Жендерийн ялгааг харгалзан улсын хилээр шалган нэвтрүүлэх үйл явц нь хүний наймааны золиос болох үйлдлийг илрүүлэх боломжийг бүрдүүлж байгаагаас гадна хүний наймаа, хууль бус цагаачлалын золиос бологсдыг хамгаалах шаардлагатай арга хэмжээ юм гэж үзэж байна.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаар дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, зааврыг хамтран боловсруулснаар нэгдсэн, цогц бодлогыг хангадаг.

Энэхүү үйл ажиллагаанд оролцох янз бүрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаа, боловсруулах ажлын бүлгүүдэд орох гүйцэтгэх ажилтнуудыг хууль, хяналтын байгууллагууд ихэвчлэн хариуцан томилдог. Үүнээс гадна хилийн хяналт шалгалтын байгууллагуудаас өөр хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажиллаж буй дараах байгууллагууд ордог. Үүнд.

- Цагдаагийн тусгай салбар;
- Эмнэлгийн шинжээчид (шүүх эмнэлгийн шинжээч, хүүхдийн асран хамгаалах алба, эмэгтэйчүүдийг хамгаалах алба, хохирогчид тусламж үзүүлэх байгууллага, хохирогчдод өмгөөлөл үзүүлэх, хууль зүйн зөвлөгөө өгөх байгууллага ба бусад хувийн байгууллагууд);
- Төрийн бус байгууллагууд гэх мэт.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаар үндэсний хэмжээнд төрийн байгууллагууд хүний наймааны золиос болж буй хүмүүсийн эрхийг хамгаалахад өөрийн үүрэг чиглэлээ биелүүлэхдээ иргэний болон төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй хамтран үйл ажиллагаагаа явуулдаг.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоог практик амьдралд хамтран ажиллах хэрэгсэл болж төлөвлөн ажилласан тохиолдолд илүү үр дүнтэй. Хамтран ажиллах үед төрийн байгууллага, иргэний болон төрийн бус байгууллагуудын үүрэг оролцоо, тэдний хариуцан ажиллах бүс хэсгүүдийг тогтоож, хамтран ажиллах дүрэм, зааврыг мөрдлөг болгож ажиллах нь зүйтэй юм. Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд тухайн төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх байгуулагаас энэ чиглэлээр байнгын мэдээ, мэдээллийг цуглуулахад хилийн боомт бүхий гарцууд нь мэдээ мэдээллийг цуглуулах, ашиглах чухал обьект болдог.

Эдгээр хүчин зүйлсээс хамааран хилийн хяналт шалгалт, аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаарх сургалтыг байнга хийх нь үр дүнгээ өгдөг нь гадаадын улс орнуудын туршлагаас харагдаж байна.

Сургалтын ач холбогдол нь суралцагчдын талаар урьдчилсан байдлаар практик мэдлэгийн түвшинд дүн шинжилгээ, тэдний эрэлт хэрэгцээ зэргийн үр дүнг сургалтын хөтөлбөрт хэрхэн боловсруулж тусгаснаас хамаарна.

Сургалтын агуулга нь бодит нөхцөл байдал, практик түвшинд нийцсэн, эрэлт хэрэгцээг хангасан, хоорондоо уялдаа холбоотой байна.

Сургалтын суралцах явцын график төлөвлөгөө, үргэлжлэх хугацааг тогтоох шаардлагатай.

Сургалтыг идэвхтэй болгох янз бүрийн арга барилууд байдаг. Оновчтой сургалтын арга барилыг сонгоход дотоод нөөц боломж, суралцагчдын албан тушаал, цол хэргэм, мөн тодорхой нөхцөл байдалд тавигдах шаардлагуудаас шууд хамааралтай байдаг.

Сургалтын чадамж нь сургалтад ноогдох хугацаа, хөрөнгө төсөв, мөн зарим сургалтын хувилбаруудаар явуулахаас хамаарна. Үүнд: танилцах дадлага, ажилтнуудаа солилцох, зааварчилгаа, дугуй ширээний ярилцлага, дадлага, ажлын байранд тавигдах зөвлөмж, зааварчилгаа гаргах зорилгоор удирдлагын түвшинд шинжээчдийг ажиллуулах гэх мэт.

Сургалтын ач холбогдлыг нэмэгдүүлэхэд нэмэлт арга хэмжээг авч болно. Үүнд:

Ажилчдыг шагнаж урамшуулах, эрэгтэй, эмэгтэйчүүдийн бүрэлдэхүүний дунд, жендерийн онцлогт харгалзан бүртгэл судалгааг явуулсан байдалд амжилт гаргасан, мөн шагнаж урамшуулсан талаар мэдээллийн хэрэгслээр зарлан мэдээлэх зэрэг болно.

Хилийн хяналтын байгууллагуудын албан хаагчдад сургалтыг зохион байгуулж явуулах зөвлөмж, саналууд

- Жендерийн бүртгэлийг "агаарын орон зай" гэсэн байдлаар авч үзэхгүй байх. Хилийн хяналтын байгууллагуудын алба хаагчид магадгүй албан үүргээ биелүүлэх үед энэхүү арга хэмжээг хэрхэн хийх талаар тайлбарлаж өгснөөр боддог.

- Жендерийн тулгамдсан асуудал нь онцгой тусгай сэдэв мэтээр ойлгох бус хилийн хяналтын байгууллагуудын албан хаагчыг сургах гол холбоос сургалт гэдгээр ойлгох, мөн жендерийн онцлогт тулгуурласан тусгай хичээлээс бусад бүх сургалтын хөтөлбөрт жендерийн асуудлын талаар оруулна.

- Орон нутгийн онцлогийг тусгасан сургалтын материаллаг баазыг сонгож авах.

- Сургалтад оролцож байгаа бүрэлдэхүүний албан тушаал, зэрэг дэв, тодорхой бүлгүүдийн онцлогийг харгалзанүзэж,угсургалтынматериалын агуулга нь практик даалгаврыг биелүүлэх, шийдвэр гаргах түвшинд байхаар сургалтад заах материалдаа тодотгол хийнэ. Жишээлбэл: удирдах албан тушаалтнуудын бүрэлдэхүүний суралцагчдад жендерийн онцлогийг харгалзан бүртгэлийг хийх хүрээнд эрх зүйн баримт бичиг, заавар боловсруулах дадлагын даалгавар гүйцэтгүүлэх, дундаж түвшний удирдлагуудад жендерийн тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх даалгавар өгөх, харин гүйцэтгэх албаны ажилтнуудад тодорхой цагийн байдал үүссэн үед жендерийн онцлогийг харгалзан бүртгэлийг явуулах дадлагын арга барилыг сургах.

- Эмэгтэйчүүд, иргэний нийгмийн байгууллагаас авагдсан орон нутагт тулгамдаж буй асуудал, жишээ баримт, олон талын үзэл бодол зэрэг мэдээллүүдийг эх сурвалж болгон ашиглана.

- Сургалтад ахлах офицерыг оролцуулснаар тухайн сургалтад онцгой ач холбогдол өгөх боломж бүрдэнэ.

Давтан сургалтыг байнга явуулж, чанартай болгох үүднээс хамрагдсан талаарх тодорхойлолт, үр дүнг тодорхойлох үнэлгээ зэргийг өгөхөд анхаарах зэрэг болно.

ХИЛИЙН БООМТОД ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ СЭЖИГ ИЛЭРСЭН ҮЕД ХИЛ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Г.Галбадрах. Хилийн сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдлын тэнхимийн багш, докторант, дэд хурандаа



Дэлхий дахинд шинэ болон дахин сэргэж байгаа хүн, мал амьтны гоц халдварт өвчин тогтмол бүртгэгдэж, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсаар байна.

Хүрээлэн буй орчин, байгаль цаг уур, нийгэм эдийн засгийн олон нөлөөллийн улмаас зарим халдварт өвчин шинээр гарч, хуучин халдварт өвчин эргэн сэргэж, эрсдэл үүсгэсэн хэвээр байна.

1980-аад оны эхэн үеэс ДОХ зэрэг шинэ халдварт өвчнүүд гарах болсны зэрэгцээ эмэнд тэсвэртэй бактери, сүрьеэгийн савханцар, халуун хумхаа зэрэг нь олон оронд бүртгэгдэж, хүн амын эрүүл мэндэд аюул учруулах болсон.

АНУ-ын эрдэмтэн, нян судлаач Жошуа Ледерберг 1992 онд "Шинээр тархаж буй халдварт өвчнүүд, АНУ-ын хүн амд заналхийлж буй нянгийн аюул" гэсэн ном хэвлүүлж, энэ үеэс "шинэ болон дахин сэргэж буй халдвар" гэсэн ухагдахуун шинээр хэрэглэгдэх болсон. 1995 онд хуралдсан Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын (ДЭМБ) 48 дугаар чуулганаар шинээр тархаж буй халдвараас сэргийлэх асуудлаар тогтоол гарч энэ асуудал хариуцсан хэлтсийг ДЭМБ-ын төв хороонд байгуулсан. 1973 оноос өнөөг хүртэл ДОХ, Ханта болон эбола вирусын халдвар, Лаймын өвчин, гепатит E, C, G вирусын халдвар, хеликобактери, урвах тахал-0139, амьсгалын цочмог халтай хам шинж (АЦХаХ буюу SARS) зэрэг 40 гаруй халдварт өвчин шинээр бүртгэгджээ.

Шинээр бүртгэгдэж буй халдваруудаас нянгаар үүсгэгдсэн халдварт өвчний эзлэх хувь багасч, харин вирусээр үүсгэгдсэн нь нэмэгдсээр байгаа нь үүсгэгчийг илрүүлэх, оношлоход хүндрэл учруулаад зогсохгүй орчин үеийн техникийн ололтыг нэвтрүүлэх шаардлага зүй ёсоор гарч байна.

Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнүүдээс Олон улсын эрүүл мэндийн дүрмээр (ОУЭМД) зохицуулагддаг хүний олон улсын хөл хориот өвчнүүд байдаг бөгөөд тэдгээрийг уг дүрмийн хавсралтаар баталсан "шийдвэр гаргах, үнэлэх, мэдээлэх схем"-ийн дагуу үнэлж, ДЭМБ-д шуурхай болон тогтмол мэдээлэн хариу арга хэмжээ авдаг.

Хэрэв цагаан цэцэг, халдварт саа,

шинэ дэд төрлөөр үүссэн хүний томуу (H1N1, H5N1, H7N9, H8N10 гэх мэт), амьсгалын цочмог халтай хам шинж гэсэн 4 өвчний ганц л тохиолдол илэрвэл тухайн улсын ОУЭМД-ийг зохицуулагч байгууллага (манай улсын хувьд Халдварт өвчин судлалын үндэсний төв) ДЭМБ-д шууд яаралтай мэдээлэх, бусад халдварт өвчний (урвах тахал, тарваган тахлын уушигны хэлбэр, шар чичрэг, эбола, марбург, Өрнөд Нилийн цусархаг халуурал гэх мэт вируст цусархаг чичрэгүүд) тохиолдол гарвал эрсдэлийн үнэлгээ хийн, мэдээлэх үүрэгтэй.

Монгол Улсад 1998 онд урвах тахал буюу "холера", 2003 онд АЦХаХ буюу "SARS", 2009-2010 онд хүний томуугийн А хүрээний H1N1 халдварууд бүртгэгдэж, Монгол Улсын Засгийн газар, эрүүл мэндийн болон хил хяналтын байгууллагуудаас голомтыг таслах, дамжин тархахаас сэргийлэх хариу арга хэмжээг авч байсан.

Аливаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналт тандалт хийх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаа нь зөвхөн нэг улсын биш хөрш зэргэлдээ улс, цаашилбал олон улсыг хамарсан арга хэмжээ авахыг шаарддаг онцлогтой арга хэмжээ юм. Жишээ дурьдвал: 2014 онд Баруун Африкийн зарим улсад гарсан Эбола вируст халдвар нь одоог хүртэл намжаагүй бөгөөд олон улсын шинж чанартай арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байгаа юм.

Хөл хориот өвчин хил дамжин тархахаас урьдчилан сэргийлэх, сэжигтэй тохиолдол илэрсэн үед хариу арга хэмжээ авах (түр тусгаарлах, эмнэлгийн байгууллага дуудах г.м) үйл ажиллагааг хилийн боомт дээр хил хяналтын байгууллага хийх үүргийг ДЭМБ-аас гаргасан "Олон улсын эрүүл мэндийн дүрэм" болон бусад хууль тогтоомжид заасан байдаг. Түүнчлэн тээврийн хэрэгсэл, ачаа тээш, шуудан илгээмж, цогцос, биологийн халдвартай материал, хүнс, эмийн бүтээгдэхүүн, химийн хортой болон аюултай бодисын үзлэг шалгалтыг хилийн боомт дээр хийж, болзошгүй эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь хилийн боомтод ажиллаж буй хил хяналтын байгууллагуудын чухал үүргийн нэг юм.

Иймд хүний хөл хориот өвчнөөс урьдчилан сэргийлэх, сэжиг илэрсэн, халдварын голомт үүссэн үед хилийн боомтод ажиллаж буй хил хамгаалах алба, хорио цээр, иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний, гааль, цагдаа, тагнуулын байгууллагын үүрэг хариуцлага, авч хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхой байх ёстой.

Энэ арга хэмжээг хэрхэн авах, зохицуулах талаар "Нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн бэлэн байдал-Тохиолдлын удирдлагын тогтолцоо" гарын авлагыг ДЭМБ-аас гаргасан. Үүнд:

Хилийн хорио цээрийн хяналтын байгууллага:

- Тусгаарлах байр, өрөөний халдвар эсэргүүцэх арга хэмжээнд шаардагдах эм, тариа, ариутгал халдваргүйтгэлийн бодис, хувийн хамгаалах хэрэгслийн нөөцийг бий болгох, голомтод ажилласны дараах ариутгал халдваргүйтгэл хийх нөхцлийг бүрдүүлэх
- Сэжигтэй тохиолдол болон хавьтагсдыг нийслэлд Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ),

Зоонозын (мал, амьтны гаралтай) өвчин судлалын үндэсний төв (ЗӨСҮТ), хилийн боомтод боомт байрлаж буй сумын эмнэлэгт яаралтай мэдээлж, сэжигтэй зорчигч, хавьтагсдыг шилжүүлэх

• Халдварын голомтын хатуу болон хагас хязгаарлагдмал дэглэмийн үед тээврийн хэрэгслийн агаар, ус, бохирын цэг, эд зүйлсийг эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтад авах

• Хилийн боомт, галт тэрэг, онгоц, зорчигч тээврийн үйлчилгээний төвд байнгын ариутгал халдваргүйтгэл, шавьжгүйтгэл, мэрэгчгүйтгэл хийх

• Халдвартай, сэжигтэй материалууд, түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүнийг халдвар эсэргүүцэх дэглэмийн дагуу устгах

• Халдварт өвчний сэжигтэй зорчигч болон хавьтагсдыг холбогдох эмнэлгүүдэд хүргүүлсний дараа эцсийн халдваргүйтгэл хийх

• Эцсийн халдваргүйтгэл хийснээс хойш 1-2 цагийн дараа хөдөлгөөн цаашид үргэлжлүүлэх эсэх тухай дүгнэлт гаргах

• Халдвар судалгаа, эмнэл зүйн шинж тэмдэг, шинжилгээний хариуг үндэслэн халдварын эх уурхай, дамжсан зам, голомтын хүрээг тогтоож, халдвар судлалын дүгнэлт гаргаж, хөл хориог ямар хугацаатай тогтоох, хил түр хязгаарлах эсэх асуудлыг гамшгаас хамгаалах штабаар /зохицуулагч/ дамжуулан холбогдох байгууллагуудад тавих

• Голомтод ажиллах, халдвар эсэргүүцэх арга хэмжээг мэргэжлийн удирдлага, заавар, зөвлөмжөөр хангаж ажиллах

• Халдвар эсэргүүцэх арга хэмжээг зохион байгуулсан тайлан, халдвар судлалын дүгнэлт, зарцуулсан хөрөнгийн тооцоог гаргаж улс, нийслэл, аймаг, сумын онцгой комисст илтгэж, холбогдох асуудлыг шийдвэрлүүлнэ.

Хил хамгаалах байгууллага:

• Хилийн боомтын тухай хуулийн 7 дугаар бүлгийн 15 дугаар зүйлийн 2 дугаарт “Боомтод … гоц халдварт өвчин тархах зэрэг онцгой нөхцөл үүссэн үед боомтыг хил хамгаалах байгууллага хамгаалалтад авч, холбогдох байгууллагатай хамтран тусгай дэглэм тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулна.” гэж заасан байдаг.

• Бэлэн байдлын зэрэглэлээс хамаарч хил түр хаах асуудлыг хорио цээрийн байгууллагын халдвар судлалын дүгнэлт, саналыг үндэслэн шийдвэрлэх

• Халдварт өвчний сэжигтэй зорчигч тээвэрлэсэн тээврийн хэрэгслийг тусгай /ариун цэврийн/ талбайд зогсоох, буулгах, хамгаалалтад авах асуудлыг зохион байгуулах

• Бие бүрэлдэхүүнийг амны хаалт, нүдний шил, хамгаалах хувцас, халдваргүйтгэлийн бодис болон бусад шаардлагатай зүйлсээр хангах

• Ажилтнуудыг ямар зэрэглэлийн хамгаалах өмсгөлтэй ажиллуулах талаар хилийн мэргэжлийн хяналтын албанаас зааварчилгаа авах

• Хилийн мэргэжлийн хяналтын алба, хэлтсийн хяналт шалгалтаар эрсдэлгүй болох нь тогтоогдсон зорчигч, тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу хил нэвтрүүлэх асуудлыг шийдвэрлэх

• Хил хамгаалах албаны алба хаагчдыг халдвараас урьдчилан сэргийлэх тарилга, вакцинжуулалтад

хамруулна.

Гаалийн байгууллага:

- Зорчигчийн ачаа тээшийг тусгай /ариун цэврийн/ талбайд байрлуулж, гаалийн ажилтныг халдвар эсэргүүцэх дэглэмийн дагуу оруулж, ачаа тээшийг халдваргүй-жүүлсний дараа хяналт шалгалтад хамруулж бүрдүүлэлт хийсний дараа тээш хадгалах байранд хийх
- Бүрдүүлэлт хийх гаалийн байцаагч нарыг ямар зэрэглэлийн хамгаалах өмсгөлтэй ажиллуулах талаар хилийн мэргэжлийн хяналтын алба, хэлтсээс зааварчилгаа авах
- Гаалийн хяналтын бүс, талбайд шалгалт бүрдүүлэлт хийж байгаа гаалийн байцаагч, шалгагч нарыг амны хаалт, бээлий, шаардлагатай тохиолдолд нүдний шилтэй ажиллуулна
- Халдварын сэжигтэй болон түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүнийг халдвар эсэргүүцэх дэглэмийн дагуу хилийн мэргэжлийн хяналтын алба, хэлтэст шилжүүлэх
- Гаалийн түр болон баталгаат агуулахуудыг хамгаалалтад авч, тэдгээрт орох ачаа, тээш, бараа бүтээгдэхүүнд халдваргүйтгэл хийлгэх
- Байцаагч, шалгагч нарыг амны хаалт, нүдний шил, нэг удаагийн бээлий, хувийн хамгаалах хувцас, халдварын эсрэг эм, халдваргүйтгэлийн бодисоор тасралтгүй хангах
- Гаалийн байцаагч, ажилтнуудыг халдвараас урьдчилан сэргийлэх тарилга, вакцинжуулалтад хамруулна.

Иргэний харьялал, шилжилт хөдөлгөөний байгууллага:

- Халдварт өвчний сэжигтэй зорчигч тээвэрлэсэн тээврийн хэрэгсэлд иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ажилтныг хилийн хорио цээрийн ажилтантай хамт халдвар эсэргүүцэх дэглэмийн дагуу оруулж, хил нэвтрэх эрхийн баримт бичгийн шалгалт хийх
- Халдвараас сэргийлэх, цаашид тархаахгүй байх талаар бие бүрэлдэхүүнд яриа, таниулга хийж бэлэн байдлыг хангуулах
- Бие бүрэлдэхүүнийг амны хаалт, нүдний шил, хамгаалах хувцас, халдваргүйтгэлийн бодис болон бусад шаардлагатай зүйлсээр хангах
- Шалгагч болон бусад ажилтнуудыг ямар зэрэглэлийн хамгаалах өмсгөлтэй ажиллуулах талаар хилийн мэргэжлийн хяналтын алба, хэлтсээс зааварчилгаа авах
- Ажилтнуудыг халдвараас урьдчилан сэргийлэх тарилга, вакцинжуулалтад хамруулна.

Цагдаагийн байгууллага:

- Халдварын голомтын хатуу дэглэм, хагас хязгаарлагдмал ба ажиглалтын бүсэд цагдаагийн хамгаалалт гаргаж, нийгмийн хэв журам сахиулж ажиллах
- Халдварт өвчтэй хүн, зорчигч тээвэрлэн ирсэн, тусгай талбайд байрласан тээврийн хэрэгсэл, стратегийн ач холбогдолтой обьектуудыг /усны эх булаг, усан хангамжийн цэгүүд, хүнсний агуулах г.м/ цагдаагийн хамгаалалтад авах
- Халдвараас сэргийлэх, нийгмийн хэв журам зөрчигдөхөөс сэргийлэх талаар яриа, таниулга, сэрэмжлүүлэг хийх
- Бие бүрэлдэхүүнийг бээлий /нэг удаагийн/, нүдний шил, амны хаалт, хувийн хамгаалах хувцас, халдваргүйжүүлэх уусмал, хамгаалах

өмсгөлөөр хангах

• Халдварын бүсэд ажиллах цагдаагийн ажилтнуудыг ямар зэрэглэлийн хамгаалах өмсгөлтэй ажиллуулах талаар хилийн мэргэжлийн хяналтын алба, хэлтсээс зааварчилгаа авах

• Ажилтнуудыг халдвараас урьдчилан сэргийлэх тарилга, вакцинжуулалтад хамруулна.

Дүгнэлт:

Олон улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэх, уг дүрэмд зааснаар нийгмийн эрүүл мэндэд ноцтой байдал үүсэх аливаа эрсдлийн үед тухайн улсын Засгийн газар, түүний дор ажиллаж буй бодлогын яам, агентлагууд, хил хяналтын байгууллагуудын нягт хамтын ажиллагаа, мэдээлэл солилцооны зөв урсгал, нэгдмэл зохион байгуулалтын арга хэмжээ чухал ач холбогдолтой байгаа юм.

Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсэх магадлал өндөр хүн, мал амьтны гоц халдварт өвчин нэг улсын нутгаас нөгөө улсад дамжин орох болон тэдгээрийн тархалтаас урьдчилан сэргийлэх, халдварт өвчний сэжиг илэрсэн, голомт үүссэн үед Олон улсын эрүүл мэндийн дүрмийн дагуу яаралтай мэдэгдэх арга хэмжээний хамтын механизмыг бүрдүүлэх хүрээнд "Хилийн боомтод хүний олон улсын хөл хориот /гоц халдварт/ өвчний сэжиг илэрсэн үед хил хяналтын байгууллагаас авч хэрэгжүүлэх нийтлэг журам"-ыг боловсруулах, түүний дагуу дадлага сургуулийг тогтмол хийх шаардлагатай юм.

Ашигласан материал:

1. Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД-2005)

2. С.Чимэдсүрэн. "Халдварт өвчний хяналт, тандалт, сэргийлэлтийн ерөнхий зарчим". 2004 он.

3. ДЭМБ-ын "Хил нэвтрэх цэгт бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах" гарын авлага, зөвлөмж. 2013 он.

ТАГНУУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Т.Баяраа. Хилийн сургуулийн Цэргийн сэтгэлзүйн тэнхимийн дэд профессор, докторант, дэд хурандаа

Тагнуул:

1. Зориуд нууцалж буй зүйлийн тухай нууцаар мэдээ олох хэрэгсэл

2. Зарим гадаад орон, эвсэл холбоо, бүс нутгийн цэрэг, улс төрийн байдал, нөөц, хүчин чадал болон бусад асуудлын талаар тагнуулын мэдээ, баримт сэлт цуглуулах, боловсруулах, ашиглах ажиллагаа

3. Улс орны төрийн гадаад бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах хүчин чадал, эдийн засгийг бэхжүүлэхэд ач холбогдолтой нууц

болон бусад мэдээ олох, цуглуулах, боловсруулах, ашиглах ажиллагаа.

Тагнуулын үйл ажиллагаа:

1. Тагнуулын нууцалсан чухал мэдээ олох зорилгоор тусгай албанаас зохиож буй нарийн төвөгтэй арга хэмжээ.

2. Улс орныхоо цэрэг, улс төр, эдийн засгийн гадаад нөхцөл байдал, байр суурьт нөлөөлөх зорилгоор тусгай албаны шууд оролцоотойгоор зохион байгуулж байгаа нууц арга хэмжээ.

3. Зохион байгуулагчдыг нь тогтоох, нотлоход саад бэрхшээл учруулах гэх мэт зорилгоор тусгай алба нууц, далд арга хэлбэрээр зохиож буй арга хэмжээ.

Улс орныхоо үндэсний аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор тухайн орны тусгай албадаас нууцаар явуулж буй арга хэмжээг тагнуулын ажил гэж ойлговол зохино. Энэ нь мэдээ, мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, мэдээ, мэдээллээ хэрэглэгчдэд хүргэх үйл ажиллагаа юм. Аль ч улсын тагнуулын байгууллагын үүрэг зориулалт нь улс үндэснийхээ аюулгүй байдлыг тагнуулын аргаар хамгаалах нэгдмэл зорилготой бөгөөд дараах үүрэг, зорилгыг хэрэгжүүлдэг. Үүнд:

1. Төрийн бодлого, шийдвэр гаргах үндсийг бэлдэж өгөх

2. Тагнуулын нууц арга хэмжээг төлөвлөж, зохион явуулах.

Тагнуулын үйл ажиллагаа нь тухайн улсын төрийн гадаад бодлогыг хэрэгжүүлэгч хүчирхэг хэрэгсэл юм. Энд дараах асуудлуудыг багтаан авч үздэг .

1-рт Өөрсдийн нөөц боломж, чадвараа урьдчилан тооцсон байх

2-рт Тагнуулын үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хэмжээний хүч, хэрэгсэлтэй байх

3-рт Тагнуулын үйл ажилллагаа шуурхай, үр дүнтэй явагдсан байх

Дээрх байдлаас үзэхэд аливаа өөрчлөлтийг зөвхөн мэдрэх төдий биш, харин тодорхой судалгаа дүн шинжилгээ хийх замаар үйл явдлын учир шалтгааныг олж тогтоох нь тагнуулын байгууллагын үйл ажиллагаа амжилттай явагдах нэг үндсэн нөхцөл болдог. Өөрөөр хэлбэл Тагнуулын байгууллага нь үйл явдлын өрнөлийг урьдчилан харж, үнэн бодит мэдээ, мэдээллээр төр засгийн удирдлагыг хангах үндсэн чиг үүрэгтэй. Сайн дүн шинжилгээ хийсэн мэдээ, мэдээлэл нь шийдвэр гаргагчдын үйл ажиллагаанд тодорхой дэмжлэг үзүүлж, улмаар бодлого, чиглэл тодорхойлох үндсийг бэлдэж өгдөг.

Тагнуулын үйл ажиллагааны ангилал:

А. Нутаг дэвсгэрийн хүрээнд

1. Гадаад тагнуул: Үндэсний аюулгүй байдалд гадаадаас учирч болзошгүй аюулаас хамгаалах зорилгоор тухайн орны гадаад тагнуулын албанаас гадаад улс,түүний байгууллага, төлөөлөгчийн газрын далд үйл ажиллагаа, эрмэлзэл, сонирхол, түүнийгээ хэрэгжүүлэх бололцоо нөхцлийн тухай болон бусад мэдээ олох ажиллагааг хэлнэ.

2. Дотоод тагнуул: Тагнуулын байгууллагад хуулиар харьяалуулсан гэмт хэрэгтэй холбоотой мэдээ, мэдээллийг олох ажиллагааг хэлнэ.

Б.Хамрах хүрээгээр нь

1. Стратегийн тагнуул: Улс орны улс төрийн зорилтыг бүхэлд нь болоод гадаад улс төрийн үйл ажиллагааны тодорхой салбар зорилтыг хангах

зорилго бүхий гадаад тагнуулын үйл ажиллагаа буюу стратегийн тагнуулын үйл ажиллагаа явуулдаг тагнуулын байгууллага, салбар нэгжийг хэлнэ.

2. Тактикийн тагнуул: Бага хүрээний буюу тактикийн зорилтыг шийдвэрлэхэд чиглэсэн тагнуулын үйл ажиллагааг хэлнэ. Тактикийн зорилт нь стратегийн зорилтоосоо урган гарч түүнийг шийдвэрлэхэд тусалдаг. Өөрөөр хэлбэл тактикийн тагнуулын үйл ажиллагаа гэдэг нь өдөр тутам өнгөрч байдаг өөрөөр хэлбэл яг өнөөдөр яригдаж байгаа асуудлууд дээр явагддаг тагнуулын үйл ажиллагаа, стратегийн тагнуулын үйл ажиллагаа гэдэг нь маш том онц чухал үйл ажиллагаануудад урт хугацаатай төлөвлөгөө гарган ажилладаг тагнуулын үйл ажиллагааг хэлнэ.

В. Явуулах орчноор нь

1. Газрын
2. Агаарын
3. Сансрын
4. Тэнгисийн

Г. Үүрэг зориулалтаар нь

1. Цэргийн тагнуул: Дайсан болон болзошгүй дайсан орны зэвсэгт хүчин, түүний байлдааны бэлтгэл, байлдах чадвар, зэвсэглэл, цэргийн нөөцийн талаар мэдээ олох ажиллагааг хэлнэ.

2. Улс төрийн тагнуул: Гадаад орнуудын улс төрийн зорилго, зорилт бодлого төлөвлөгөө, харьцаа, гадаад дотоод улс төрийн бодлого, нөлөө бүхий улс төрчдийн тухай гэх мэт асуудлаар мэдээ олох ажиллагааг хэлнэ.

3. Эдийн засгийн тагнуул: Гадаад орны эдийн засгийн байдал, үйлдвэр, тээвэр, холбоо, мөнгө санхүү, ашигт малтмалын үйл ажиллагааны талаар мэдээ олох гадаад тагнуулын ажиллагааны нэг төрөл юм.

4. Шинжлэх ухаан, техникиийн тагнуул: Гадаад орны шинжлэх ухаан техникийн ололт, нээлт, нөөц, шинжлэх ухааны чухал байгууллагын тухай нууц мэдээ олох зорилго бүхий гадаад тагнуулын үйл ажиллагааны нэг төрөл юм.

Д. Явуулах аргаар нь

1. Тагнуулч, туршуулыг ашиглан явуулах тагнуулын үйл ажиллагаа: Тагнагдагч орны иргэдийн дундаас элсүүлсэн болон тухайн оронд нэвтрүүлсэн тагнуулч, туршуулаа ашиглан явуулах тагнуулын ажлыг хэлнэ.

2. Техникийн тагнуул: Тусгай техник хэрэгсэл ашиглахад үндэслэсэн тагнуулын үйл ажиллагааны бие даасан төрөл юм.

Техникийн тагнуулыг радио тагнуул, радиотехникийн тагнуул, цахилгаан соронзон долгионыг хүлээн авахад суурилсан радиолакацийн болон телевизийн тагнуул, гэрлийн долгионыг хүлээн авахад суурилсан фото болон хэт ягаан туяаны тагнуул, газар хөдлөлтийн чичирхийллийн долгионыг хүлээн авахад суурилсан газар хөдлөлтийн тагнуул, цацраг идэвхит бодисын задралаас үүсэх цацралд суурилсан радиацийн тагнуул гэх мэтээр ангилдаг.

Радиотагнуул: Холбооны хэрэгслээр дамжиж байгаа ил болон нууц яриаг радио хэрэгслийн тусламжтайгаар мэдээ олох техникийн тагнуулын нэг төрөл юм.

Радиолакацийн тагнуул: Газар, далай тэнгис, агаар дахь обьектын байршил, пуужингийн нислэгийн муруй, цөмийн дэлбэрэлтийн төвийг тодорхойлоход цацрал үүсгэгч радио

хэрэгслийг ашиглахад үндэслэсэн техникийн тагнуулын нэг төрөл юм.

Радиацийн тагнуул: Хөрс ургамал, усанд үлдсэн цацрагийн хэмжээ, цацраг идэвхит бодисын задрал түүний шинж байдлыг дозиметрийн хэрэгслийг ашиглан тодорхойлох ажиллагааг хэлнэ.

Е.Тагнуулын ажлын үе шат

1. Мэдээ олох: Тагнуулын ажлын хамгийн анхны шат бөгөөд мэдээ, мэдээлэл олох, цуглуулах үйл ажиллагаа нь мэдээ мэдээллийг боловсруулах ажлын суурь болдог.

2. Мэдээнд дүн шинжилгээ хийх: Ил далд эх сурвалжаас олсон мэдээ мэдээллийг үнэлж, бусад эх сурвалжийнхтай харьцуулж, задлан шинжилгээ хийх ажиллагааг хэлнэ.

Мэдээ, мэдээллийг цуглуулах ажилд тагнуулын техник хэрэгсэл голлох үүрэгтэй оролцдог бол харин дүн шинжилгээний ажилд хүний оюун ухаан, сэтгэн бодох чадвар чухал үүрэгтэй байдаг.

3. Мэдээг боловсруулж, хэрэглэгчдэд хүргэх: Ил далд эх сурвалжаас олсон мэдээ, мэдээллээ "тагнуулын мэдээний шаардлагад" оруулан хувирган өөрчлөх үйл ажиллагааг хэлнэ.

ХИЛИЙН ТҮҮХ

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТҮҮХИЙН СУДАЛГААНД Б.ЦЭДЭН-ИШИЙН ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ

Ц.Ганболд. Доктор /Ph.D/, профессор, хурандаа



Аливаа улс орны нийтлэг шинжтэй онцлог зүйл бол улсын хил, газар нутгийн асуудал бөгөөд энэ нь мөнхийн шинжийг агуулдаг. Түүх нь аливаа улс орны төр, байгууллагуудын амьдралын залгамж чанарт үндэслэсэн, уламжлалт шинжийг агуулсан үйл явдлын тасралтгүй үргэлжилсэн гинжин холбоо юм. Улсын хил, газар нутаг, түүхийн асуудал хоёр нь дээрх товч тодорхойлолтоос харахад тасралтгүй мөнхөд үргэлжлэх, залгамж чанартай, тусгаар улс байхын гол шинжийг илэрхийлж, өөр хоорондоо нягт уялдсан, харилцан хамааралтай болох нь харагдаж байна.

Хил судлалын шинжлэх ухаанд хилийн болон хил хамгаалалтын түүх нь бие даасан салбар болон судлагддаг бөгөөд тэр нь: Улсын хил бүрэлдэн тогтсон түүх, хил хамгаалалтын түүх, хил хамгаалах урлагийн түүх, хилийн цэргийн байгуулалтын түүх, хилч сэтгэлгээний түүх зэргээс бүрддэг.

Улсын хилийн түүх гэдэг бол газар зүй, түүх, хил судлал гэсэн гурван том шинжлэх ухааны уулзвар, зааг дээр орших бөгөөд энэ торгон зааг, агшин дээр МУ-ын хилийн түүхийг судлах, хөгжүүлэхэд үнэт хувь нэмэр оруулсан хүн бол түүхийн ухааны доктор Б.Цэдэн-Иш болой.

Монголын үе үеийн хилчдийн дунд "Улсын хилийн нэвтэрхий толь" хэмээн алдаршиж "Хилийн амьд домог" болон мөнхөрсөн Хөх Ишгэнтийн хилийн цагдаа, харуулын даргаас Хязгаарын ба Дотоодын цэргийн хэрэг эрхлэх газрын дарга, НАХЯ-ны орлогч сайд хүртэлх албыг хашиж, Монгол Улсын хил бүрэлдэн тогтсон түүхийг судлах, "Одоогийн" хилийг тодорхойлох, тогтоох, баталгаажуулах ариун үйлсэд өөрийн жинтэй хувь нэмрийг оруулсан хилчин-түүхч билээ.

Зууны турш амьдарч, бүхэл бүтэн жарныг нь Монгол Улсын тусгаар тогтнол, хилийг хамгаалах, МУ-ын хилийн түүхийг өнө эртнээс нь аваад өнөө эдүгээ хүртэл судлах, үе хойчдоо үнэн түүхээр нь үлдээх, өнөөгийн хилийн түүхийг бичихэд түүхэн үүрэг гүйцэтгэсэн судлаач юм.

Монгол Улсын хилийн түүхтэй холбоотой 7 төрлийн 121,5 хх нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага, 33 шинжлэх ухааны өгүүлэл нийтлэл, Монгол Улсын хил хамгаалалтын

түүхтэй холбоотой 3 төрлийн 26,2 хх сурах бичиг, гарын авлага, 12 өгүүлэл нийтлэл туурвиж нийтийн хүртээл болгосон нь энэ бүхний баталгаа болно.

Хил судлалын шинжлэх ухааны үндсэн тогтолцоо, судлагдахууныг бүрдүүлэгч чухал хэсэг болох хилийн түүх, хил хамгаалалтын түүх гэсэн хоёр том салбарт ихээхэн амжилт гаргасан түүхч бол Б.Цэдэн-Иш билээ.

Б.Цэдэн-Иш докторын "Монгол Улсын хил бүрэлдэн тогтсон түүхээс" 2003 оны 25.3 хх, "БНМАУ-ын хил хязгаар бүрэлдэн тогтож ирсэн түүхэн сурвалж баримт бичгүүдийн эмхтгэл" 1990 оны 28.7 хх бүтээлүүдийг МУ-ын хилийн түүх судлалын оргил бүтээлүүд гэж нэрлэж болно.

"Дархан хилийн домогт сургамжууд" 1979 оны 9.5 хх, "Төрөлх нутгийн төө газрын төлөө", 1976 оны 7.5 хх, зэрэг бүтээлүүд нь МУ-ын хил хамгаалалтын түүхийн асуудлаар туурвисан сор бүтээлүүд бөгөөд үе үеийн хилчид эдгээр бүтээлүүдээс суралцаж, хүмүүжиж өдий хүрснийг хилчин бүхэн мэдэх бөгөөд "Хилчдийн ширээний ном"-оор зүй ёсоор нэрлэгддэгийг энэ өндөр индэр дээрээс бахархан дурьдахад таатай байна.

Эдгээр түүхэн бүтээлүүдийн агуулгыг тодорхой ярих шаардлагагүй бөгөөд хилийн судалгааны түүхэн цар хүрээгээрээ, ач холбогдлоороо, хилийн түүхийн судлагдахууны үнэт сурвалж гэдгээрээ үнэ цэнээ алдаагүй, дахин давтагдашгүй мөнхийн бүтээл гэдгийг л онцгойлон тодруулах гэсэн юм.

Түүхч Б.Цэдэн-Иш нь Монгол Улсын хилийн түүхийг эрт эдүгээ, өнөө, ирээдүй гэсэн гурван цагийн хэлхээсэнд судлан Монгол Улсын хилийг улс төр-дипломатын аргаар хамгаалах онолын асуудлыг практикаар баталсан хилийн дипломатч хүн юм.

Доктор Б.Цэдэн-Ишийн Монгол Улсын хилийн түүхийг сонгодог аргуудаар нь судалсан төдийгүй улируулан судлах, мөшгих судалгааг оновчтой ашиглах арга зүйг тодорхойлж, Монгол Улсын хилд биечлэн явж, хээрийн шинжилгээний тусгай ангийн үйл ажиллагаагаар цогц судалсан эрдэм шинжилгээний уйгагүй эрэлч хүн юм.

Хаант Орос–Манж Чин Улсын хооронд 1727 онд байгуулсан Буурын гэрээгээр Монголын хилийг Оросоос тусгаарласан 83 овооноос 82-ыг нь олж тогтоон бүртгэх зэргээр хилд биечлэн судалгаа хийхдээ 50–55000 км замыг туулан гүйцэтгэсэн байдаг.

Түүхийн ухааны доктор Б.Цэдэн-Ишийн хилийн болон хил хамгаалалтын түүхэнд оруулсан хувь нэмрийг бүтээл туурвилаар нь төдийгүй, тодорхойлон тогтоогдож, НҮБ-аар баталгаажсан Монгол Улсын бодит хилээр нь үнэлэх ёстой.

Доктор Б.Цэдэн-Иш нь Монгол Улсын хилийг өөрөө үлгэрлэн биечлэн судлах төдийгүй "Хилийн түүх судлалын сектор" эрдэм шинжилгээний байгууллагыг санаачлан байгуулсан, удирдсан, залуу судлаачдыг бэлтгэх, сургах, төлөвшихөд үнэт хувь нэмрээ оруулсан соён гэгээрүүлэгч, хилийн болон хил хамгаалалтын түүх судлалын үндсийг тавигч гэж зүй ёсоор үнэлэгддэг юм.

Доктор Б.Цэдэн-Ишийн түүх судлалын өвийг баяжуулж, хилийн түүхээр судалгаа явуулдаг И.Саруул, Ж.Гэрэлбадрах, Э.Лувсанбалдан, Д.Шүрхүү, На.Сүхбаатар, Ч.Алтангэрэл,

Х.Хүүжий, Н.Даваадорж нарын шавь нь, хамтран зүтгэгч, эрдэмтэн судлаачид байгаа болно. Доктор Б.Цэдэн-Ишийн бүтээл туурвилын талаар болон түүхч, эрдэмтэн, соён гэгээрүүлэгч болохыг нь онцолсон 22 найруулал, хөрөг найруулал, дурсамжийг 16 эрдэмтэн, сэтгүүлч, дипломатч туурвисан нь Б.Цэдэн-Ишийг хэн бэ? гэдгийг тод томруун харуулсан үзүүлэлт юм.

Б.Цэдэн-Иш өөрөө доктор төдийгүй өөрийн 3 хүүхэд, бэрийг эрдэм ном, шинжилгээ судалгааны ажилтай нөхөрлүүлж, эрдэмд шамдуулан сургаж, шинжлэх ухааны салбар бүрийн дөрвөн докторыг төрүүлсэн эрдэмт гэр бүлийн тэргүүн, халамжит эцэг юм.

Доктор Б.Цэдэн-Ишийн мэндэлсний 110 жилийн түүхт ойг өргөн тэмдэглэж байгаа нь түүний үйл ажиллагааг нь үргэлжлүүлэх, өвлүүлэх, эхлэлийг нь тавьж анхны шанг нь татсан хилийн түүх судлалыг хөгжүүлэхэд түлхэц өгсөн томоохон арга хэмжээ болж байна.

Генерал, доктор, Б.Цэдэн-Ишийн хилийн болон хил хамгаалалтын түүхэнд оруулсан оюуны болон түүхэн бодит хувь нэмрийг баяжуулах, хөгжүүлэх, үргэлжлүүлэн судлах шаардлага, хэрэгцээ, нийгмийн захиалга, хүлээлт байсаар байна. Энэ хүлээлт, шаардлага, хэрэгцээг өнөөгийн хилчин бид биелүүлэх ёстой, харин яаж, хэрхэн биелүүлэх ёстой вэ? гэдэгт хариулт өгөхийг оролдож, хилч ухаанаа уралдуулъя !

Өчүүхэн судлаач минийхээр бол:

- Хил судлаач, хилийн түүхч, түүхийн ухааны доктор Б.Цэдэн-Ишийн залгамж халааг бэлтгэх ёстой. Үнэт өвийг нь, хилийг судлах ёстой;

- Хилийн болон хил хамгаалалтын түүхийн судалгааг эрчимжүүлэх, Хилийн судалгааны төвүүдийг нэгтгэн "Хилийн хүрээлэн" болгон өргөжүүлэх;

- Хилийн түүхийн асуудлаар судалгаа явуулдаг эрдэмтдийг бодлогоор дэмжих, эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх боломж бололцоог олгох, бүтээл туурвилыг нь нийтийн хүртээл болгох, хил болон хил хамгаалалтын түүхийг гүнзгийрүүлэн судлах хээрийн шинжилгээ-судалгааны багийг бүрдүүлж ажиллуулах;

- Хилийн түүх судлалд гадаад эх сурвалжийг өргөн ашиглах боломжийг нээх, хилийн түүх гадаад, дотоод эх сурвалжуудаар баталгаажиж, харьцуулсан судалгаа явуулбал илүү цогц болох юм;

- Өнөө үед хилийн түүхийн асуудлыг анги, салбарын түүх бичих төдийгөөр л хязгаарлаж байгаад зарчмын болон чанар, арга зүйн эргэлт гаргах;

- МУ-ын хил хамгаалалтад тодорхой бодит, түүхэн үүргээ гүйцэтгэсэн хүмүүсийг алдаршуулах, өв бүтээлийг нь уламжлуулах, судалгааг гүнзгийрүүлэх тал дээр нь хилийн эрдэм шинжилгээ судалгааны байгууллагууд анхаарах ёстой.

Цаг хугацаа, үнэлэмжийн орон зайн хувьд хожуу ч гэсэн хилийн 0243 дугаар ангийг Б,Цэдэн-Ишийн нэрэмжит анги болсонд талархаж байгаа бөгөөд энэ ажлыг үргэлжлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Генерал Б.Цэдэн-Ишийн хил хамгаалах албаны гараагаа эхэлсэн Хөх Ишгэнтийн түүхэн харуул нь одоогийн Хилийн 0275 дугаар ангийн 0238 дугаар салбар буюу Ямлахын заставын

хариуцсан хэсэгт хилийн 890 дүгээр баганын II дугаар туслахын чиглэлд оршдог байсан юм байна. Хилийн 0238 дугаар салбарыг, ХХЕГ-ын Стратегитүүх судалгааны төвийг Б.Цэдэн-Ишийн нэрэмжит болгох саналыг дэвшүүлж байна. Түүхэн хүмүүсийн нэр, алдар, гавъяатай холбоотой газар, байгууллагыг нэрэмжит болгон алдаршуулах нь хувь хүнийг төдийгүй түүний бүтээл, туурвил, хилийн түүхийг бүдэгрүүлэхгүй байх, тухай хамт олныг идэвхжүүлэхэд асар их ач холбогдолтой.

Мөн Монгол Улсын хил тогтоох, хилийн асуудлыг түүхэн хилийн үүднээс авч үзэхэд анхаарч Монгол Улсын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал, хилийн бүрэн бүтэн байдлыг хангахад бодит хувь нэмрээ оруулсан Сайд нарын зөвлөлийн орлогч дарга, ГХЯ-ны сайд агсан С.Аварзэдийн түүхэн гавъяаг хилчид бид, Монголын ард түмэн мартах ёсгүйг ГХЯ-ны ажилтнууд оролцож буй учраас дурьдахгүй байж чадсангүй.

Монгол Улсын газрын зураг дээр цэг төдий тэмдэглэгддэг ч одоогийн үнэлгээгээр 2,4 триллион доллароор үнэлэгдсэн Асгатын мөнгөний уурхайтай хилийн хэсэг зэрэг ихэнх нутгийг түүхэн хилээр нь авч үлдсэн гавьяаг нь үнэлж, Асгатын заставыг С.Аварзэдийн нэрэмжит болгох саналыг дэвшүүлж байна. Энэ нь асуудлыг сөргүүлэн тавьж байгаа явдал огт биш бөгөөд хилийн түүхэн үнэнийг бүдгэрүүлэхгүй байх, хилийн алдартнуудаа мөнхжүүлэх ёстой гэдгийг л сануулсан төдий юм.

ХҮЙТЭН ДАЙНЫ ҮЕИЙН АХМАД ХИЛЧДИЙН НИЙГМИЙН АСУУДАЛ

Д.Бухбат. Ахмад хилчин, бэлтгэл хурандаа

Монголчууд улсынхаа хилийг хэдэн зуун, магадгүй мянган жилээр хамгаалж ирсэн түүхэн уламжлалтай ч орчин үеийн хил хамгаалах байгууллага үүсч хөгжөөд ердөө 80 гаруйхан жил болж байна.

Үүний сүүлийн 30-аад жилд нь би улсын хил хамгаалах албанд зүтгэжээ. Гэхдээ ажилласан хугацааны маань нилээд хэсэг нь хүйтэн дайны, үлдэх хэсэг нь тайван цаг байж. Хүйтэн дайны үед фронтын шугам (улсын хил) дээр үүрэг гүйцэтгэснээ одоо бодоход жаахан жихүүцмээр ч, бас бахархмаар. Харин энэ дайны онцлогтой уялдан, хилчид байгаль цаг уурын хүнд нөхцөл, өдөр шөнийн аль ч цагт, улсын хил дээр үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан шууд л дайсны суманд өртдөг байв.

Зөвхөн миний ажиллаж байсан отрядын хариуцсан хэсгээр гарсан зарим тохиолдлыг дурьдваас: Дэслэгч Я.Батням улсын хилд албан үүрэг гүйцэтгэж яваад ГАЗ-66 машиныхаа кабины дээд хэсгийг "шүүрэн шанага шиг" болтол дайсанд буудуулчихаад, жолоочийнх (Төв аймгийн харьяат байлдагч Батсайхан) нь шилэн хүзүүнд сум ороод тогтчихсон ирж байсан юм.

Мөн Хэнтий аймгийн харьяат Пүрэвсүрэн нарын хоёр байлдагч улсын хил дээр дайсны суманд өртөж нэг нь амь насаа алдаж, нөгөө нь морио буудуулж алуулан явган гүйж ирж байсан

эмгэнэлт явдал ч гарч байв. Буудуулсан цэргийн цогцсыг Хятадууд, хөлөөс нь чирээд л аваад явчихаж байсан. Хожим нь бид уг цогцсыг хилийн уулзалтаар буцаан авсан. Түүнчлэн манай хөрш отрядын хариуцсан хэсэгт албан үүргээ гүйцэтгэж явсан хошууч Очир ахлагчтай хилийн манааны бүрэлдэхүүн, Хятадын талд баривчлагдан 7 жил шоронд хоригдож нэг офицер нь хоёр удаа дотор эрхтэндээ мэс ажилбар хийлгэн, суллагдаж ирсэн тохиолдол ч бий.

1988 оны зун юм даг, манай отрядын хилийн -р заставын хариуцсан хэсгээр Хятадын талаас хил зөрчин орж ирсэн этгээд манай хилчдэд илчлэгдсэнийхээ дараа эсэргүүцэл үзүүлсэний учир хилчид түүнийг буудаж шархдуулан баривчилж байсан тохиолдол бас байдаг юм.

Байнгын түгшүүрт байдлын тэр жилүүдэд эсрэг талаас ихэвчлэн оргодол босуул, төөрсөн малчин эсвэл галзуу солиотон гэх мэт янз бүрийн халхавчаар хил зөрчигчид их орж ирдэг байсан бөгөөд тэдний дийлэнхи нь манай улсын хилийн харуул манаа, цаашилбал застав отрядын байрлал үйл ажиллагааг тагнан мэдэх үүрэг даалгавартай ирсэн болохоо мөрдөн байцаалтын явцад хүлээсэн байдаг юм.

Бид улсын хилээ өдөр шөнийн 24 цагийн турш сахиж хамгаалахын зэрэгцээ, хилийн застав отрядууд дайсантайгаа зах нийлсэн байрлалаас байлдаанд орох байнгын бэлтгэлтэй байх, байлдааны болоод улс төрийн бэлтгэл сургуулийг дайн байлдааны нөхцөлд аль болох ойртуулан явуулах, байлдааны зэвсэг техник, бусад нөөцүүдийг тогтмол бэлэн байлгаж, зохих горимын дагуу бэлтгэж шинэчлэх зэрэг нь тийм ч амар хялбар ажил байгаагүй юм.

Тодорхой хугацаа, эсвэл нөхцөл байдлын өөрчлөлтийн улмаас байнга тодотгодог байсан "байлдааны хуваарь"-т л гэхэд байлдааны ажиллагааны үндсэн элементүүдээс гадна" ар гэрийн хүмүүсийг нутгийн гүнд татах бүлэг" хүртэл томилогдож тэр дагуугаа дадлага сургууль тогтмол хийдэг байсныг тэр үед ажиллаж байсан гэр бүлийн хүмүүс ч санаж байгаа байхаа.

Хилийн нэг л отрядын жишээн дээр эдгээрийг цухас дурьдахдаа би, хүйтэн дайны үеийн улсын хил дээрхи нөхцөл байдал, хилчдийн үйл ажиллагааны талаар бага боловч ойлголт өгөхийг зорив.

Харин өнөөгийн нийгэм, түүний дотор төр засгийн удирдлага ч, дээрхи нөхцөл байдлын талаар бага мэдэж, ихэнхи нь бараг мэдэхгүй шахам байгаад үнэн хэрэгтээ ахмад хилчид бид өөрсдөө буруутай гэж бодогдоно. Энэ талаар Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн зохиолч, сэтгүүлч До.Цэнджавын "Маргааш л дайн эхлэх юм шиг 1080 хоног минь" нэртэй эссэ баримтат туужаас өөр тухайн үеийн хилийн застав салбарын "уур амьсгал" түгшүүрт байдлын тухай баримт өгүүлсэн ном зохиол, нийтлэл материал бараг л гараагүй болов уу. Гэтэл гавьяат сэтгүүлч маань тэр үед улсын хил дээр 3-жил алба хаасан жирийн цэрэг. Харин дархан хилээ хамгаалах албанд 30 жил зүтгэсэн хилчин офицер ахлагч нар нь дээрхи түгшүүрт байдлын нөхцөлд дунджаар 10 орчим мянган хоног үүрэг гүйцэтгэж илүү их хүндрэл бэрхшээлийг туулсан хүмүүс билээ. Миний хувьд энэ

өгүүлэлээр хэлэх гэсэн гол санаа маань зөвхөн энэ биш, харин дараах юм.

Халх голын болоод Чөлөөлөх дайн, Баруун хязгаарын тулгаралт-байлдаануудад оролцсон ахмад дайчдын талаар төр засгаас зохих арга хэмжээ авсан бөгөөд, өнөөдөр он цагийн эрхээр тэдгээр ахмадууд маань ч цөөрч байх шиг байна.

Тэгвэл одоо хүйтэн дайны үеийн ахмад дайчид, ялангуяа уг дайны тэргүүн шугамд үүрэг гүйцэтгэсэн ахмад хилчдийн талаар төр засгаас, тусгайлсан арга хэмжээ авах цаг нь нэгэнт болжээ.

Хүйтэн дайн нь тухайн үедээ бие биенийхээ эсрэг зогссон хоёр системийн хоорондох дайн байсан бөгөөд бид үндсэндээ тэр үеийн Зөвлөлт гүрний зэвсэг техникийн хангамжтайгаар, социалист системийн өмнөт хилийг дангаараа хамгаалж байсан юм. Энэ утгаараа ч Монгол улсын өмнөт хилийн хамгаалалт нь Олон Улсын чанартай үйл ажиллагаа байсныг, өнөөдөр тэр үеийн зарим ахмад хилчдийн энгэрт хааяа үзэгдэх социалист гэгдэж байсан орнуудын хүндэт болон онц хилчин тэмдгүүд тодруулан сануулж байх шиг.

Гэвч миний мэдэх, тухайн үед үүргээ нэр төртэй биелүүлсэн олон ахмад хилчид тэтгэвэртээ гарсныхаа дараа, нилээд нь хилийн аймаг сумандаа суурьшин үлдэж, харин зарим нь Улаанбаатарт шилжин ирсэн боловч тохитой орон сууцгүй, хувьдаа өмчилсөн газаргүй, ах дүү үр хүүхдээ бараадан хэрэн хэсч явна.

Үүний дээр аль ч үеийн хилчдэд түгээмэл тохиолдож ирсэн, үр дагавар нь харьцангуй хожим илэрдэг гол бэрхшээл нь: Нэгдүгээрт, хилчин офицер улирагсадын гэр бүлийн хүмүүс хэдийгээр дээд болон тусгай дунд боловсролтой хүмүүс байвч, тэдэнд хилийн застав отрядад мэрэгжлийнхээ дагуу хийх ажил олддоггүй учраас хилийн заставт угаагч, тогооч, ариун цэврийн зааварлагч зэрэг бага цалинтай ажил хийсээр насны эцэст хамгийн бага тэтгэвэртэн болдог. Хоёрдугаарт, хилийн отряд заставт хүүхдийн сургууль цэцэрлэг хүрэлцээгүй, ихэнхи тохиолдолд байдаггүйгээс офицер ахлагч нарын хүүхдүүд сурлага хүмүүжлээр доголдох нь түгээмэл байдаг. Гуравдугаарт, "Цэргийн хүн цагаан зээр хоёр нутаггүй" гэсэн хэлц үг байдаг ч хилчин офицер нь хилийн нэг хязгаараас нөгөө хязгаар хүртэл нүүдэг учир түүний нүүдлийг цагаан зээрийнхтэй ч зүйрлэх аргагүй юм.

Тухайн үед, улсын хил хамгаалалтыг "байлдааны үүрэг" хэмээн авч үзэж хилийн цэрэгт алба хаах хүмүүсийн талаархи судалгааг Улсыг ажуулаас хамгаалах байгууллага тусгайлан хийдэг байсан юм.

Иймээс өмнөх нийгмийн үед бид, өгөгдсөн томилгоот үүргийг, надад эх орноо хамгаалах үйл хэргийн төлөө өгч буй байлдааны тушаал хэмээн үзэж уг дуугүй биелүүлдэг байсан боловч, үүний эцэст өнөөгийн байдлаа бусадтай харьцуулан дүгнэж үзэхнээ, булан нь цоорсон хэдэн чемоданаас өөр үндсэн хөрөнгөгүй, зуслангийн байшин ч үгүй хоцорсон байгаагаа ахмад хилчид харамсан ярьцгаадаг болсон зэргийг, асуудал нэг бүрээр нь судлан үзэж холбогдох арга хэмжээг авууштай.

Хөндөж буй ахмад хилчдийн нийгмийн асуудал нь төсөв мөнгөний талаасаа ч төр засагт тийм их хүндрэл

бэрхшээл учруулах зүйл биш билээ.

Учир нь энэ дайн, монгол улсын хилийн хэсэгт 1960-аад онд хоёр их хөршийн маань хоорондын харилцаанд гарсан сөрөг өөрчлөлтөөр эхэлж, 1990-ээд он хүртэл ердөө 20 гаруйхан жил үргэлжилсний дээр, дээрхи цаг хугацааны эхний үед ажиллаж байсан ахмад хилчдийн тоо ч цагийн эрхээр нилээд цөөрчээ.

Юуны түрүүнд 90-ээд оноос өмнө улсын хил дээр үүрэг гүйцэтгэсэн ахмад хилчдийг ажилласан жил насны байдлыг нь харгалзан ахмадын орон сууцанд очер дугаар харгалзахгүй оруулах, хувьд нь орон сууц олгох, үгүйдээ л хот аймгийн төв, тэдний хүссэн газарт нь, газар өмчлүүлэх асуудлыг "комьпютерын сугалаа таарахыг нь хүлээхгүйгээр" шийдвэрлэх хэрэгтэй.

Нягталж үзвээс тайван цагт үүрэг гүйцэтгэсэн өнөөгийн офицеруудынхтай харьцуулахад, хүйтэн дайны үед алба хашиж 1990-ээд онд тэтгэвэрт гарсан офицеруудын өнөөдөр авч буй тэтгэвэр нь харьцангуй бага, тэдэнд нэг удаагийн буцалтгүй тэтгэмж болгож 2008 онд нэг сая төгрөг олгосон зэрэг нь өнөөдрийнхөөс үлэмж доогуур байна. Иймд офицер ахлагч нарын тэтгэвэрийг хэзээ тэтгэвэрт гарснаас нь үл хамааруулан, хашиж байсан албан тушаалынх нь зэрэглэлд нийцүүлэн жигд болгож шинэчлэх хэрэгтэй байна.

Үүний зэрэгцээ, тэдний тэтгэвэр цаашид нэмэгдвээс, ямар төвшиний ажилтан байсныг нь үл харгалзан адилхан хандаж нэмдэг байх зарчимд ч шилжих нь зүйтэй.

Өөрөөр хэлбэл офицер ахлагч нарт анх тэтгэвэр тогтооход нь л хашиж байсан алба, авч байсан цалингаас нь хамааруулан ялгаатай тэтгэвэр тогтоох бөгөөд харин тэтгэвэрт гарсных нь дараа бол, уг тэтгэвэр авагч нь генерал байсан уу, жирийн ахлагч байсан уу, гэдгийг үл харгалзан ижил хандана гэсэн үг.

Давтан онцолвоос, ижил зэрэглэл, төвшиний ажил алба хашиж байсан офицер ажилтнууд хэзээ тэтгэвэрт гарснаасаа хамааран ижил бус тэтгэвэр авч байгаа өнөөгийн байдлыг л даруй халах ёстой гэж үзэж байна.

Харин тэдний цолны мөнгийг эдүгээ цагийн ханшаар нь тооцож, тэтгэвэр дээр нь нэмж олгодог байвал зохистой бөгөөд, ингэвээс цэргийн цол ч илүү үнэ цэнэтэй болох билээ.

Тодруулж тэмдэглэхэд, манай улсын, төрийн хилийн бодлого нь хүйтэн дайны үед ч өнөөгийнхтэй адил "улсын хилийг аль болох тодорхой бөгөөд зөрчилгүй байлгах, улсын хил дээр аль болохоор зэвсэг үл хэрэглэх" агуулгатай байсан хэмээн үзэж болох юм. Гэтэл өмнөд хөршийн маань хилийн бодлого хандлага нь манайхаас нилээд өөр байсны улмаас манай хилчид эрсдэлд орох нь илүүтэй байсан болов уу.

Ер нь хүйтэн дайны үеийн төрийн хилийн бодлогыг хэн хэрхэн тодорхойлж байсан болон холбогдох бусад олон асуудлаар судалгаа шинжилгээний ажил хиймээр байгаа юм.

Гэхдээ хүйтэн дайны үеийн хилийн цагийн байдлын хүндрэлийг 1967 оноос эхлэн Монгол Хятадын харилцаа эрс муудсан үе, 1979 онд тухайн үеийн Хятадын эрх баригчид Вьетнамд довтолсны дараах үе гэх мэтчилэн тогтоож, авах арга хэмжээг

дэс дараатай, зохих ялгамжтай авч үзэх ёстой байх.

Ахмад хилчдийн нийгмийн асуудлыг сайжруулах талаар авч болох эдгээр арга хэмжээнүүд нь зөвхөн хилчин ахмадууд төдийгүй, харьцангуй хүнд нөхцөлд үүрэг гүйцэтгэж байгаа өнөө цагийн хилчдэд ч зохих урам өгч, тэдний ирээдүйдээ итгэх итгэлийг улам нэмэгдүүлж, улмаар улсын хил хамгаалалтын чанар үр дүнг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой болно хэмээн үзэж байна.

УЛСЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ДИПЛОМАТЫН АРГЫГ ХЭРЭГЛЭЖ ИРСЭН ТҮҮХЭН ТУРШЛАГА

Д.Жавхлант. Хилийн сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдлын тэнхимийн ахлах багш, докторант, дэд хурандаа



Хил хамгаалах мэргэжлийн цэрэг үүсэхээс өмнөх үе (1900-1933 он): Манжийн дагуур улс байх үед суман харуулаар хилийн овоо, хайчийн замын бүрэн бүтэн байдлыг хянах, хилийн зөрчлийг магадлан шийдвэрлэх, туршуул явуулах, хил залгаа улсын хилийн харуултай мэдээ солилцон хилийн уулзалт зохиох, тогтоосон боомт газраар зорчигч ачаа хөсгийг шалган нэвтрүүлэх, хязгаар нутгийн хүн ам, мал, амьтныг сэргийлэн хамгаалах зэрэг үүргийг гүйцэтгэдэг байсан.

Олноо Өргөгдсөн Монгол улсад 1921 онд ардын хувьсгал ялснаар 1924 онд Ардын Эрхт Бүгд Найрамдах Улс болсноо Үндсэн хуулиараа баталгаажуулж, зарлан тунхаглав.

Орчин үеийн хил хамгаалах мэргэжлийн цэрэг үүсэн байгуулагдсан үе /1933-1953 он/: Монгол Улсын Засгийн газар 1932 онд "Хил хязгаарыг хамгаалах явдал нь улсын ДХГ-ын эрхлэн гүйцэтгэвэл зохих хэрэг тул эл хэргийг улсын ДХГ-т шилжүүлбэл зохино" хэмээн зааж, эхний ээлжинд Увс, Ховд, Алтай, Өмнөговь аймгууд болон Дорноговь аймгийн баруун өмнө, Хангайн хязгаарыг /хойд хил/ бүрнээ хамгаалах явдлыг ДХГ 1933 оны 1-р сарын 1-ээс улсын хил хязгаарыг хамгаалах шинэ бүтэц, зохион байгуулалттай Хязгаарын Цэрэг байгуулагдах үндэс тавигдсан.

Хязгаарын цэргийг татан буулгасан үе /1953-1967 он/: Дэлхийн II дайны дараа энх тайвны хөдөлгөөн дэлхий дахинаа өрнөж, олон улс орон тусгаар тогтнож Монгол улс БНХАУ-тай дипломат харилцаа тогтоон 1952 онд эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах хэлэлцээ байгуулж найрамдалт харилцаа тогтсон нь хилийн аюулгүй байдалд эерэгээр нөлөөлсөн гэж үзээд 1953 онд Хязгаарын цэргийг татан

буулгасан. Өөрөөр хэлбэл БНМАУ-ын Засгийн газар энэхүү найрамдалт харилцаанд үндэслэн хилийн аюулгүй байдлыг цэргийн аргаар хангах ажиллагааг хязгаарлаж, хилийн асуудлыг улс төр-дипломатын аргаар зохицуулж байхаар шийдвэрлэсэн.

Ийнхүү энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр хоёр улсын найрамдалт харилцаа хөгжиж БНМАУ-ын ДЯЯ-ны сайд, ГЯЯ-ын сайд нарын 1953 оны 11 дүгээр сарын 24-ний 1196 тоот тушаалаар "СССР ба БНХАУ-тай хил нийлсэн БНМАУ-ын хилийн хэсгийн хилийн комиссор-төлөөлөгчөөс ямар нэг зөрчил будлианыг зөвөөр шийдвэрлэх талаар хийж гүйцэтгэх ажлын тухай түр заавар" батлан гаргасан нь хилийн аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангах анхны хууль ёсны эрхийн акт байсан.

Хязгаарын цэрэг дахин байгуулагдсаны дараах үе /1967 оноос одоог хүртэл/: Энэ үеэс Монголын төр, засаг хөрш хоёр улстай албан ёсоор хил тодорхойлон тогтоож, газар дээр нь тэмдэглэн гэрээ байгуулж баталгаажуулах, үүсэж буй улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан улсын хилийн хамгаалалтын нягтарлыг нэмэгдүүлэх, хүч хэрэгсэл, техникийн хангалтыг сайжруулах, хилийн зөрчил, маргааныг улс төр-дипломатын аргаар тайван замаар шийдвэрлэх зэргээр нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн болон хилийн аюулгүй байдлыг хангах, тусгаар тогтнолоо хамгаалах арга хэмжээг системтэйгээр авч хэрэгжүүлсэн байна. Үүний нэг илрэл нь ХЦ-ийг дахин байгуулсан явдал байсан.

Мөн эртний түүхтэй Монголын умард хилийг БНМАУ, ЗСБНХУ хоёр 1976 онд тодорхойлж, 1977-1979 онд газар дээр нь тогтоон тэмдэглэж гэрээ байгуулсан.

Ер нь хилийн аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангах арга хэмжээнүүдийн дотроос улсын хил тодорхойлж тогтоох нь хялбар ажил биш байдаг бөгөөд Алтай, Сийлхэм, Саян, Гурви, Үүдэн Зоо зэрэг ой тайгаар бүрхсэн их нуруунуудын, Дэлгэр мөрөн, Сэлэнгэ мөрөн, Зэлтэр, Цөх, Онон голуудын сав газрын ус, шавар, намаг, зам харилцаагүй газруудаар байгаа хилийн шугам, овоо тэмдгийг түүхийн үүднээс газар дээр нь олж судлах ажлыг 1970 оноос эхлэн хэсэг хэсгээр, голдуу өвлийн улиралд, өөр ажил, амралтын далимаар явуулж 2180 км хилийн шугам түүн дээр байвал зохих 87 овооноос 85-ыг газар дээр нь олж судалж, зохих материалуудыг эмхэтгэж, хилийн байдал, орон нутагт гарч байсан асуудлын талаар танилцуулах илтгэл, справкуудыг (лавлагаа) БНМАУ-ын гавьяат хуульч, шинжилэх ухааны доктор, Онц бөгөөд Бүрэн Эрхт элчин, дэслэгч генерал Б.Цэдэн-Иш үндсэндээ ганцаар боловсруулж 1974 онд бэлэн болгож Монголын умард хил тогтоох бэлтгэл ажлыг хангасан байна.

Ийнхүү 1980 он гэхэд БНМАУ, Таван Богд уулнаас Тарваган дахын овоо хүртэл хойд талаараа ЗСБНХУ-тай 3543км, өмнө талаараа БНХАУ-тай 4709.658 км албан ёсоор тогтсон хилтэй болсны нийт урт 8252.6 км байна.

Энэ нь Монгол улс хилийн аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангахад баримтлах гол ОУЭЗ-н акт болох хилийн дэглэмийн гэрээг хөрш хоёр улстайгаа байгуулан мөрдөж ажиллах өргөн боломжийг нээж өгсөн

ба БНМАУ БНХАУ-тай 1964 онд хилийн тухай протоколд гарын үсэг зурж, ЗСБНХУ-тай 1980 онд дэглэмийн гэрээ байгуулсан юм. Уг дэглэмийн гэрээгээр улсын хилийн тэмдэг, туслах чанарын тэмдэг, тэдгээрийн холбоос, хилийн шугамын таних тэмдэгүүдийг арчлан хамгаалах, тэдгээрийг хөдөлгөн шилжүүлэх, устгахаас сэргийлэх шаардлагатай арга хэмжээ авах, хэрэв гэмтсэн, үгүй болсон, эвдэрч хэмхэрсэн тохиолдолд хэн түрүүлж илрүүлсэн нь харилцан биендээ мэдэгдэж, өөрийнхөө хариуцсан тэмдэг, туслах тэмдэг, хилийн шугамын таних тэмдэгийг нөгөө талын хилийн ажилтаныг байлцуулан байранд нь тавих буюу тодорхой тогтоосон хугацааны дотор шийдвэрлэж дуусгах гэх мэтээр бусад, хилтэй зайлшгүй холбоотой бүх асуудлуудыг хамарсан ажиллагаануудыг бүгдийг тохирдог бөгөөд түүнийг хоёр талын хил хамгаалах байгууллагууд болон бусад холбогдох байгууллага, иргэд хатуу мөрдөж ажилладаг байна.

Тэрчлэн хоёр улсын Засгийн газрууд Хил орчмын дэглэмийн гэрээ, Улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай хэлэлцээрүүд байгуулан мөрдөж ажилладаг болсноор улс төр-дипломатын аргаар улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, хилийн болон хил орчмын дэглэм журмыг сахиулан ажиллаж хилийн аюулгүй байдлыг хангах хууль эрх зүйн баримт бичгүүдтэй болсон байна.

Мөн түнчлэн 1973 онд "БНМАУ-ын Хил хамгаалах хууль"-ийг анх удаа БНМАУ-ын Ардын Их Хурлаас батлан гаргаж, 1967 онд "Хил хамгаалалтын дүрэм" батлагдан 1984 онд хэсэгчилэн шинэчлэх зэргээр хил хамгаалалтын дотоодын эрх зүйн орчинг бүрдүүлж байсан.

Ийнхүү БНМАУ-ын нам, төр, засаг хилийн аюулгүй байдлыг улс төр дипломатын хангах үндсэн чиг хандлагыг тууштай баримталж иржээ.

Хилийн аюулгүй байдлыг хангах талаар хөрш орнуудын төрөөс баримтлаж буй дипломат бодлого

Монгол Улсын өмнөд хөрш БНХАУ-ын удирдлага дэлхийд тэргүүлэх зорилт тавьж байгаа. Үүний тулд дэлхийн хэмжээнд өөрийн ашиг сонирхлоо цэргийн хүчээр хамгаалах чадвартай болох төдийгүй 2050 он буюу зэвсэгт хүчнийг шинэчлэх сүүлчийн шатанд Хятад, цэргийн зохих чадавхтай дэлхийн их гүрний нэг болно гэж стратегийн зорилт дэвшүүлсэн улс.

Орос, Хятад улсад аль алинд нь Монгол үндэстний тодорхой хэсэг, өөрсдийн түүхэн газар нутаг үлджээ. ОХУ бол манай өнгөрсөн үеийн түүхийн хамгийн ойрын түнш байсан, Монгол Улсын түүхэнд хамгийн дотно итгэлийг төрүүлж байдаг хөрш гэхэд болно. Гэвч 2008 оноос ОХУ-ын гадаад бодлого түрэмгий шинжтэй боллоо гэж олон судлаачид үздэг. ОХУ-ын аюулгүй байдал, гадаад бодлого, цэргийн шинэ номлолд дайн хийх, цэрэг хөдөлгөх босгыг намсгаж, мөн цөмийн зэвсэг хэрэглэх боломжийг өндөр тавьсан хөрш болоод байна. Одоогоор ОХУ, БНХАУ-ын хооронд стратегийн түншийн харилцаа тогтоож байгаа боловч ОХУ-ын хувьд Монгол Улс Алс Дорнодын бүс нутгаас ирэх аюулаас сэргийлэх "бамбай" улсын үүргийг гүйцэтгэж байна.

Гэвч ОХУ, БНХАУ цөмийн зэвсэггүй бүс бий болгох тухай Монголын

саналыг дэмжих бөгөөд Монголын аюулгүй байдал нь, тусгаар хамгаалан бэхжүүлэхэд томхон хувь нэмэр оруулж байна. ШХАБ хэмжээнд Ташкентад байгуулсан "Хилийн аюулгүй байдлын хэлэлцээр" нь Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн нэрийн дор ОХУ-ын цэргийг Төв Азид оруулах боломж олгож байна Төв Азийн орон зайд өөрийн нөлөөгөө хадгалах гэсэн ОХУ-ын энэхүү бодлогын Монгол улс багтаж байгаа нь Гиополитика и безопасность сэтгүүлд нийтлэгдсэн "Орос Хятад хоёр Монголтой "Уян" аргаар нөлөөлөлдөө оруулахыг хичээж байна" нэртэй нийтлэлд тодорхой тэмдэглэгджээ. Монголын талаар явуулах бодлого ч тодорхой онцлогтойгоор хэрэгжихийг үгүйсгэх аргагүй байгаа юм.

ОХУ одоо хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан Төв Азийн улсуудыг "Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл ТУХН" нэрийн дор өөрийн нөлөөлөлдөө байлгаж байх бодлогыг явуулж байна. Төв Азийн орнуудад НАТО-ийн нөлөө бий болж бэхжихээс сэргийлэх улс төрийн арга хэмжээг байнга авч хэрэгжүүлж байна. Ийнхүү үүссэн улс төрийн нөхцөл байдал нь Монгол улсын хилийн аюулгүй байдлыг улс төр дипломатын аргаар хангах асуудал юм юмнаас чухал тавигдаж байгааг улам тод томруун харагдаж байна.

Ашигласан материал:

1.Хилийн цэргийн архив. Жагсаалтын дугаар 171. С-20

2. Монгол Улсын хил хамгаалалтын түүхэн тэмдэглэл.УБ.1994

3. Дэд хурандаа Д.Жавхлант 2014 он БХИС магистрын ажил "Улсын хилийг улс төр-дипломатын аргаар хамгаалж ирсэн түүхэн туршлага, боловсронгүй болгох арга зам".

ӨНӨӨГИЙН ДЭЛХИЙ ДАХИНЫГ ӨӨРЧИЛСӨН ЧИНГИС ХААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Н.Алтанзул. ХСИС-ийн ЭЗНУС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн багш, докторант, ахлах дэслэгч



Түлхүүр үг: даяаршил, шашин шүтлэг, цэргийн тактик, мэдээлэл дамжуулалт, дипломат, дипломат халдашгүй эрх

Оршил

Их эзэн Чингис хааны суу заль, мэргэн цэцэн ухааныг энэ үед амьдарч буй би гайхахын дээдээр гайхаж, бишрэхийн дээдээр бишрэн сууж байна. Учир нь тэр тухайн үеийн манлайлагч нь байж, хүний эрх болон шүтэх, эс шүтэх эрхийг энэ дэлхийд хамгийн анх зарласан нь түүний ёс суртахуун өндөр хэмжээнд байсан гэж хэлж болохоор байна. Түүний дараа 750 гаруй жилийн

дараа АНУ-ын Үндсэн хуульд хүний шүтэх, эс шүтэх эрхийг зарласан байдаг. Нэг үгээр хэлбэл, тухайн үеийн эрх чөлөөт улс нь Монгол улс байсан гэж хэлэхэд бараг хэлсдэхгүй.

XIII-XIV зууны тэр бие биенэ үл мэдэн орших улсуудыг холбож, худалдаа наймааг хөхүүлэн дэмжиж, байгаль орчноо хамгаалах зэрэг асуудлыг Их засаг хуулиндаа тусган зохицуулсан нь үнэхээр гайхалтай хэрэг юм. XIII-XIV зууны үед Чингис хааны эзэлж авсан болон түүний угсаа залгамжлагчдийн захирч байсан улс (Алтан ордны улс, Ил хаадын улс, Цагаадайн улс, Их Юань гүрэн)-ын газар нутагт худалдаа наймаа, мэдээлэл солилцох нь нээлттэй байсан. Их Монгол улсын нийслэл Хархорум хотод энд тэндхийн шашны (Христос, Лал, Будда, Бумба, Күнз) төлөөлөгчид ертөнцийн үнэн мөний талаар ном хаялцдаг байсан талаар Вильгельм Рубрук өөрийн үзсэн харсан зүйлээ хэлсэн боловч Өрнийн ард түмэн түүнд итгэлгүй худалч хэмээн доог дохуу хийж байжээ.

Чингис хаан ба даяаршлын үйл ажиллагаа

Ийм бахархал болсон хэрмийг байгуулсан ард түмэн аугаа их түүхтэй байж таарна. Аугаа их түүхтэй ард түмэн аугаа их ирээдүйтэй байж таарна. (Ричард М.Никсоны Хятадын цагаан хэрэм дээр хэлсэн үг)

Даяаршил гэдэг нь францаас гаралтай global буюу латины globus буюу бөмбөрцөг гэсэн утгатай үгээс гаралтай болно. Академич Т.Намжим *Даяаршилт: ойлголт, хандлага* номондоо "даяаршил" гэдэг нэр томъёог хэрэглээд энэ үзэгдлийн агуулга, мөн чанар нь дэлхий даяар эдийн засгийн нэгдмэл хэв загвар, харилцан хамаарал тогтох үйл явц мөн гэж дурдсан байна.

XIII-XIV зуун тэр чигээрээ Монголын зуун байсан юм. Урьд хожид огт дуулдаагүй үндэстэн гэнэт гарч ирэн хорвоог доргион чичрүүлж, дэлхийн хамгийн том эзэнт гүрнийг үлдээсэн билээ.

Нэгдсэн Үндэстний байгууллагын дүрэмд уг байгууллагын зорилтыг дараах байдлаар томъёолсон нь орчин үеийн даяаршлын гол шалгуур үзүүлэлтийг тусган харуулжээ. Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулах, энэ зорилгын үүднээс энх тайванд учрах аюул заналыг сэрэмжлэн зайлуулах, улс түмний тэгш эрх, өөртөө засан тохинох зарчмыг хүндэтгэсэн найрсаг харилцааг хөгжүүлэх, арьсны өнгө, хүйс, хэл, **шашин шүтлэгийг** үл харгалзан хүний эрх ба хэн бүхний үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг хөхүүлэн дэмжих олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх[1].

Эдгээр нийтлэг зорилтыг хэрэгжүүлэхэд улс үндэстнүүдийн нүүдлийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах төв болж байх явдал гэж үзсэн байна.

Үүнээс үзэхэд орчин үед төдийгүй XIII зууны үед ч дэлхий дахины энх тайван, аюулгүй байдлыг сахиулах, түүнчлэн бүх нийтийн энх тайвныг бэхжүүлэх, хүний эрх ба үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдал олон улсын харилцааны тулгамдсан асуудал, даяаршлын гол хандлага байсаар буйг харуулж байна. Эдгээрийг XX зуны сүүлч XXI зууны эхэн үеийн даяаршлын

[1] Заанхүү Ж.Чингис хааны засан тохинуулах үйл ажиллагаа ба даяаршлын асуудал.УБ.,2007. 152 дахь тал

агуулга гэж эрдэмтэд судлаачид үндсэндээ хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд энд санал бодлын зөрүү ялгаа тодийлөн байхгүй гэж хэлж болно.

Чингис хаан дэлхий дахины энх тайван, аюулгүй байдлыг хангах явдлыг өөрийн амьдралын зорилгоо болгож, түүний хийсэн аян дайныг уг зорилгодоо хүрэхийн төлөө хийсэн үйл ажиллагаа гэж үзэхээс аргагүй билээ. Энэ нь аль XIII зууны үе бөгөөд энэ өндөрлөгөөс үзэхэд түүний үед уг асуудлыг дайны замаар шийдвэрлэхээс өөр арга байгаагүй ба Чингис хааны амьдарлын гол зорилго уриа нь "худлыг үхүүлж, гэмтнийг гэсгээх явдал" байлаа.

Чингис хааны өмнө нь ч, түүний үед, дараа нь ч дэлхий дахинд даяаршлал гэсэн ойлголт байсан, харин түүнийг үнэлэх хэмжүүр, хэрэгжүүлэх түвшин өөр өөр байжээ. Бүхэлд нь Чингис хаанаас өмнөх үеийн даяаршлын агуулга нь дараах байдлаар илэрч байсан болно.

1. Хүн төрөлхтөн нэг нар дэлхийтэй гэж үзэж байсан боловч дэлхий бөөрөнхий, дэлхийн хаана, ямар улс орон байдаг талаар ойлголт байхгүй, улс орнуудын хил хязгаар бүрэлдэн тогтоогүй, дэлхийн хуурай газар бүхэлдээ нээгдээгүй, дэлхийн газар нутагт хүмүүс суурьших үйл явц үргэлжилж, тив хоорондын зам харилцааны сүлжээ бий болоогүй байв.

2. Улс орнууд төдийгүй дэлхий дахины хэмжээнд хүн амын аюулгүй байдал алхам тутам алдагдаж, айдас түгшүүрт нийгэмд амьдарч, хил хязгаараас давсан буюу улс хоорондын маргаантай асуудлыг ихэнхдээ цэрэг дайны замаар шийддэг хандлага ноёрхож байв.

3. Улс орнуудын гадаад харилцааг зохицуулах эрх зүйн орчин бүрдээгүй, улс төр дипломат бодлогын үндсэн зарчим, хэм хэмжээ төлөвшөөгүй бөгөөд улс орнуудад томилсон элч, төлөөлөгчдийн амь насанд халдах явдал хэвийн үзэгдэл байв.

4. Улс орнуудын хооронд тогтмол худалдаа хийдэггүй, худалдааг зөвхөн бараа солилцоогоор хийдэг, цаасан мөнгө нэвтрээгүй нь барааг зөөхөд ихээхэн хүндрэл учруулдаг, худалдаачдын амь нас, эд хөрөнгийн аюулгүй байдал хангагдаагүй, явах зам харгуй, бартаа бэрхшээлтэй, тэдэнд үзүүлэх үйлчилгээ дутмаг зэрэг олон асуудал шийдэгдээгүй байв.

5. Улс орнууд, ялангуяа суурьшмал орнуудын тухайд байгалийн тэнцвэртэй байдлыг хангах тухай асуудал төлөвшөөгүй, хүн төрөлхтний буруугаас бидний нэгдмэл гэр дэлхий хэзээ нэгэн цагт доройтол сүйрэлд учирна гэдгийг бүрэн ухамсарлаагүй байв.

6. Хүний эрх, нийгмийн баталгааг хангах эрх зүйн тодийгүй практик арга хэмжээ авах боломжгүйгээс хүмүүсийн харилцаанд "Хүчтэй нь хүчгүйгээ" гэсэн зарчим үйлчилж, ялангуяа суурин соёл иргэншилтэй бүс нутгуудад хүмүүсийг боолчох, боолын худалдаа сонгодог байдлаар ноёрхож, хүмүүст боолын сэтгэхүй төлөвших хандлага илэрч байв.

Чингис хааны эхлүүлсэн даяаршлын агуулга нь дээр дурдсан байдлыг *даван туулахад* чиглэгдэж өөрийн онцлогтой хэрэгжиж ирсэн.[2]

Чингис хаан аливаа шашинд хүлцэнгүй хандсан

[2] Заанхүү Ж. Чингис хааны засан тохинуулах үйл ажиллагаа ба даяаршлын асуудал. УБ, 2006. 157дахь тал